



ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА



The Asia Foundation



УУЛ
УУРХАЙН ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



The Asia Foundation

Швейцарийн Хөгжлийн Агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Уул уурхайн яамтай хамтран хэрэгжүүлж буй Азийн Сангийн “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь-II” төслийн хүрээнд энэхүү гарын авлагыг хэвлүүлэв.

“ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА”

/Төрийн албан хаагчдад зориулав/

Эмхэтгэсэн:

Пүрэвжавын Болормаа

*АНУ-ын Азийн сангийн Байгаль орчны хөтөлбөрийн
ахлах зөвлөх*

Зөвлөсөн:

Патрик Твомэй

Олон улсын хүний эрхийн сүлжээ байгууллагын захирал

Хянасан:

Намсрайн Баярсайхан

“Хил хязгааргүй алхам” ТББ-ын тэргүүн



Танилцуулга

“Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь -II” төслийг АНУ-ын Азийн сан Уул уурхайн яамтай хамтран Швейцарийн хөгжлийн агентлагийн \ШХА\ санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна. Уг төслийн зорилго нь Бичил уурхай эрхлэгчдийн орон нутгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэхийн сацуу эрүүл, аюулгүй орчинд амьдрах, зохистой ажлын байраар хангагдах эрхийг нь хангахад хувь нэмэр оруулахад оршино.

“Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь-II” төслийг хэрэгжүүлэх үндсэн арга барил бол Хүний эрхэд суурилсан хандлага \ХЭСХ\ бөгөөд энэ нь олон улсын хүний эрхийн стандартуудад түшиглэсэн, хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахад чиглэсэн хүний хөгжлийн үйл явцыг илэрхийлсэн үзэл баримтлалын тухай ойлголт юм.

ХЭСХ нь хүмүүс өөрсдийнх нь амьдралын хэв маяг, чанарт нөлөөлөх шийдвэр гаргахад нээлттэй, ач холбогдолтойгоор оролцдог байх боломжийг бүрдүүлэхийг зорино. Түүнчлэн “үүрэг хүлээгч” нар олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заагдсан хүний эрхийн стандартын дагуу “эрх агуулагч” нарын өмнө хүлээх ёстой үүргээ илүү сайн биелүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны үйл явц юм.

ХЭСХ-ыг төслийн хэрэгжилтэд тусгаснаар гарах ач холбогдол:

- **Олон улсын гэрээ хэлэлцээр, хууль тогтоомжийн хүрээнд:** зорилго, стандартууд нь дэлхийн хэмжээнд зөвшөөрөгдсөн бөгөөд Швейцарь, Монгол улс болон олон улсын хэмжээний хуулийн хүрээнд тодорхойлогдсон зарчмуудыг ажил хэрэг болгоход дэмжлэг болох;
- **Хүний эрхийг хангах зорилго нь тодорхой бөгөөд нээлттэй:** орон нутгийн хөгжлийн аливаа бодлого, хөтөлбөрүүд нь ХЭСХ-ын суурь зарчмуудыг хангасан байх бөгөөд түүний хэрэгжилт нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн байх боломжуудад дэмжлэг болох;
- **Шийдвэр гаргах эрх мэдэл:** урт хугацааны нөлөө бүхий шийдвэр гаргахад хүн бүрийн идэвхтэй, чөлөөтэй, утга учиртайгаар оролцох чадавхийг бэхжүүлэх;
- **Эрх тэгш байдал:** шударга ёс, эрх тэгш байдал, эрх чөлөөг эрхэмлэж, ядуурал, нийгмийн тэгш бус байдлын суурь шалтгаан болсон үүрэг хүлээгчдийн эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах байдлыг зогсоохыг шаарддаг. Мөн гадуурхагдсан бүлэгт хүрч ажиллах шаардлагыг хангах хандлагыг бий болгох;





- **Үр ашигтай, гарах үр нөлөө нь их:** хариуцлага тооцох, эрх мэдэл олгох, идэвхи зүтгэл гаргах асуудлуудад онцгой ач холбогдол өгөхөд нь дэмжлэг үзүүлэх;
- **Хариуцлага:** төрийн болон хандивлагч байгуулагууд, хувийн хэвшил, нутгийн иргэд, хувь хүмүүс харилцан биесийн өмнө хүлээх хариуцлагын хэм хэмжээг тодорхой болгож дээрхи зарчмуудыг хөгжлийн бүх оролцогч талууд даган мөрддөг болоход нь нөлөө үзүүлэх.

2005 онд Монгол улс засаглалыг сайжруулах явдал нь хүний хөгжлийг хангах, Мянганы хөгжлийн бүсэд 8 зорилгыг хэрэгжүүлэх урьтал нөхцөл мөн болохыг онцолж, ардчилсан засаглал, хүний эрхийг дэмжихэд чиглэсэн Мянганы хөгжлийн 9 дэх зорилтыг тодорхойлж баталсан дэлхийн анхны улс болсон. Энэ нэр хүнд бүхий томоохон амлалт, үйл ажиллагаа нь Монгол улсын төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах үлмаар төрийн бодлогыг хүний эрхэд суурилсан хандлагаар төлөвлөж хэрэгжүүлэх, үр дүн, үр нөлөөг хэмжих шалгуур нь иргэн бүрийн эрх, эрх чөлөө хэрхэн хангагдсанаар үнэлэгдэх хандлагын суурь, эхлэл болсон гэж үзэж болно.

Монгол улс уул уурхайд түшиглэн хөгжихийн тулд нэг үе гадны хөрөнгө оруулагчдыг татаж хайгуул, олборлолт хийлгэхийг нэн тэргүүнд тавьдаг байсан бол одоо тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн, ногоон ул мөр бүхий эдийн засгийг бий болгох, өнөө болоод ирээдүй үеийн хүмүүсийн эрх, эрх чөлөөний боломж, сонголтуудад саад хийхгүйгээр урагшлах шаардлагатай тулгараад байна. Үүний дагуу Засгийн газраас эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогыг гаргаж эрдэс баялгаа олборлохдоо хүний эрх, эрх чөлөөнд саад хийхгүй, тогтвортой хөгжлийг бий болгоход онцгойлон анхаарахаа илэрхийлсэн байна.

Энэ хүрээнд АНУ-ын Азийн сангаас «Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь-II» хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ үндэсний болон орон нутгийн түвшинд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн салбар, төр засаг, иргэний нийгмийн байгууллага, ард иргэдийг хамарсан цогц үйл ажиллагаа явуулах юм. Ингэхдээ Хүний эрхэд суурилсан хандлагын зарчмуудыг бодитойгоор мөрдөж, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн орон нутгийн түвшний хөгжлийн аливаа бодлого хөтөлбөр боловсруулан баталгаажуулах үлмаар хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх, ахиц дэвшил гаргахад нь талуудад шаардлагатай мэдлэг, үр чадвар олгох, чадавх бэхжүүлэхэд чиглэх юм.

Энэхүү гарын авлагын талаар уншигч та бүхэн санал сэтгэгдлээ бидэнтэй хуваалцахад таатай хүлээж авах болно.

И-мэйл: bolormaa.purevjav@asiafoundation.org



Удиртгал

Монгол улсын Үндсэн хуулийн 3-р зүйлийн 1-д “Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэнэ” гэж заасан нь иргэдийн шийдвэр гаргах үйл явцад оролцох эрхийг хуульчлан баталгаажуулсан байна.

Мянганы Хөгжлийн зорилтууд дахь Байгаль орчны тогтвортой хөгжлийг хангах, Ардчилсан засаглалыг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах зорилтуудыг хэрэгжүүлэхдээ иргэдийг шийдвэр гаргахад оролцуулах, хараа хяналт тогтоож, үнэлгээ хийхэд нь тасралтгүй чадваржуулах явдал нэн чухал юм.

Монгол оронд сүүлийн хорин жил байгалийн нөөцөд түшиглэсэн эдийн засгийн салбарууд эрчимтэй хөгжиж үйлдвэржилт, хотжилтын цар хүрээ тэлж тэр хэмжээгээр хүн амын амьдрах хүрээлэн буй орчныг жилээс жилд доройтуулж байна. Ялангуяа уул уурхайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны улмаас үүссэн хөрсний эвдрэл, газрын чанарын доройтол нь орон нутгийн иргэдийн амьдралын тогтсон хэв маягт эрс өөрчлөлт оруулах боллоо.

Уламжлалт мал аж ахуй, малын бэлчээр, хадлангийн талбай, ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнесийн талбай, хөдөөгийн тосгодод уул уурхайн хайгуул, ашиглалтын үйлдвэрлэл нь “хүсээгүй цоо шинэ ертөнц” болон айлсаж түүнтэй нутгийн иргэд “дасан зохицож, хүлцэн тэвчиж амьдрах”, эсвэл “дайжин нүүж төв бараадах”-аас аргагүйд хүргэж байна.

2014 оны 08 сарын байдлаар нийт нутаг дэвсгэрт 2798 тусгай зөвшөөрөл байгаагаас 40 гаруй хувь нь Ашиглалтын тусгай зөвшөөрөл байна. 2010 оны 10 сарын Уул уурхайн нөхөн сэргээлтийн талбайн тооллогоор эдэлбэрт өртөгдсөн нийт газрын тодорхой хувь нь нөхөн сэргээгдээгүй үлдсэн байна. Яагаад “эзэнгүй талбай” үлдэх болов? Энэ нь төрийн хяналт, компанийн нийгмийн хариуцлага, түүнд нутгийн иргэдийн хяналт, оролцоо болон хуулийн хэрэгжилт сул байгааг харуулж байна.

Иймд байгалийн нөөцийг хариуцлагатай ашиглах менежментийг хэрэгжүүлэхэд нутгийн иргэд, иргэний нийгмийн оролцоог үр дүнтэй нэмэгдүүлэх, оролцогч талуудын хамтын ажиллагаа, аман тохиролцоог хэлбэржүүлэн гэрээ хэлцэл



болгон тогтворжуулах шаардлага анхан шатны засаг захиргааны нэгжийн удирдлагын нэн тулгамдсан ажил болж байна.

Үүний тулд нэгдүгээрт: эрх ашиг нь зөрчигдөж буй иргэдийг бодлогын үйл явцад оролцох эрхийг хангах, хоёрдугаарт: бодлогын яриа хэлэлцээр, түншлэлийн үр нөлөө бүхий тодорхой механизмыг бий болгох, бэхжүүлэх шаардлагатай байна.

Хайгуулын болон ашиглалтын компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд уурхайн үйл ажиллагаа явуулахдаа нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэн үзэх зарчмаар иргэдийн оролцооны эрхийг хангах ёстой. Нөгөө талаас орон нутгийн засаг захиргааны байгууллага ардчилсан, сайн засаглалын хүрээнд иргэд, ИНБ-ыг хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэнд оролцуулж байж эрхүүдийг хангах нөхцлүүд бүрдэх юм.



Товчилсон үг

АСЕАН	Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг
БОНХАЖЯ	Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
ГХЯ	Гадаад хэргийн яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕЗ	Европийн зөвлөл
ИБУТЭТОУП	Иргэний болон үлс төрийн эрхийн тухай олон улсын пакт
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИБУТЭ	Иргэний болон үлс төрийн эрх
КНХ	Компаний нийгмийн хариуцлага
МУ	Монгол үлс
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОУ	Олон үлс
ОУХБ	Олон үлсын хөдөлмөрийн байгууллага
ОУСБ	Олон үлсын санхүүгийн байгууллага
ОНБ	Олон нийтийн байгууллага
ОНХС	Орон нутгийг хөгжүүлэх сан
ӨАА	Өрхийн аж ахуй
СХЗГ	Стандартчилал, хэмжил зүйн газар
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын их хурал
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ХАЁТ	Хөгжлийн албан ёсны зээл түслэмж
ХЭДКГ	Хүний эрхийн дээд комиссарын газар
ХЭСХ	Хүний эрхэд суурилсан хандлага
ХЭҮЭЧ	Хүний эрх, үндсэн эрх чөлөөний тухай Европын конвенци
ХЭҮЭЧТЕК	Хүний эрх, үндсэн эрх чөлөөний тухай Европын конвенци
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЭТТ	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
ЭЗНСЭТОУП	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг



Энэ гарын авлага ямар зорилготой вэ?

Хүний эрхэд суурилсан хандлага хэмээх энэхүү гарын авлага нь төрөөс баримталж буй урт, дунд, богино хугацааны аливаа хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд болон хөгжлийн албан ёсны зээл тусламжаар хэрэгжиж буй төслүүдийг хэрэгжүүлэхэд хүний эрхэд суурилсан хандлагыг нэвтрүүлэх шаардлага, үзэл баримтлалыг танилцуулах зорилготой юм.

Энэ гарын авлага хэнд зориулагдсан бэ?

“Хүний эрхэд суурилсан хандлага” тус гарын авлага нь хөгжлийн бодлогуудыг тогтвортой хөгжлийн чиг хандлага, үзэл санаанд нийцүүлэн хэрэгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэж байгаа бүхий л шатны төрийн албан хаагчид, шийдвэр гаргагчдад зориулагдсан болно. Мөн хөгжлийн оролцогч талууд болох бичил болон том уурхайн бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн байгууллагуудын ажилтнууд, олон нийт, нутгийн иргэд ч хэрэглэж болно. Уг гарын авлага нь хүний эрх, эрхэд суурилсан хандлагын талаар мэдлэг ойлголтыг сайжруулахад чиглэсэн үндсэн агуулгыг багтаасан болно.



Агуулга

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ ТҮҮНИЙГ ХАНГАХ ҮҮРЭГ	13
1.1 Хүний эрхийн үндсэн ойлголт	15
1.2 Хүний эрхийн төрөл, ангилал	16
1.3 Хүний жам ёсны эрх түүний ангилал	21
1.4 Хүний эрхийн үндсэн зарчмууд	22
1.5 Хүний эрхийн дэвшилтэт хэрэгжүүлэлт	27
1.6 Хүний эрхийг биелүүлэх төрийн үүрэг	28
1.7 Хүний эрхийг биелүүлэх бизнесийн үүрэг	32
1.8 Хувь хүний эрх, эрх чөлөө ба хариуцлага	36
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА, ТҮҮНИЙ ЗАРЧМУУД	39
2.1 Хүний эрхийг хангах олон улсын болон үндэсний тогтолцоо	41
2.2 Хүний эрхэд суурилсан хандлага, түүнийг үйл хэрэг болгох шаардлага ...	42
• Хүний эрхэд суурилсан хандлагын зарчмууд:	
o Олон улсын хүний эрхийн тогтолцоо, стандартыг мөрдөн хэрэгжүүлэх	48
o Эрх мэдэл олгох буюу эрх мэдэлжүүлэх	49
o Эрх мэдэлжүүлэх замаар утга учиртай, үр дүнтэй оролцоог хангах	49
o Үл ялгаварлах болон эмзэг бүлэгт түлхүү ач холбогдол өгөх зарчим	50
o Хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх зарчим	50
2.3 ХЭСХ-ыг хэрэгжүүлэхэд тулгарч болох бэрхшээлүүд	51





2.4 ХЭСХ-ыг нэвтрүүлэхийн ач холбогдол	53
2.5. ХЭСХ-ыг хэрэглээ болгох нь	55

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БА

ХҮНИЙ ЭРХ	65
3.1 Тогтвортой хөгжлийг эрхэд суурилсан хандлагаар хэрэгжүүлэх нь	67
3.2 Оролцогч талуудын хамтын ажиллагаа	82
3.3 Жендэрийн эрх тэгш байдал	85

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. УЛС ОРНУУДАД ХҮНИЙ ЭРХИЙН ХАРИУЦЛАГА

ХҮЛЭЭЛГЭХ МЕХАНИЗМУУД	87
4.1. Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)	89
4.2 Хүний эрхийн тухай олон улсын гэрээ	89
4.3 Хүний эрхийн хяналтын байгууллагууд	90
4.4 Гарын үсэг, баталгаажуулалт ба нэмэлт тайлбар	90
4.5 НҮБ-ын хүний эрхийн хяналтын бүтэц болон хүний эрхийн зөвлөл	91
4.6 Бүс нутгийн хүний эрхийн арга хэрэгсэлүүд	92
4.7 ХАЁТ-ийн хүний эрх, эрх чөлөөг хангах олон улсын эв санааны зарчим ..	93
4.7.1 Парисын тунхаглал түүний зарчмууд	95
4.8 Швейцарь улсын олон улсын хамтын ажиллагааны зарчим	96
4.9 Дотоодын хууль дахь хүний эрхийн хамгаалал	98



БҮЛЭГ

1

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ
ТҮҮНИЙГ ХАНГАХ ҮҮРЭГ





1.1 Хүний эрхийн тухай үндсэн ойлголт

Хүний эрх нь арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, нийгэмд эзлэх байр суурь, нас хүйс, улс төрийн үзэл бодлын ялгаатай байдлыг үл харгалзан хүн төрөлхтөний гишүүний хувиар хүн бүрт **эрх тэгш заяагдсан** өгөгдөл юм.

Өөрөөр хэлбэл хүн бүр төрөхөөсөө эрх чөлөө, нэр төртэй, эрхийнхээ хувьд адил, ижил үнэ цэнэтэй. Хүн бүр амьд явах, өөрийн давамгайлал, онцлог байдлаа хадгалах; нандин чанараа мэдрэн хэнээс ч хамааралгүй, хараат бусаар эрх чөлөөтэй, нэр төр, үнэ цэнэтэйгээр амьдрах; амьдралаа хүссэнээрээ шийдэх; үүний тулд сонголт хийх боломжийг өөртөө агуулж төрдөг. Эдгээр нь зөвхөн хувь хүнд өөрт нь заяагддаг, өөрийг нь тодорхойлогч өвөрмөц, давамгайлал шинж юм.

Энэ нь аливаа нэгэн төр, шашин, хууль, засаглалын ямар нэг тогтолцооноос олгогддог буюу зөвшөөрөгддөг бус, хүн болсных нь хувьд өөрөөс нь урган гардаг, зөвхөн хүнд заяагддаг төрөлх чанарыг илэрхийлсэн ухагдахуун юм.

Гэхдээ хүний эрх гэдэг нь ямар нэг давуу эрх, онцгой ямбыг илэрхийлдэггүй. Аз жаргалтай, сайхан амьдрахад зайлшгүй шаардлагатай наад захын стандарт юм.

ХҮНИЙ ЭРХ НЬ:

- хүнд угаас заяагдсан, өөрт нь байдаг төрөлх чанарыг илэрхийлсэн;
- хүн ёсоор амьдрахад зайлшгүй шаардагдах наад захын стандарт;
- хүн болж төрснийх нь хувьд байгалиас заяагдсан өгөгдөл бөгөөд түүнийг харин олон улсын болон үндэсний түвшинд баталгаажуулах, хамгаалах үүргийг төр, байгууллага, хамт олон, хүмүүст хүлээлгэдэг.

Хүн төрөлхтөн 1948 онд хүний эрх, эрх чөлөөг олон улсын түвшинд Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (ХЭТТ) хэмээх баримт бичгээр баталгаажуулсан. ХЭТТ нь эдийн засгийн, улс төрийн, иргэний, нийгэм, соёлын бүх төрлийн эрхүүд нь ижил тэгш хүчинтэй, чухал ач холбогдолтой болохыг тодорхой болгосон түүхэн баримт бичиг юм. Гэхдээ энэ нь хүний сайн сайхан амьдрах наад захын

хэм хэмжээг стандарт болгон зааж байгаа болохоос тэмүүлж буй алсын зорилт, мөрөөдөл биш.

Хүний эрхийн олон улсын энэхүү баримт бичиг нь бүхий л засгийн газруудын ард түмнийхээ өмнө болоод харилцан биесийнхээ өмнө хүний эрх, эрх чөлөөг хангах





талаар хүлээн зөвшөөрсөн үүрэг хариуцлагыг баталгаажуулсан баримт бичиг юм. Ийнхүү улс орон бүрийн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ нь норматив хүрээ, нийтлэг зорилт болж, хөгжлийн бодлого хөтөлбөр, тусламжийн үр дүн, практик ач холбогдлыг үнэлэх суурь хэмжүүр нь болсон.

Хүний эрхийн судлагдахуун нь философи, ёс суртахуун, эрх зүйн гэх мэт олон салбар шинжлэх ухааны огтлолцол дунд орших ойлголт юм. 1256 онд хүний эрхийн тухай хамгийн анх Английн парламент албан ёсоор цаасан дээр буулгаж баталгаажуулсан байдаг. Тэр үеэс хүний эрх гэдэг асуудал яригдаж эхэлжээ. Одоогийн бидний ярьж буй хүний эрхийн ойлголт нь 1700-аад оны үеийн томъёоллын нилээд хожмын хэлбэр. Тиймээс хүний эрх бол 300 гаруй жилийн настай нэр томъёо хэдий ч бүрэн гүйцэт судлагдаагүй бас төгс боловсроогүй шинжлэх ухаан байсаар байна.

1.2 Хүний эрхийн төрөл, ангилал

Хүний эрхийг агуулга, чиглэлээс нь шалтгаалан дараах таван төрөлд хувааж үздэг. Үүнд:

1. Иргэний болон улс төрийн эрх (“Нэгдүгээр үеийн эрх” гэж нэрлэх нь бий). Эдгээр эрх нь эрх чөлөөг хангах, баталгаажуулахад чиглэсэн.
2. Эдийн засгийн болон нийгмийн эрх (“Хоёрдугаар үеийн эрх” гэж нэрлэх нь бий). Эдгээр эрх нь аюулгүй байдлыг хангахад чиглэсэн.
3. Хүрээлэн буй орчны, соёлын, хөгжлийн эрх (“Гуравдугаар үеийн эрх” гэж нэрлэх нь бий). Эдгээр эрхүүдэд эрүүл цэвэр, аюулгүй хүрээлэн буй орчинд амьдрах эрх, соёл, улс төр, эдийн засгийн хөгжлийн эрх зэрэг хамаарна.



Гэвч хүн бүр хүний эрхийг эдлэхийн хамт бусад хүмүүсийн хүний эрхийг хүндэтгэх үүрэг хүлээдэг.

Хүний эрхийн үндсэн таван төрөл бүрийг нарийвчлан доорх хүснэгтэд харуулахдаа ХЭТТ –д заагдсан 30 зүйл эрх, Үндсэн хуулиар заасан 18 зүйл эрхүүдэд үндэслэн төрөлжүүлээ.¹

¹ Бусад улс орнуудын туршлагаас харахад цаашид хөгжлийн явцад шинэ эрхүүд байнга үүсэн гардаг байна



ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДСЭН ТАВАН ТӨРӨЛ

 ИРГЭНИЙ ЭРХ:	 УЛС ТӨРИЙН ЭРХ:	 ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ	 НИЙГМИЙН ЭРХ	 СОЁЛЫН ЭРХ
Амьд явах, эрх чөлөөтэй байх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгаль орчны тэнцэл алдагдахаас хамгаалуулах, боолчлолоос ангид байх, нэр төрөө хамгаалуулах, эрхгүйн чадвартай байх, эрүү шүүлтээс ангид байх, хүн бүр хуулийн өмнө адил тэгш байх, зөрчигдсөн эрхээ бүрэн сэргээх, халдашгүй байх эрх, шударга шүүхээр шүүлэх эрх, өөрөө өөрийгөө өмгөөлөх өмгөөлүүлэх, иргэний харьяалалтай байх, шашин шүтэх эс шүтэх, сайн дурын үндсэн дээр гэрлэх, өрх тусгаарлах, үр удмаа үлдээх, өлсгөлөнгөөс ангид байх, усаар хангагдах, сүрч боловсрох, түр буюу байнга оршин суух газраа сонгох эрхүүдийг багтаан ойлгоно.	Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх, иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байх, төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрх, мөрдөлт мөшгөлтөөс зугтаж өөр орноос орогнол хүсэх, үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, сонгох сонгогдох, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх, гомдол гаргах, үг хэлэх эрхүүдийг багтаан ойлгоно.	Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, эд хөрөнгө дангаар буюу бусадтай өмчлөх, хувийн аж ахуй эрхлэх, хөдөлмөрлөх, ажилгүйдлээс хамгаалуулах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, адил хэмжээний хөдөлмөрд адил хэмжээний хөлс авах, хувийн болон ам бүлийнхээ ахуй амжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц, хийсэндээ таарсан, хүрэлцэхүйц шан хөлс авах, эрх ашгаа хамгаалах үйлдвэрчний эвлэл байгуулах түүнд нэгдэх, ажил хаях, өмчлөх, өв залгамжлах залгамжлуулах, хөдлөх үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах эрхүүдийг багтаан ойлгоно.	Улсынхаа дотор чөлөөтэй зорчих, нийгмийн хангамж эдлэх, эд мөнгөний түслалцаа авах, нэр төрөө хадгалах, хөгжих, эрүүл мэндээ хамгаалуулах, аялах, эрүүл мэндийн үйлчилгээ авах, өвчтөний эрх, ажлын цагаа зохистойгоор хязгаарлуулж амрах, цалинтай ээлжийн амралт эдлэх эрхийг оролцуулан амрах зав чөлөөтэй байх эрхүүдийг багтаан ойлгоно.	Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх, өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах, хэвлэн нийтлэх, үлэмжлалт соёлоо өвлөх, хадгалах, хөгжүүлэх, хамгаалуулах эрхүүдийг багтаан ойлгоно.

Хүний эрхийг дээрх үндсэн таван төрөлд хуваан тухайн эрх бүрийн хэрэгжилтийг засгийн газрууд тодорхой шаталсан хугацаанд НҮБ-ын хороодод тайлагнаж зөвлөмж авч түүнийг хэрэгжүүлэх амлалт үүрэг авдаг хэдий ч иргэний болон улс төрийн



эрхийг НҮБ-ын ИБУТЭТОУП (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт) гэсэн баримт бичигт хамтад нь авч үздэг. Мөн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг НҮБ-ын ЭЗНСЭТОУП (Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт) баримт бичигт нэгтгэн авч үздэг.



“Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хэн боловч хувийн болон ам бүлийнхээ ахуй амьжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц бөгөөд зайлшгүй тохиолдолд нийгмийн хангамжийн эх үүсвэрээр нэмэн арвижуулсан, хийсэндээ таарсан, хүртээмжтэй шан хөлс авах эрхтэй”

ХЭТТ. 23.3 заалт

“Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй. Ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, эсхүл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэй”.

ХЭТТ.25.1 заалт

ХЭТТ-ын энэхүү хоёр заалт нь ажилтай орлоготой байх эдийн засгийн эрх, хоол хүнстэй байж амьд байх иргэний эрх, шаардлагатай үед нийгмийн халамж авах нийгмийн хамгааллын эрхийг хамтад нь заасан байгаагаас харж болно.

МУ-ын Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний эдийн засаг, нийгэм, соёлын үндсэн эрхийг дараах байдлаар харуулъя.

Эдийн засаг, нийгэм, соёлын үндсэн эрх	
1. Ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох (16.4)	6. Эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, (16.2)
2. Амрах (16.4)	7. Эрүүл мэндээ хамгаалуулах...(16.6)
3. Цалин хөлс авах (16.4)	8. Соёл, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах (16.8)
4. Сурч боловсрох (16.7)	9. Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэр бүл, эх няхлас, хүүхдийн ашиг сонирхолыг төр хамгаална (16.11)
5. Бүтээл түүрвих (16.8)	10. Бүтээл түүрвиж үр шимийг хүртэх(16.8)

Энд заагдсан эрхүүдийг бүлэглэн үзвэл 1-5 буюу эхний багана бүхэлдээ эдийн засгийн, 6-9-д дугаарласан нь амь биеийн аюулгүй байдлын буюу иргэний болон нийгмийн, 9-10 нь улс төр, нийгэм, соёлын эрхийг баталгаажуулсан байна.



НҮБ-ын ИБУТЭТОУП түүний нэмэлт протоколд нэгдсэн улс орнууд нь 4 жил тутамд хэрэгжилтийн тайланг гаргаж НҮБ-ын ИБУТЭ-ийн хороонд хүргүүлдэг бол ЭЗНСЭТОУП-ын хэрэгжилтийг 5 жил тутамд НҮБ-ын ЭЗНС-ын хороонд хүргүүлэх үүрэгтэй байдаг. МУ-ын Засгийн газар нь ЭЗНСЭТП-ын хэрэгжилтийн тайлангаа 2012 оны 11 сард хүргүүлсэн бөгөөд НҮБ-ын ЭЗНС-ын хороо 2014 оны 12 сарын 01 өдөр авч хэлэлцэх юм. Харин Монголын Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд (ТББ)-ын Иргэний нийгмийн форум нь ЭЗНСЭТП-ын хэрэгжилтийн сүүдэр илтгэл буюу хараат бус, хөндлөнгийн илтгэл боловсруулж мөн НҮБ-ын хороодод илгээдэг. Энэ мэтчилэн хүний эрхийн пактуудын хэрэгжилтийн тайлагнал нь өөр өөрийн тогтолцоотой.

Монгол улс нь НҮБ-ын ХЭТТ болон ЭЗНСЭТОУП, ИБУТЭТОУП-ын үзэл санаа, зарчмыг багтаан тусгасан байх олон улсын өмнө хүлээсэн үүргийн дагуу Үндсэн хуулиа боловсруулсан ба 1992 оны шинэ Үндсэн хууль нь ардчилсан хүмүүнлэг нийгэм байгуулах үзэл баримтлал бүхий ард түмний эрх, эрх чөлөөг бүрнээ эдлүүлэхээ илэрхийлсэн баримт бичиг мөн. Тус Үндсэн хуулийн 14; 15; 16-р бүлгүүд бүхэлдээ хүний эрх, эрх чөлөөг хангах заалтууд бөгөөд түүний 16.14-р заалт нь илүү иргэний болон улс төрийн эрхийн тухай юм.



Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;

Үндсэн хууль.16-р зүйлийн 14 заалт.

Тухайлбал, шүүхэд гомдол гаргах, хохирлыг нөхөн төлүүлэх, гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх зэрэг нь иргэний эрх, гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно гэдэг нь улс төрийн эрхтэй холбоотой. Ийнхүү хүний эрхүүд нь хуваагдашгүй, харилцан хамааралтай, салшгүй, түгээмэл байх чанараар нь дэлхий нийтээрээ





хүлээн зөвшөөрч Эдийн Засаг Нийгэм Соёлын болон Иргэний болон Улс төрийн гэсэн үндсэн хоёр бүлэгт хуваан үздэг байна.

Харин хүний эрхийг байр сууринаас нь шалтгаалан үндсэн хоёр ангилалд авч үздэг. Үүнд:

- **Туйлын буюу цөм** эрх нь ямар ч нөхцөл байдалд саад болох боломжгүй, хасагдах эсвэл түдгэлзүүлж болшгүй эрхүүд юм. Эдгээрт амьдявах, өлсгөлөнгөөс ангид байх, эрүү шүүлт болон боолчлогдохоос ангид байх эрхүүд багтана. Тиймээс энэхүү эрхийг зөрчсөн харьцааг зөвтгөх ямар ч үндэслэл байхгүй юм;
- **Хязгаарлагдмал** эрх ба тодорхой нөхцөлд, тодорхой хугацаанд төрийн хязгаарлалтанд хамаарах эрх юм. Өөрөөр хэлбэл, Хязгаарлагдмал эрх гэдэг нь олон улсын хуулиар тодорхой хэмжээ, хугацаатайгаар хязгаарлагдаж болох зөвшөөрөгдсөн эрх бөгөөд зарим тохиолдолд нийгмийн сайн сайхны төлөө хязгаарлагдах эрх юм. Жишээлбэл, Тамхи татах нь хувь хүний эрх хэдий ч нийтийн эрх ашгийг хамгаалах үүднээс олон нийтийн газар энэ эрх нь хязгаарлагдах юм.



Нэмж хэлэхэд, зарим хязгаарлагдмал эрхийг бууруулж болдог. Тухайлбал, дайны үед эсвэл олон нийтийн тодорхой онц байдлын үед түдгэлзүүлдэг эрх юм. Үүнд магадгүй баривчлагдан байцаагдах хугацааг уртасгах орж болно. Эдгээр хязгаарлалт нь хэн нэгэн дураараа гаргасан шийдвэр байж болохгүй ба заавал **хуулиар зохицуулагдсан, хуулийн үндэслэлтэй, эрхээ хязгаарлуулж буй хүмүүст танилцуулагдсан байна.**

Энэ талаар МУ-ын үндсэн хуулийн 19.2-т:



Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.

заасан нь хүний туйлын буюу цөм эрхийг ямар ч тохиолдолд хязгаарлаж болохгүй гэдгийг баталгаажуулж хамгаалсан байна.



1.3 Хүний жам ёсны эрх түүний ангилал

Хүний жам ёсны эрх, эрх чөлөө нь үг хэлэх, сүсэг бишрэлтэй байх, оршин амьдрах газраа сонгох, сурч боловсрох эрх зэрэг ордогийг дээр дурьдсан. Жам ёсны эрхийг эрх болон эрх чөлөө гэж ангилах буюу ялгаатай авч үзэх ч энэ хоёр ойлголт нь харилцан нягт шүтэлцээтэй юм.

ЭРХ

гэдэг нь хүнийг төрөхтэй хамт өгөгдсөн өгөгдөл. Энэ утгаараа заавал эдлэгдэх ёстой эрх.

ЭРХ ЧӨЛӨӨ

гэдэг нь хүний эрхээ эдлэх ёстой боломж нь юм. Тухайлбал, төрийн эрх баригчид нь иргэнийнхээ үг хэлэх, шашин шүтэх, шийдвэр гаргахад оролцох, хөгжих эрхэд хөндлөнгөөс оролцохгүй байснаар эдгээр эрх чөлөө хэрэгжинэ.

Жишээлбэл, улс төрийн эрх, эрх чөлөөний харилцан шүтэлцээг Үндсэн хуулиар баталгаажуулсан эрхүүдийн хүрээнд тайлбарлая.

Улс төрийн эрх, эрх чөлөөний харилцан шүтэлцээ	
Үндсэн ЭРХ – төрөлхийн ӨГӨГДӨЛ	ЭРХ ЧӨЛӨӨ - эрхээ эдлэх БОЛОМЖ
Төрийн удирдах хэрэгт оролцох(16.9)	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх(16.16)
Сонгох, сонгогдох(16.9)	Үг хэлэх(16.16)
Эвлэлдэн нэгдэх, нам, ОНБ байгуулах(16.10)	Хэвлэн нийтлэх (16.16)
Өргөдөл гомдол гаргах, шаардах(16.12)	Жагсаал цуглаан хийх(16.16)
Шударга шүүхээр хамгаалуулах (16.14)	Мэдээлэл хайх, хүлээн авах (16.17)

Эрх чөлөөний хувьд үүрэг хүлээгчид нь эс үйлдэх үүрэг хүлээнэ. Иймд иргэнд эрх хэдий байлаа ч төр нь эрх чөлөөг хангаагүйгээр, эрх чөлөөгүйгээр хүн ямар нэгэн эрх эдэлж, үүрэг хүлээх боломжгүй гэсэн үг юм.

ХЭТТ-ын 29 зүйлд заасан эрхийн дагуу МУ-ын Үндсэн хууль нь хүний эрх, эрх чөлөөг аль болох багтаахыг хичээж 18 зүйл эрх болгон оруулсан байдаг. Гэвч, дээр хэлсэнчлэн хүний эрх нь нийгмийн хөгжил, даяарчлалын явцад шинэчлэгдэж шинэ эрхүүд, шинэ нэр томъёо үүсч байна. Тиймээс тухай бүр Үндсэн хуульдаа нэмэлт оруулах замаар баталгаажуулж байх шаардлагатай. Тухайлбал өнөөдрийн хүчин төгөлдөр Үндсэн хуулинд хүнсний эрх, иргэдийн оролцооны эрх, хөгжих эрх, төрд хариуцлага тооцох эрх, эрх чөлөөг дурьдаагүй байгаагаас харж болно.



1.4 Хүний эрхийн үндсэн зарчмууд

Дэлхий дээр хамгийн өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн баримт бичиг бол Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (ХЭТТ) мөн. ХЭТТ-ийг Нэгдсэн Үндэстний Байгууллага ямар ч татгалзсан гишүүний саналгүйгээр (8 улс түдгэлзсэн) 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан байна.

Тунхаглалд үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн байдал, шашин шүтлэг, үзэл бодол, хөрөнгө чинээ, бусад нөхцөл байдал хамаарахгүйгээр дэлхий дээр амьдарч буй бүх хүмүүс эдлэх үндсэн эрхүүдийг жагсаан бичсэн билээ. Засгийн газрууд өөрийн улсын иргэдээс гадна бусад улсын иргэдийн эрхийг мөн адил дэмжихээ баталсан. Өөрөөр хэлбэл, аливаа улсын хил нь хүн эрхээ эдлэхэд хаалт болохгүй гэсэн үг. 1948 оноос хойш ХЭТТ нь хүний эрхийн олон улсын стандарт болсон бөгөөд 1993 онд болсон Дэлхийн хэмжээний хуралд оролцогч 171 улс буюу дэлхийн хүн амын 99 хувийн төлөөлөл ХЭТТ-ыг хэрэгжүүлэхээ дахин баталсан байдаг.

ХЭТТ-д тулгуурласан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСЭТОУП)-д хүний эрхийн зарчмуудыг албан ёсоор тусгасан. Үүнээс гадна ХЭТТ-д тулгуурласан Хүний болон хүмүүсийн эрхийн тухай Африкийн харти, Хүний эрхийн Европын конвенци, Хүний эрхийн Америкийн конвенци зэрэг бүс нутгийн хүний эрхийн баримт бичгүүдэд ч хүний эрхийг биелүүлэх зарчмуудыг тодорхой заасан байдаг.

Дээрх ХЭТТ болон бусад хүний эрхийн баримт бичгүүдэд тусгаснаар олон улсын хүний эрхийн хүрээнд хэрэглэдэг нийтлэг үндсэн зарчмууд нь:

1 Тэгш байдлыг хангах зарчим:

Хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнэтэй байж, эрхийн хүндэтгэлийг адил эдлэх тухай ойлголтыг илэрхийлдэг. “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна.” хэмээн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 1-р зүйлд онцлон заасан нь хүний эрх адил тэгш байх суурь зарчим юм.





2 Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим:

Тэгш байдлын үзэл баримтлалтай салшгүй холбоотой. Энэ нь гадны зарим хүчин зүйлсэд тулгуурлан хүний эрхийн хамгааллыг хэн ч няцаахгүй байх явдлыг хангана. Угсаа гарал, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, өмч хөрөнгө, төрсөн байдал болон бусад статусаас үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй. ОУ-ын гэрээ, конвенцид тодорхойлогдсон дээрх шалгуурууд нь зөвхөн жишээ тул бусад үндэслэлээр ялгаварлан гадуурхаж болно гэсэн утга санааг агуулахгүй. Тухайлбал, жолооны үнэмлэхийг эмэгтэйчүүд болон хөдөөний хүмүүст олгохгүй гэвэл энэ нь гарцаагүй алагчлал болох юм. Харин хараагүй хүмүүсийг болон хүүхдийг жолоо барихыг хориглох заалт нь бодит үндэслэлтэй учир алагчлал болохгүй.




3 Түгээмэл байх зарчим:

Дэлхийн бүх л үндэстэн, уугуул иргэд, орон нутгийн оршин суугчид, хамт олон бүрт өөр өөрийн зан заншил, уламжлал, ёс зүйн үнэт зүйлс байдаг. Энэ нь зөвхөн тухайн хүрээндээ дагаж мөрддөг зүйл бөгөөд энэ зарчмыг хүлээн зөвшөөрөх хийгээд ертөнцийн өнцөг, булан бүрт амьдарч байгаа бүх л хүмүүсийг хүнийх нь хувьд ижил авч үзэх зарчим юм.



4. Хүний үнэ цэнэ, нэр төрийг дээдлэх зарчим:

Бүх хүмүүс хүн болж төрснийхөө хувьд ижил үнэлэгдэж, адил хүндлэл хүлээнэ гэдгийг баталгаажуулдаг. Бүх хүн нас хүйс, хэл соёл, угсаа гарал, арьс өнгө, бэлгийн чиг баримжаа, боломж чадвар, нийгэмд эзлэх байр суурь, иргэний харъяалал болон улс төрийн үзэл бодлоос үл хамааран ижил хүндлэл хүлээнэ. Хүний эрхийн талаарх ойлголтын үндсэн санаа нь хүний нэр төр буюу эрхэм чанартай салшгүй холбоотой.





Хүний эрхэм чанар нь хүн байх, хүмүүнлэг орших мөн чанараас үүдэлтэй. Тухайлбал, дөнгөж төрсөн ямар ч гэм нүгэлгүй нялх хүүхэд, бас хорвоогийн хамгийн аймшигт гэмт хэрэгтэн ч хүн гэдгээрээ адил. Өөр нэг зүйл нь хүний нэр төр эрхэм чанар нь хүний алдар нэр буюу түүнтэй төсөөтэй нэр хүндээс тэс өөр ойлголт юм. Алдар нэр, нэр хүндийг хүн болж төрөөд хийсэн сайн шударга үйлсээр олж авах буюу муу муухай үйлдлээрээ эргүүлэн алдаж болдог. Хүний эрхийн хувьд тэрнээс өмнө хүн болж төрсний хувьд оноогдсон хүний эрхэм чанар илүү онцгой бөгөөд үнэ цэнэтэй юм.

5 **Хуваагдашгүй байх зарчим:**

Хүний эрх нь хуваагдашгүй ба иргэний, нийгмийн, эдийн засгийн, соёлын болон улс төрийн, бүлгийн эрхийг хамтад нь авч үзэх ёстой. Хүний эрхийн хуваагдашгүй, харилцан хамааралтай байх зарчим нь нэг эрх нөгөөгөөсөө салангид бус ихэнхдээ нэг нэгнээсээ хамаарч оршдог гэсэн үг юм. Жишээлбэл: эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь амьд явах эрх чөлөө, хүнсний эрх хэрэгжихтэй, эрүүл хангалттай тэжээллэг хүнстэй байх эрх хангагдах нь сурч боловсрох эрх улмаар эрч хүчтэйгээр эрүүл саруул сэтгэж эх орныхоо бүтээн байгуулалтад үр дүнтэй оролцох эрхийг хангах гэх мэт харилцан хамааралтай байдаг. Эдийн засгийн эрх хангагдах нь хүний орон байртай, ажил орлоготой байх эрх хэрэгжихэд дэмжлэг үзүүлэх ойлголт юм.



6 **Харилцан хамааралтай байх зарчим:**

Хүний эрхүүд хуваагдашгүй, нэгдмэл байдаг тул нэг эрх зөрчигдсөнөөр бусад эрх мөн хязгаарлагддаг. Үүнтэй адил аль нэг талбарт хүний эрхийг хангах нь хүний бусад эрхийг хангахад мөн дэмжлэг болж байдаг. Хүний эрх нь орон гэр, сургууль, ажлын байр, гудамж талбай зэрэг хаана ч тэр цаг ямагт, газар бүрт, нийгмийн бүхий л харилцаанд биелэгдэж байх учиртай.





7. Салшгүй байх зарчим:

Хувь хүнээс салгаж үл болох эрхийг дэмжих тухай ойлголт юм. Нэг этгээд өөр нэг хүнийг өөрийн гэр бүл болгохоор хүчээр зөвшөөрүүлэх эсвэл боол болгохоор өөрөөр нь эрх чөлөөнөөс нь татгалзуулж баримт бичиг дээр гарын үсэг зуруулах нь байж болохгүй асуудал. Харин хувь хүн өмчлөх эрхээсээ татгалзаж болно. Өмч эзэмшигч нь үл хөдлөх хөрөнгө эзэмших эрхээ хязгаарлах нь чөлөөтэй бөгөөд энэ нь салшгүй эрх биш юм.



8. Хариуцлага тооцох зарчим:

а) **Төр, засагтай хариуцлага тооцох:** Хүний эрхийг төр, засгаас бэлэглээгүй, өгөөгүй, олгоогүй. Төр, засаг нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах, ахиц гаргахаас татгалзах, эсвэл хэсэг хүмүүсийн эрхийг хүндэтгэж, хамгаалж, хангаад бусдынх нь эрхийг хүндэтгэж, хамгаалахаас татгалзах ёсгүй.



б) **Хувь хүнтэй хариуцлага тооцох:** Хувь хүн бүр эрхээ эдлэх, хүний эрхийг хүндэтгэх, аливаа хувь хүн, институцээс хүний эрхийг зөрчсөн тохиолдолд эрхээ хангуулахаар шаардах, хариуцлага хүлээлгэх эрхтэй.

в) **Бусад этгээдтэй хариуцлага тооцох:** Корпорациуд, ТББ-ууд, сангууд болон төрийнг бусад институцүүд зэрэг нийгэм дэх байгууллага бүр хүний эрхийг хамгаалах, хангах үүрэг, хариуцлагыг хүлээн байдаг.



НҮБ-ын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос: Засгийн газрууд нь “ус, агаар болон хөрсийг олборлох болон бусад салбарын үйлдвэрүүд бохирдуулахыг хориглосон хуулийг батлахгүй, мөрдүүлэхгүй байх нь” эрүүл мэндийн эрхийг зөрчиж буй хэрэг хэмээн онцолжээ.

Энэ нь хүмүүсийн амьд явах эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, газарт түшиглэсэн өрхийн амжиргааг хамгаалах, аюулгүй хоол хүнсээр хангагдах эрхийг



биелүүлэх, эдгээр эрхүүд болон эрх чөлөө зөрчигдөхөөс хамгаалж сэргийлсэн эрх зүйн хамгаалалт бий болгох үүргийн заалт юм.

Мөн хүний эрх нийгмийн хөгжлийн явц, даяарчлалтай холбоотойгоор байнга өөрчлөгддөг байна. Өөрөөр хэлбэл, нийгэм хөгжиж өөрчлөгдөхийн хэрээр хүний эрх мөн өөрчлөгдөн шинэчлэгдэж, хүний эрхийн шинэ нэр томъёо гарч байдаг. Тухайлбал, манай улсын хувьд эрдэс баялгийн үйлдвэрлэл хөгжөөгүй, эрчимтэй явагдаж эхлээгүй байх үед байгаль орчны буюу ногоон эрх, нутгийн иргэд, соёлын өвийг тээгч малчдын эрх, өрхийн бизнес амжиргааны эрх, газрын өмчийн эзний эрх зэрэг эрхүүд нийгэмд яригддаггүй байлаа.

Тэр ч бүү хэл Монгол Улс ЭЗНСЭТОУП-д нэгдэн иргэдээ өлсгөлөнгөөс ангид байлгах үүрэг хүлээсэн хэдий ч хүн амын 40 шахам хувь нь ядууралтай байхад ч эдийн засгийн эрх, өлсгөлөнгөөс ангид байх эрхийн зөрчлийн талаар холбож авч үздэггүй байсан бөгөөд Мянганы хөгжлийн зорилтод ядуурлыг бууруулах зорилт оруулснаар л сая, эдийн засгийн эрхийн зөрчил бол ядуу байхад хамааралтай гэдгийг хүлээн зөвшөөрч байх жишээтэй.

Түүнтэй адил эрдэс баялгийн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байгаатай холбоотой байгаль орчныг хамгаалах нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангахад шууд холбогдож байна. Байгаль орчны доройтол нь амьд явах эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, шаардлага хангасан хоол хүнс, цэвэр усаар хангагдах эрхүүдэд шууд сөрөг нөлөө үзүүлж байна. Тэглээ гээд ганц нэг төрийн албан хаагчид хариуцлага тооцоод тухайн хуулийн этгээдэд эсвэл тухайн шийдвэрийг гаргасан улс төрийн албан хаагчдад хариуцлага тооцох тогтолцоо өнөөдөр манайд байхгүй байна.

Харин Япон улсад бизнесийн үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчин бохирдуулсан, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд зөрчил учруулсан компаний эсрэг нэхэмжлэл гаргах “Хамтын нийгэмлэгийн тогтолцоо” гэж байдаг бол барууны орнуудад тухайн хуулийн этгээдэд маш өндөр торгууль ногдуулах, цаашлаад татан буулгаж нийтэд зарлах хүртэл арга хэмжээ байдаг байна.

Иргэдийн ялангуяа нутгийн иргэд, нутгийн хамт олон өөрийн нутаг дэвсгэр дээр хэрэгжих аливаа төслийн талаар мэдээлэл авах, мэдээлэл дээр үндэслэн хэлэлцүүлэгт мэтгэлцэх, байр сууриа илэрхийлэх, байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад оролцох, хэрэв тухайн төсөл хэрэгжсэнээр эрүүл, аюулгүй орчинд



амьдрах эрх, эрх чөлөө зөрчигдсөн тохиолдолд шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулсан ОУ-ын баримт бичиг байдаг.

Энэ нь Дани улсын Аархус хотноо 1998 оны 06 сарын 25-ны өдөр батласан “Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах талаарх Аархусын конвенц”² юм.



“Хүн бүрийн болон хойч үеийнхнийхээ эрүүл мэнд, сайн сайхан орчинд амьдрах эрхийг нь хамгаалахад хувь нэмрээ оруулахын тулд Конвенцийн Гишүүн улс бүр энэхүү Конвенцийн зүйл заалтуудын дагуу байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах эрхийг нь баталгаажуулна.”

Аархусын конвенци. 1-р зүйл.

Монгол улс энэхүү ач холбогдолтой конвенцид нэгдэх талаар бэлтгэл ажил хийж иргэний нийгмийн байгууллагууд уриалж, янз бүрийн түвшинд хэд хэдэн удаагийн зөвлөлдөх үүлзалтууд хийсэн бөгөөд энэ талаар Ерөнхийлөгчийн тамгын газраас эхлээд БОНХАЖЯ, ГХЯ дээр ч ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

1.5 Хүний эрхийн дэвшилтэт хэрэгжүүлэлт

Зарим эрх (жишээлбэл: эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж зэрэг) нь нөөцүүдийн хязгаарлагдмал байдлаас болоод улс орнуудад саад сорилтыг бий болгож болох юм. Үүнийг эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай Гэрээ хэлцэлийн 2(1) заалт дээр “Энэхүү Гэрээ хэлцэлд оролцогч улс бүр дангаараа болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар, түхйлбал эдийн засаг, техникийн салбарт, энэхүү Гэрээ хэлцлээр хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилтэтгээр хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, зохистой арга хэмжээг байгаа бүх боломжийнхоо хэрээр авах үүрэгтэй” гэж заасан.

ЭЗНСЭТП-с өөр зарчмууд талуудыг “өөрийн нутаг дэвсгэр дээр байгаа болон өөрийн хуулинд захирагдах хувь хүмүүсийг” энэхүү конвенцийн эрхийг хүндлэн дагах үүргийг хүлээлгэдэг. Гэсэн ч “дэвшилтэт хэрэгжүүлэлт” гэдэг энэхүү концеп заримдаа буруу ойлгогдох тохиолдол бий. Жишээ нь: нийгэм эдийн засгийн эрх нь шууд үүрэг хариуцлага оноодоггүй гэсэн үг биш (заримдаа буруугаар тааварладаг).

² www.chrd.mongolnet.mn Хүний эрх хөгжил төвийн орчуулга. 2011 он.





“Алхам хийх” шаардлага нь эрх зөрчигдсөн үед хэрэгжүүлэх шууд шуурхай болон үргэлжилсэн үүрэг хариуцлагыг хүлээлгэдэг. Энэ нь мөн тэрхүү зорилгод саад болох санаатай арга хэмжээ авахыг хориглодог. Эдийн засаг, нийгэм соёлын хороо энэхүү зарчмыг дор хаяж бүх эрхүүдийн хамгийн бага үндсэн чухал түвшинг хангаж чадахаар тогтоосон “хамгийн бага үндсэн үүрэг” хэмээн тайлбарласан. Дараа нь шууд хариуцлага бол эдгээр эрхүүдийн дэвшилтэт хэрэгжүүлэлтийг ялгаварлахгүй байх үүрэг хариуцлага юм.

Тэгэхээр гол үүрэг хариуцлага нь (ихэнхдээ хөтөлбөр, тайлан зэрэгт тодорхой тусгагддаггүй) энэхүү ангилалд хамаарах эрхийг хэрэгжүүлэхийн тулд **байгаа бүх боломжит нөөцийнхөө хэрээр арга хэмжээ авах** үйл явц юм. Энэхүү шаардлага нь төсөвт шийдвэр гаргалт болон эрэмбэ дарааллын тухай практик уруу хөтөлсөн бөгөөд төр энэхүү хуулийн шаардлагыг биелүүлж буй эсэхэд хяналт хийх хэрэгсэл болдог.

Дэвшилтэт хэрэгжүүлэлтийн концепцийн зөрүүг улс орнуудад багасгаж өгдөг өөр нэг шаардлага бол олон улсын хуулийн буцалтгүйн зарчим юм. Энэхүү зарчим нь **аль хэдийн хүлээж авсан болон хүрсэн стандартууд өөрчлөгдөж** болохгүйг шаарддаг.

Нийгэм эдийн засгийн эрхийн агуулга дахь нэмэлт үүрэг хариуцлага болон хөгжил нь олон улсын хамтын нийгэмлэгүүдийн улс орнуудыг өөрсдийн хүний нөөцийн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд туслахыг шаарддаг.

Энэхүү үүрэг хариуцлагын судалгаа нь “хөгжих эрх”-ийн концепци бий болоход зарим талаар нөлөөлсөн. Энэхүү үүрэг хариуцлага нь бусад улс орнуудыг хүний эрхийн үүргээ биелүүлэхэд туслах юм. Тэр нь улс орнууд бусад улсуудыг зохих тусламжийн нөхцөл зэргээр өөрсдийн үүрэг хариуцлагаа биелүүлэх боломжгүй болтол шахаж дарамталж болохгүй гэсэн үг.

1.6 Хүний эрхийг биелүүлэх төрийн үүрэг буюу төр үүрэг хүлээгч болох нь

Монгол улс НҮБ-ын гишүүнээр 1961 онд элсэн орсноор Засгийн газар нь ХЭТТ түүний хоёр үндсэн пакт болох ЭЗНСЭТОУП мөн ИБУТЭТОУП-д заасан хүний эрх, эрх чөлөөг хангах заалтуудыг биелүүлэх, сахин мөрдөх үүрэг хариуцлагыг хүлээсэн юм.



Тухайлбал, иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, зохистой ажлын байраар хангагдах улмаар хөдөлмөр хийснээр орон байр, хоол хүнс бусад хэрэглээгээ хангахуйц орлоготой байх, нийгмийн сайн сайханд өөрийн хувь нэмрийг оруулахад оролцох эрх, эрх чөлөөг эдлэх бололцоог дэмжсэн бүхий л таатай орчныг ТӨР бий болгох үүргийг хүлээсэн.

Улс орнуудын Засгийн газар нь аливаа хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөхөөс идэвхитэй хамгаалах, эрх, эрх чөлөөг нь хангах үйл ажиллагаа явуулахгүй бол хүний эрх, эрх чөлөөг зөвхөн ОУ-ын түвшинд хүлээн зөвшөөрөх нь тийм ч ач холбогдолтой биш юм.



Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах нь төрөөс биелүүлэх зайлшгүй үүрэг болохыг ойлгохын өмнө ТӨР-ийг яах гэж, хэн бий болгодог вэ? Төр ямар үүрэгтэй вэ? Хэнээс ямар даалгавартай ажиллаж байгаа талаар тогтож ярилцах нь зүйтэй юм.

Хүй нэгдлийн үед хувь хүн бүр өөр өөрийн аюулгүй байдлыг хангах нөхцөлд хүмүүсийн амьдрал маш эрсдэлтэй байсан. Удалгүй ураг төрлөөрөө нэгдэн, овог аймгууд нэг нэгнээ хамгаалж, цаашид аймгууд нэгдэн орших болсон билээ. Ингэснээр хүн бүр зэвсэг барьж явахад болин, хөдөлмөрийн хуваарьт шилжсэнээр хувийн аж ахуйгаа эрхлэх үед аюулгүй байдлыг хангах, овог аймгаа эрсдлээс хамгаалж чадах этгээдийг сонгох үеэс төр бий болсон гэж үзэж болно.

Гэхдээ энэхүү гарын авлагаар төр хэзээ үүссэн асуудлаар биш харин төрийн үүргийн талаар илүү авч үзнэ. Учир нь өнөөг болтол төрийн тухай нэг мөр ойлголт бий болоогүй, тогтсон тодорхойлолтгүй янз бүрийн байр сууринаас томъёологддог. Харин төр ямар үүрэгтэй, юуны төлөө ажилладаг талаар олон судлаач, онол дэвшүүлэгчид ерөнхийдөө нэгдсэн байр суурьт хүрсэн төдийгүй бид үүнийг л гүн гүнзгий ойлгож мэдэх хэрэгцээтэй тул төрийн үүргийн талаар илүү авч үзнэ.

Энгийн ойлголтоор хүмүүс бид өөрийн жам ёсны эрх, эрх чөлөөндөө тулгуурлан өөрсдийн амьдралын сайн сайхны тулд нэгдэн нийлж төр улсыг бий болгож, эрх мэдлийг тодорхой бүлэгт шилжүүлснээр төрийг ажиллуулдаг. Тодруулбал, ард түмэн



өөрт байгаа эрх, эрх чөлөөгөө аюулгүй эдлэхийн тулд өөрсдийгөө хамгаалуулах эрх мэдлийг л төрд өгсөн. Монгол улсын хувьд, иргэд төрд өөрийгөө төлөөлөх хүмүүст сонгуулиар санал өгч дөрвөн жилийн хугацаатай томилон ажиллуулдаг. Төр, засгийн үүргээ, үйл ажиллагаагаа явуулах боломжийг хангахын тулд иргэд





өөрсдийн зарим эрхийг сайн дүрээр хасч, төр засагт шилжүүлдэг. Тухайлбал, иргэд татвар төлж, шаардлагатай тохиолдолд цэргийн албанд явах, байгаль орчныг хамгаалахыг журамт үүргээ болгон зөвшөөрсөн байдаг.

Тэгэхээр төр гэдэг нь ард түмний засгийн газар юм. Төр бол ард түмний даалгавраар тэднийг амгалан тайван, айх аюулгүй, ажилтай, орлоготой, орон гэртэй байлгах, хүн бүрийн эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх үүрэг хүлээн ажиллаж буй байгууллага (институц) юм.



Ард түмний засгийн газар гэдэг нь ард түмний төлөө, ард түмнээс бүрдүүлсэн зүйл юм.

Абрахам Линкол

Монгол улс шинэ Үндсэн хуулиар ардчилсан хүмүүнлэг нийгмийг цогцлоон байгуулахаа тунхагласан бөгөөд дэлхий нийт ардчилсан орон, ардчиллын замаар хөгжиж буй, хүний эрх, эрх чөлөөнд ээлтэй орон гэж үнэлдэг. Тэгвэл ардчилсан оронд эрх мэдэл гэдэг бол ард түмэнд байдаг зүйл. Ард түмэн үзэл бодол, итгэл үнэмшил, хүсэл зориггоо хэрэгжүүлэх шийдвэр, түүний үйлд бодитой оролцох, эрх, эрх чөлөөгөө бүрэн эдлэх боломж нөхцлийг үүрэг хүлээгчдээс шаардаж хангуулах эрх мэдэлтэй байх ойлголт юм. Иймээс төр нь эн тэргүүнд өөрийн улсын нутаг дэвсгэр дээрх хүмүүсийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах чиг үүрэгтэй.





Төрийн энэхүү гурван чиг үүргийг тодруулбал:

Эрхийг хүндэтгэх үүрэг:	Эрхийг хамгаалах үүрэг:	Эрхийг хангах үүрэг:
Хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, төр өөрөө иргэдийнхээ эрхээ эдлэхэд нь ямарваа нэгэн хууль бус саад учруулахгүй, зөрчихгүй байх ойлголт. Төрийн зүгээс хүмүүсийн эрхээ эдлэх гэсэн үйлдлийг хязгаарлах, хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулж болохгүй (жишээлбэл, эрүүдэн шүүх, хууль бусаар баривчлах, хүчээр нүүлгэх буюу төлбөрийн чадваргүй хүмүүст төлбөртэй эмнэлгийн үйлчилгээ санал болгох, улс эд хөрөнгийг нь хүчээр хураахаас татгалзах, сонгох эсвэл эвлэлдэн нэгдэх эрхийг нь дүр зоргоороо хорихгүй байх гэх мэт)	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд эрхийг нь сэргээж, хохирлыг арилгах хууль тогтоомж бүрдүүлэх, бүтэц, тогтолцоог бий болгох ойлголт	Хүмүүс эрх, эрх чөлөөгөө эдлэх нөхцөл бололцоо, сонголтуудыг төр дээшлүүлэх, сайжруулах эерэг алхмуудыг ахиц дэвшил гаргасан байдлаар тасралтгүй авах тухай ойлголт. Хангах үүрэг нь хамгаалах хэрэглүүрийг багтаасан өргөн агуулгатай ойлголт юм. Энэхүү үүрэг нь хөнгөвчлөх; (төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, шат дамжлагыг багасгах) болон хөхиүлэн дэмжих; (мэдээллээр хангах, утга учиртай оролцоог дэмжих), хэрэгжүүлэх; (эмзэг бүлгийг эн тэргүүнд анхаарч, тэгш байдлыг бүрдүүлэхэд чиглэх) чиглэгддэг

Дээрх гурван чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ТӨР нь олон улсын хүний эрхийн нийтлэг зарчмуудыг баримтлахаас гадна дараах зарчмуудыг баримтлана³. Үүнд:

-  **Хүрэлцээтэй байх зарчим:** Төрийн үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар хуульчлах, тухайн байгууллагын барилга байгууламж, тоног төхөөрөмж, ширээ сандал, ариун цэврийн өрөө, ундны цэвэр ус, мэргэжлийн боловсон хүчин, тэдний боломжийн цалин хөлс зэрэг асуудлыг шийдсэн байна.
-  **Хүртээмжтэй байх зарчим:** Ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүйгээр үйлчлэх, аливаа нэгэн үйл ажиллагаанд хүн бүрт тэгш оролцох боломж олгосон байна.
-  **Хүлээн зөвшөөрөгдсөн байх зарчим:** Төрийн зүгээс шаардлагатай дүрэм журмыг ойлгомжтой байдлаар тогтоох, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх, төрийн үйлчилгээ авах боломжийг орчны болон мэдээлэл авах бололцоотой түвшинд бүрдүүлсэн байх зэрэг асуудлыг хамарна.
-  **Цаг үетэйгээ зохицсон байх зарчим:** Төрийн бодлого, үйлчилгээ нь нийгмийн өөрчлөлт, хөдөлгөөнд таарч зохицсон байна. Эмзэг бүлгийн хувьд тэдний хэрэгцээнд нийцсэн байхаас гадна тухайн үйлчилгээгээр дамжин бусад эрхүүдийг дэмжсэн байх зарчмууд байна.

³ Хүний эрх эмхтгэл. 196-р тал. ХЗҮК. 2014 он





Иргэд засаг төрийг эрх олж авахын тулд байгуулдаггүй, харин өөрийн эрх, эрх чөлөөгөө хамгаалуулахын тулд байгуулдаг гэдгийг дээр тодорхой тайлбарласан. Тиймээс хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах нь засаг төрийн зөвхөн халамж анхаарлын буюу сайн санааны үйлс огтхон ч биш, **харин үндсэн үүрэг нь юм.**

Албан болон албан бус судалгааны дүнгээр Монгол улсын нийт иргэдийн 29-40 хувь нь буюу нэг сая орчим хүн ядуу буюу амьдралын баталгаажих түвшингөөс доогуур амьдарч байна. Мөн төдий хэмжээний хүн ам ядуурлын түвшинд ороход бэлэн байна гэсэн тооцоо байна. Монголын ард түмний ядуурч, ядуурал өсөж байгаагийн гол шалтгаан юу вэ? Буруутан нь хэн бэ? Монголчуудыг ядууруулсан хариуцлагыг хэн хүлээх вэ? Монголын ард түмний ядуурсан шалтгаан нь ард түмэн өөрсдийн арчаагүй байдал уу? Эсвэл ард түмнийг амгалан тайван, айх аюулгүй, ажилтай, орлоготой, орон гэртэй байлгах бүх бололцоог хангаж өгөхийн тулд ажиллах ёстой төр нь үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаа болохоор ард түмэн ядуурч байна уу?

Тэгэхээр ард түмэн төр ямар байх ёстой, ямар үүрэг даалгавар өгч эрх мэдэл, үүрэг хариуцлага даалгаснаа байнга сануулж, шаардаж байх эрхтэй. Үүнээс гадна ардчилсан хүмүүнлэг нийгмийг цогцлоон байгуулах орны иргэд нь өөрсдийн өнөө үеийн эрх, эрх чөлөө болон ирээдүй үеийн эрх ашиг хөндөгдөх аливаа асуудалд бүтээлчээр оролцох чадвартай байх нь ардчиллыг бэхжүүлэхэд онцгой ач холбогдолтой.

1.7 Хүний эрхийг биелүүлэх, сэргээх бизнесийн үүрэг

Монгол улсад ардчилсан нийгэм, чөлөөт эдийн засгийн тогтолцоо бий болсноор иргэд аж ахуйн нэгж байгуулах, бусад хэлбэрээр хамтран ажиллах таатай орчин бүрдсэн. Мөн үндэстэн дамнасан томоохон корпораци, группүүд манай улсад бүхий л салбарт, ялангуяа уул уурхай, барилга, дэд бүтцийн салбарт өргөн хүрээнд ажиллах боллоо. Өөрөөр хэлбэл, улсын болон хувийн салбар холилдсон холимог эдийн засагтай болж байна.



Монгол улсын төрөөс сүүлийн жилүүдэд өөрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд, компани корпорациудад шилжүүлэх явдал ихээхэн гарч байна. Тухайлбал, менежментийн хувьчлалаар нийтийн тээврийн үйлчилгээг хувьд шилжүүлж, Концессийн гэрээгээр зам, барилга бариулах ажлыг хувийн хэвслээр



гүйцэтгүүлэхдээ ард түмний татвараас бүрдсэн төсвийн хөрөнгөөс санхүүжүүлдэг. Энэ нь төр өөрийн чиг үүрэг, хариуцлагаа хувийн хэвшил, бизнесийн байгууллагад шилжүүлж байгаа бол, хувийн хэвшлийн салбар ард түмний татварын хөрөнгөөр бизнес хийхдээ хүний эрх, эрх чөлөөг хангах төрийн үүргийг зайлшгүй хариуцах үүргийг шилжүүлж авч буй хэрэг юм.

Энгийн жишээ дурдвал, хүнийг тодорхой ажил, албан тушаалд шалгаруулж авахдаа нас хүйс, арьс өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлан гадуурхахгүй байх; хүнсний болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нь худалдан авагчийн амь нас, эрүүл мэндийг эн тэргүүнд тавьж, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх; уул уурхай, ашигт малтмал, эрчим хүч, барилга гэх мэт үйлдвэрлэлийн улмаас үүссэн хог хаягдлыг хүрээлэн буй орчин, байгальд сөрөг нөлөө үзүүлэхээргүй нөхцөлд устгах; байгаль орчныг бохирдуулагч ашиглагч нь илүү төлөх, нөхөн сэргээх зэрэг бизнесийн бүх төрлийн үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө хөндөгдөж байдаг учир хүний эрүүл мэнд, нийтийн эрх ашгийг хохироохгүй, аюулгүй байлгахын тулд байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөг заавал бууруулах, арилгах үүрэгтэй.

Хүний эрхийг хүндэтгэх чиглэлээр бизнесийн байгууллагуудын дагаж мөрдөх олон улсын гэрээ, конвенц, баримт бичиг олноор батлагдсан байдаг. Тэднээс “Даян Дэлхийн гэрээ”⁴/2002/, “Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчим”⁵ /2011/-ыг дурьдаж болно.

Компаний нийгмийн хариуцлагын чиглэлээр бий болсон дэлхийг хамарсан хамгийн том, сайн дурын хөдөлгөөн болох “Даян Дэлхийн гэрээ”-г НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга асан Коффи Аннан анх санаачилж, тус гэрээнд одоогоор 135 улс орны 5300 гаруй компани, байгууллагууд нэгдсэнээс гадна 90 оронд Даян Дэлхийн Гэрээний орон нутгийн сүлжээ байгуулагдан / Global Compact Local Network/ үйл ажиллагаагаа явуулж байна.

Уг гэрээнд нэгдлээ гээд эрх зүйн болон санхүүгийн ямар нэг үүрэг, хариуцлага хүлээдэггүй. Харин хүний эрх, эрх чөлөө, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчин, авлигын эсрэг гэсэн дөрвөн суурь харилцаанд үндэслэсэн 10 зарчмыг үйл ажиллагаандаа баримталж ажиллах үүрэг хариуцлагыг хүлээн авсан байдаг.

⁴ - Даян дэлхийн гэрээ 2002 он.

⁵ - НҮБ-ын Хамгаал, Хүндэл, Эрхийг Сэргээ хэмээх бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим” 2011.06.16-ны өдөр НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл





Мөн Олон Улсын Стандартчиллын Байгууллага (ОУСБ)-аас Компаний нийгмийн хариуцлагын ISO26000 стандартыг боловсруулан гаргасныг Монгол улсын Стандартчилал, хэмжил зүйн газар (СХЗГ) 2011 онд орчуулж MNS ISO 26000:2012 стандарт болгож баталсан байна⁶. Энэхүү Компаний нийгмийн хариуцлагын стандарт нь долоон үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй зөвлөмж болгосон стандарт шаардлага юм.

Бизнесийн байгууллагуудын сайн дураар даган мөрдөх Даян дэлхийн гэрээний 10 зарчим, MNS ISO 26000:2012 стандартын долоон бүрэлдэхүүн хэсгийг дор харьцуулан харъя.

Даян дэлхийн гэрээний 10 зарчим:	MNS ISO 26000:2012 стандартын 7 бүрэлдэхүүн хэсэг:
1. Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах олон улсын тунхаглалуудыг дэмжин хүндэтгэх 2. Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг аливаа хэлбэрээр зөрчихгүй байх 3. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээр байгуулах эрхийг үр ашигтайгаар хүлээн зөвшөөрөх 4. Хүчээр болон албадан хөдөлмөрлүүлэх аливаа хэлбэрийг арилгах 5. Хүүхдийн хөдөлмөрийг арилгах 6. Хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлийн хүрээнд ялгаварлан гадуурхах явдлыг арилгах 7. Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны өөрчлөлт, доройтлоос урьдчилан сэргийлэх 8. Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны хариуцлагыг өндөржүүлэх 9. Байгаль орчинд ээлтэй технологийг хөгжүүлэх нэвтрүүлэх 10. Авлига, хээл хахуулийн бүх хэлбэрийн эсрэг түүштай ажиллах	1. Байгууллагын дотоод сайн засаглал 2. Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх 3. Хөдөлмөрлөх эрхийг хангах 4. Хүрээлэн буй орчинд ээлтэй байх 5. Шударга ёсыг хангах 6. Хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрх, эрх чөлөөг хангах 7. Нийгмийн харилцаа, хөгжилд үр нөлөөтэй байх

Бизнесийн байгууллагууд өөрсдийн гаргасан дээрх баримт бичгүүдийн аль алинд дурьдсан үүрэг хариуцлагын стандарт шаардлагаас харахад хүний эрхийг дээдэлж, эрх чөлөөг хангах үүрэг, хариуцлагыг өөриймшүүлж хүлээж авчээ. Нөгөөтэйгүүр шударга ёсны үүднээс үзэхэд ч нийтийн өмчийг ашиглаж бизнес эрхэлж ашиг хүртэж байгаа байгууллага, хувь хүн бүр нийтийн эрх ашиг, хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах төрийн чиг үүргийг ямар нэг тайлбаргүйгээр хамтран биелүүлэхээ хүлээн зөвшөөрсөн байдаг байна.

⁶ - Нийгмийн хариуцлагын стандарт



Үндэстэн дамнасан корпораци зэрэг төрийн бус оролцогчдын хувьд аливаа улс орны хөгжлийн гол тоглогчид хэмээн ойлгогддог. 2011 оны 6 сард НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс НҮБ-ын “Хамгаал, Хүндэл, Сэргээ”-г хэрэгжүүлэхийн тулд бизнес болон хүний эрхийн баримтлах зарчмыг баталсан⁷ ба энэ нь бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хүний эрхэд нөлөөлөх сөрөг нөлөөллийн эрсдэлд анхаарлаа хандуулах болон урьдчилан сэргийлэх дэлхий нийтийн стандарт болсон юм. Мөн засгийн газар хоорондын байгууллагууд өөрсдийн зарим бүрэн эрхээ биенесийн байгууллагуудад шилжүүлэн олгож буйгаа ч илэрхийлсэн байдаг.

Тухайлбал, эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бичил болон том уурхайн компаниуд нь хүний эрх, эрх чөлөөг хангахад онцгой үүрэгтэй бөгөөд ямар нэг байдлаар татгалзах, түдгэлзэх эсвэл хариу тайлбар хийх эрх байхгүй юм. Ялангуяа иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хамгаалах, хүндлэх, сэргээх үүрэг хариуцлагыг хүлээсэн байдаг.

Хүрээлэн буй орчин гэдэг нь: Байгалиас түүнчлэн хүний гараар бүтсэн тухайн хүний болон хүний олонлогийн эргэн тойрныг хамруулсан ойлголт юм. Тэр дундаа эрүүл, аюулгүй орчин нь дан ганц хүн бус, амьд амьтан, ургамал зэрэгт нөлөөлж хамаарах өргөн хүрээний ойлголт юм.



Эрүүл орчин гэдэг нь: Гол төлөв байгалийн тэнцэл, хүрээлэн буй орчны төлөв байдалтай холбоотой. Тухайлбал ус, агаар, газар, хөрс түүнтэй холбоотой үүсэх эрхийн асуудлыг хамруулна.

Аюулгүй орчин гэдэг нь: Нийгэм-улс төрийн шинжтэй ойлголтыг илэрхийлэх бөгөөд тухайлбал, хүчирхийллээс ангид байх, олон нийтийн хэв журмыг хангах, бие махбодийн аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг бүрдүүлэх асуудлыг хамруулна.⁸

Хүмүүсийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь хүний амьд явах эрх, эрх чөлөөний үндэс юм. Хүн өөрөө байгалийн амьтан, эд эс нь болохоор түүнд цэвэр

⁷ НҮБ-ын Хамгаал, Хүндэл, Эрхийг Сэргээ хэмээх бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим” 2011.06.16-ны өдөр НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл

⁸ Хүний эрхийн товч тайлбар толь. 135-р тал. 2012 он ХЭҮК



агаар, цэнгэг үс, эрүүл хөрс, эрүүл хүнс эн тэргүүнд чухал. Тиймээс иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг зөвхөн төр гэлтгүй хувийн хэвшил ч хангах үүрэгтэй.

1.8 Хувь хүний эрх, эрх чөлөө ба хариуцлага

Өнөөдөр бид хүний эрхийн талаар ярихдаа улс үндэстэн, нийгмийн анги, давхаргын талаар бүс хувь хүний эрх, эрх чөлөө гэсэн утгаар авч үзэх нь зүйтэй юм. Хүний эрхийн хэрэгжилтийн тусгагдахуун нь хувь хүн бөгөөд түүний эрх, эрх чөлөө хэр хангагдсанаар хэмжигдэнэ. Нийгмийн бүх харилцаа, эрх зүйн үндэс суурь нь хувь хүн. Хувь хүн төрөлхөөсөө эрх чөлөөтэй бөгөөд тэр эрх чөлөөг хэн ч түүний дотор төр өөрөө зөрчиж болохгүй. Хувь хүн бусдад хор хөнөөл учруулаагүй л бол түүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл, шалтгаан байх ёсгүй юм.

Нөгөөтэйгүүр, иргэн хүн төртэй эн чацуу эрх бүхий субъект мөн. Төр хувь хүмүүсээс татвараар дамжуулан авсан мөнгөөр цалинжиж, хувь сонгогчдын олгосон эрх дээр оршиж байдаг тул хувь хүнээс дээр байх хуулийн хийгээд ёс суртахууны үндэслэл байхгүй. Төрийн албанд очсон хүмүүс жирийн иргэдээс илүү эрхтэй болоогүй, харин иргэдийнхээ өмнө үүрэг хүлээгч болсон гэдгээ байнга санах хэрэгтэй. Тэд иргэнтэй яг адил эрхтэй. Сум, хорооны засаг даргаас авахуулаад УИХ-ын гишүүд, ерөнхийлөгч хүртэлх төрийн бүх албан тушаалтнууд иргэдээсээ “зөвшөөрөл” авч дөрвөн жилийн хугацаатай, өрсөлдөх зарчмаар өөрсдөө хүсэл зоригоороо хамгийн сайн үүрэг хүлээгч байхаа амлаж ажилд орсон хүмүүс гэдгээ байнга санаж байх үүрэгтэй. Иргэд харин эрх эдлэгч болохын хувьд үүрэг хүлээгчдийн үүрэг хариуцлагыг сануулж, шаардах чадавхтай байх ёстой бөгөөд тэр чадавх олгох үүргийг төр хүлээсэн юм.

Төрийн эцсийн бөгөөд дээд зорилго нь хувь хүний эрх, эрх чөлөөг хангах явдал. Хувь хүн бол хэрэгсэл биш зорилго бөгөөд “төрийн бодлого тойрсон хүмүүс биш харин хүн тойрсон төрийн бодлого” байх ёстой. Төр хувь хүнийг элдэв халдлагаас хамгаалах төдийгүй төрөөс хувь хүний эрхийг хязгаарласан, үл хүндэтгэсэн өчүүхэн төдий элемент агуулсан хууль тогтоомж батлах ёсгүй.



Нийгэмд хувь хүний хариуцлага бол хамгийн гол зүйл. Хувь хүн эрх чөлөөт нөхцөл байдалд гаргасан алдаагаа бусадтай хуваалцах юм уу, бусдад үүрүүлэх ёсгүй. Харин хүмүүст ямар эрх байхгүй вэ гэвэл өөр шигээ эрхтэй хүмүүсийн эрхийг зөрчих эрх байхгүй.



Энэ бол иргэн бүрийн эрхээ эдлэхдээ баримтлах ёстой үндсэн зарчим мөн. Өөрөөр хэлбэл, хувь хүний эрх чөлөөний нэг л хязгаарлалт байх бөгөөд тэр нь бусад хүнд байгаа мөн тийм эрх, эрх чөлөө юм. Хувь хүн нь бусдын болон нийтийн ашиг сонирхол хөндөгдөх аливаа зүй бус үйлдэл хийж байгаа бол төр, бусад хүмүүсийн буюу нийтийн эрх ашгийг хамгаалах үүднээс хөндлөнгөөс оролцох эрхтэй гэсэн ойлголт юм.



Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй.

ХЭТТ. 29-р зүйл. 1,2 заалт



Монгол улсын шинэ Үндсэн хуульд “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэж заасан⁹ нь та эрхээ эдлэхдээ бусад хүн, хамт олон, нийгмээ хохироохгүйгээр эрх, эрх чөлөөгөө эдлэхийн зэрэгцээ үүрэг, хариуцлага ч хамт хүлээдэг.

⁹ Монгол улсын Үндсэн хууль. 1992 он. 19,3 заалт





Хувийн ашиг сонирхол, нийтийн үйл хэргийн нарийн холбоо, уялдааг эрх чөлөөтэй холбон тайлбарлаж, эрх чөлөөний философийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан сэтгэгч ГЕОРГ ФРИДРИХ ГЕГЕЛЬ чөлөөт хүсэл зориг гэсэн нэр томъёог хэрэглэсэн байдаг. “Хүн ёс суртахууны хувьд бие даасан байдлаа олж, өөрөө өөрийгөө чөлөөтэй удирдаж, эрх зүйд захирагдаж чаддаг болсон цагт, тэр хүн чөлөөт хүсэл зоригтой буюу жинхэнэ эрх чөлөөтэйд тооцогдоно” гэсэн санаа дэвшүүлсэн.

Энэ нь хувь хүн юу хүсч байгаагаа, юунд тэмүүлэх, зорих ёстойгоо зөвхөн энэ цаг үеийн нийгэмдээ л мэдэх, эдлэх боломжтой болохыг илэрхийлсэн байна. Гэхдээ эрхээ эдлэж, хувийн ашиг сонирхолоо илэрхийлэх эрх чөлөө нь нийгмийн харилцаанд ороход нийтийн дүрмээр, эрхзүйд захирагдаж чаддаг байх нь хувь хүнд хүлээлгэх хариуцлага болно.



БҮЛЭГ

2

ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН
ХАНДЛАГА, ТҮҮНИЙ ЗАРЧМУУД



2.1. Хүний эрхийг хангах олон улсын болон үндэсний тогтолцоо

Улс орнуудын засгийн газар ОУ-ын хүний эрхийн хамтын тогтолцоонд оролцох замаар Үндсэн хууль, хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, төсөв, үйл ажиллагаандаа эдгээр хууль эрх зүйн хэм хэмжээг тусгасан, өөрийн хүлээн зөвшөөрсөн хамгийн бага стандартыг зөрчих бус харин хангалттай хэмжээнд сахин биелүүлж байх үүрэг хүлээдэг. Энэ үүрэг хариуцлага нь төрийн бүх салбар, бүх түвшинд, ялангуяа иргэдтэй нүүр тулж үйлчилгээ үзүүлдэг орон нутгийн түвшинд бүр ч хамааралтай. Орон нутаг гэдэг нь зөвхөн хөдөө орон нутаг дахь аймаг, баг, сумдаар хязгаарлагдахгүй нийслэлийн анхан шатны хэсэг, хороо, дүүргийг хамруулан авч үздэг.

Төр нь төрөөс гаргаж буй хөгжлийн бодлого, төлөвлөгөөг хэрэгжилтийн өмнө болон дараа нь хүний эрх, эрх чөлөө бүрэн эдлэхэд хэр дэмжлэг үзүүлсэн үр нөлөөний шалгуураар үнэлж дүгнэх албан ёсны үүрэгтэй. Төрийн бас нэг үүрэг нь хүний эрхийг хүн бүрт адил тэгш эдлэх явдлыг хангах зорилгоор хөгжлийн үйл явцад оролцож буй эсвэл нөлөөлж буй гуравдагч талын тухайлбал, бизнесийн байгууллагын үүрэг хариуцлага, хандлагыг зохицуулахыг мөн хариуцах үүрэгтэй байдаг.



Хүний эрх, эрх чөлөөг хангах тогтолцоо нь зөвхөн тухайн орны асуудал биш олон улсын хамтын хүч, хамтын тогтолцоо, хамтын бодлого шаарддаг. Өөрөөр хэлбэл, дараах бүдүүвчээс харна уу.

Хүний эрх тэр тусмаа иргэний жам ёсны, үндсэн эрхийг томъёолж баталгаажуулсан баримт бичгийг хууль зүйн эх сурвалж гэдэг. Энэ нь дараахь хоёр хэлбэртэй байна. Нэг нь Олон улсын гэрээ, нөгөө нь үндэсний хууль тогтоомж, Үндсэн хууль юм¹⁰.

¹⁰ Үндсэн хуулийн мэдлэг. Б.Чимид. 95-р тал. 2008 он



Монгол улс өөрөө боловсруулж баталсан бол **соёрхон баталсан хууль**, нэгэнт байгуулсан олон улсын гэрээнд хүлээн зөвшөөрч нэгдсэн бол энэ тухай хууль гаргадаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10.2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. 10.3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэжээ.

Энэ нь Олон улсын гэрээ **Монгол улсын олон улсын гэрээ** болж хуулийн адил хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд хүлээн зөвшөөрч нэгдсэн бол шударгаар биелүүлэх үүрэг хүлээхээ баталгаажуулсан байна.

2.2. Хүний эрхэд суурилсан хандлага, түүнийг үйл хэрэг болгох шаардлага

Хүний эрхэд суурилсан хандлага (ХЭСХ)-ыг хөгжлийн бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх, сайжруулахад улс орнууд хэрэглэж хөгжүүлэхэд олон талууд хувь нэмэр оруулж байгаа ч гол байгууллага нь НҮБ юм. НҮБ-ын системийн хөгжлийн агентлагууд, тэр дундаа НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрүүд нь хүн төвтэй хандлагыг удирдамжаа болгон хэрэгжүүлсээр ирсэн. НҮБ болон түүний гишүүн орнууд хүний эрхийн түгээмэл эрхийг хангах үүргийг дангаараа буюу нэгдэн биелүүлэх үүрэгтэйг дээр хэлсэн. Энэ нь НҮБ-ын суурь зарчим, үндсэн зорилго юм¹¹.

¹¹ НҮБ-ын дүрмийн 1 дүгээр зүйл нь олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах, улс орнуудын найрсаг харилцааг хөгжүүлэх, хүн бүрийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг дэмжих зэргээр олон улсын хамтын ажиллагааг хангах гэсэн 3 үндсэн зорилтыг тодорхойлсон. 55 дугаар зүйлд НҮБ нь "хүний эрх, үндсэн эрх чөлөөг яс үндэс, хүйс, хэл, шашин шүтлэгээс үл ялгаварлан бүх нийтээр хүндэтгэх, хангахыг заасан. 56 дугаар зүйлд НҮБ-ын гишүүн орнууд хамтран болон тус тусдаа 55 дугаар зүйлийг хэрэгжүүлэх амлалт авсан



Хүний эрхийг хангана гэдэг нь хөгжлийн арга зам, зорилгын аль аль нь болдог учир хүний эрхэд суурилсан хандлага гэсэн ухагдахуун урт хугацаанд байсан бөгөөд цоо шинэ үзэл биш юм¹².

ХЭСХ нь хүмүүс өөрсдийн эдлэх эрхийг шаардах, хэрэгжүүлэх, хяналт тавих болон шийдвэр гаргах үйл явцад оролцох нөхцөл боломжоо хангуулах замаар хүмүүсийн бүхий л төрлийн эрхийг бодлого, хөтөлбөрийн гол ЦӨМ нь гэдгийг хүлээн зөвшөөрүүлэхийг зорьдог.



Хүний эрхэд суурилсан хандлага (ХЭСХ) нь хүн бүрт эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломжийг олгох зорилготой суурь зарчмуудыг бодлого, үйл ажиллагаанд тогтмол хэрэглэх ҮЙЛ ЯВЦ юм.

Энэ нь хамгийн наад захын, бага гэлтгүй, бүхий л түвшний стандарт төлөвлөгөө, бодлого, төсөв, үйл ажиллагаа, арга хэмжээ бүрт нягт бөгөөд тогтмол уялдуулан хангахыг шаардах үйл явцаас гадна үр дүнд ч мөн хангах тухай ойлголт юм.

Тэгэхээр үндэсний болон орон нутгийн түвшний хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг¹³ хүний эрх, эрх чөлөөний суурь зарчмуудад суурилан боловсруулах, батлах, хэрэгжүүлэх ёстой болж байна. Харин түүний хэрэгжилтийг үнэлэхдээ тухайн баримт бичгүүдийн үйл ажиллагаа, арга хэмжээ нь нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ямар үл мөр үлдээсэн бэ? Бодлогын хэрэгжилтийн үр нөлөө нь хүн бүрийн эрх, эрх чөлөөгөө бүрэн дүүрэн эдлэх боломжуудыг хэр бий болгосон, хүний хөгжлийг хэр хангасан, айл өрх, хүн бүрийн амьдралын чанарт гарсан ахиц, төрөөс хүний эрхийг биелүүлэх үүргээ гүйцэтгэхэд хэр дэмжлэг болж чадсан гэсэн шалгуураар харах цогц үйл ажиллагаа, түүнийг “харах өнцөг” эрхэд суурилсан байхыг ХЭСХ гэж ойлгоно.

Хөгжлийн үр дүн нь нийт ард түмэн, хувь хүн бүрийн идэвхитэй, чөлөөтэй утга учиртай оролцоонд үндэслэсэн хөгжил, тэдний сайн сайхан амьдралыг тогтмол сайжруулах үйл явц гэж үздэг.

¹² Тухайлбал, НҮБ-аас өмнө байгуулагдсан Олон улсын хөдөлмөрийн байгууллага нь 1919 онд байгуулагдсанаасаа хойш хүний эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн. НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссарын газраас хэрэгжүүлдэг тусламжийн хөтөлбөр нь 1955 оноос хойш олон улсын хүний эрхийн стандартад үндэслэдэг.

¹³ Хөгжлийн бодлогын баримт бичгүүд гэдэгт: Урт хугацааны төрийн бодлогууд, мөрийн хөтөлбөрүүд, жил бүрийн нийгэм эдийн засгийн үндсэн чиглэл, төсөв болон Зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төслүүд, бизнесийн байгууллагуудад шилжүүлэх төрийн чиг үүрэг гэрээ, концессийн гэрээ гэх мэт орно





Хөгжил нь эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн цогц үйл явц юм. Үүний цөм нь нийт хүн ам, хувь хүн бүрийн идэвхтэй, чөлөөтэй, утга бүхий оролцоонд үндэслэн, тэдний сайн сайхан амьдралыг тогтмол сайжруулах явдал бөгөөд энэ нь бүх улс оронд хамаатай.

Иймээс, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн хөгжлийн тодорхойлолт нь зөвхөн эдийн засгийн болон макро эдийн засгийн үр дүн бус түүнчлэн эрүүл мэнд, орон сууц, боловсрол, нөөцийн хуваарилалт, хүмүүсийн чадварыг бэхжүүлэх, тэдний сонголтыг өргөжүүлэх зэрэг хүн амын амьдралын бүхий л асуудлыг хамарна.

Ийнхүү хөгжил нь үйл явц болон үр дүнд анхаарч байгаа нь хүний иргэний, улс төрийн, эдийн засгийн болон соёлын эрхийн хөгжил гэсэн үг.

НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас 1986 онд баталсан Хөгжих эрхийн тухай тунхаглал¹⁴

Жишээлбэл, манай улсын хувьд хөгжлийн үр дүнд ядуурал, ажилгүйдэл бодитой буурсан байх ёстой. Энэ нь ажлын байр нэмэгдэж, хөдөлмөрийн хөлсний тариф хангалттай түвшинд нэмэгдэж, хөдөлмөрийн мөлжлөг арилж, хүмүүсийн ялангуяа эрх мэдэл багатай хүмүүсийн хөдөлмөр эрхлэх боломжууд хангалттай нэмэгдэж, шударгаар хөдөлмөрлөсөн цалин хөлс нь тэдний хоол хүнс, орон байр, боловсрол соёл, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах, гэр бүл, үр хүүхэд, эх эцгээ асран хамгаалахад хангалттай хүрдэг болж түүнчлэн залуучууд гадаадад ажиллах хүчнээр экспортлогдохгүй болох, эмэгтэйчүүд эрэгтэйчүүд хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэл буурснаар илрэх юм.

ХЭСХ нь улс орнуудын ядуурлыг бууруулах стратеги, зорилтууд нь ОУ-ын хүний эрхийн зарчим, хэм хэмжээ, стандартад үндэслэсэн байгаад зогсохгүй эдгээр стратегийг орлого багатай, ажилгүй, мэдээлэлгүй бүлгийг эрх мэдэлжүүлэх замаар тэдгээр хүмүүсийн идэвхтэй, бодитой оролцоонд суурилан тодорхойлж, тэдний оролцоотой хэрэгжүүлж, тэр бүлгийн иргэдтэй дүгнэж ахиц гаргаж байхыг шаарддаг.



ХЭСХ нь бидний “ядуу” эсвэл “эмзэг бүлэг” гэж тодорхойлсоор ирсэн эрх мэдэл багатай бүлгийн өөрсдийнх нь хүний эрх, эрх чөлөөний мэдлэг мэдээллийг алхам алхмаар нэмэгдүүлж шийдвэр гаргахад утга учиртай оролцооны чанарыг сайжруулах, эдлэх эрх, эрх чөлөөгөө мэдсэнээр эрх агуулагч гэдгээ ойлгож төрийн үүргийг сануулах, хариуцлага шаардах чадвартай болгох арга хэрэгсэл юм.

¹⁴ www.unhchr.ch/html/menu3/b/74.htm



Хүний эрхэд суурилсан хэд хэдэн хандлагыг боловсруулан хэрэгжүүлж байгаа гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Аль арга хамгийн үр дүнтэй байх нь тухайн салбараас, нийгэм улс төрийн нөхцөл байдал, ХЭСХ-ыг хэрэглэж буй этгээдээс хамаарна. Гэхдээ ХЭСХ нь өөр өөр томьёолол, хандлагыг¹⁵ ашигладаг ч нийтлэг ерөнхий зорилт, үндсэн зарчимтай байдаг. ХЭСХ-ын зарчмууд нь улс орон хамтран болон дангаараа төлөвлөж, хэрэгжүүлэхийн зэрэгцээ тухайн улсуудын эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн үйл явцын үр дүн буюу хөгжлийг хэмжихэд ашигладаг хууль ёсны шалгуур үнэлгээнүүдийн нэг болж байна.

Энэхүү гарын авлагаар Монгол улсын онцлог байдал, хэрэгцээнд нийцэх, бусад улс орнуудын нийтлэг хэрэглэж буй загварыг танилцуулж байгаа болно.

ХЭСХ-ын гол цөмийг бүрдүүлэгч, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, хоорондоо уялдаа бүхий дараах нийтлэг үндсэн зарчмуудтай.



ХЭСХ-ын зарчмуудыг тайлбарлахын өмнө хүний эрхийг биелүүлэх үүрэг хүлээгч талууд, тэдгээрийн хүний эрхийн мэдрэмж, хандлагын талаар ярилцах нь зүйтэй.

¹⁵ Жишээ нь Их Британий Олон улсын хөгжлийн яам өөрийн нийтлэг зарчим болгон хэрэглэдэг. Оролцоо, нийтийг хамрах, үүргээ биелүүлэх нь ХЭТА-ыг хэрэглэхэд чухал бүрэлдэхүүн нь болдог. Нөгөө талаас, НҮБ-ын HURIS хөтөлбөр нь Оролцоо (participation), хариуцлагын тогтолцоо (accountability), үл ялгаварлах (non-discrimination), эрх мэдэл олгох (empowerment), холбоо (linkage) гэсэн үгнүүдийн товчлол болох PANEL-ыг норматив стандарт болгон ашигладаг. Өөр өөр этгээдүүдийн ашигладаг тодорхойлолтуудын талаар http://www.crin.org/docs/resources/publications/hrbap/Interaction_analysis_RBA_definitions.pdf. хаягаас харна уу.



Үүрэг хүлээгчид ХЭСХ-ыг төлөвшүүлэхдээ хийсвэр хандаж, нэг удаагийн төслийн арга хэрэгсэл мэт ашиглаж болохгүй юм. Ингэж хандаж хүлээж авах нь ямар ч үр дүнгүй бөгөөд хүмүүсийн хүний эрх зохих түвшинд хангагдахад тодорхой хугацаанд “чөдөр” болох юм.

Төрийн албан хаагчид, орон нутгийн шийдвэр гаргагчид, ажил олгогч бизнесийнхэн үрэд өмнө олон улсын болон үндэсний түвшинд мөрдөх хүний эрхийг хангах үүргийг хэрэгжүүлж, тайлагнаж ирсэн арвин арга туршлагатай. Гэсэн хэдий ч хүний эрхийг хэрэгжүүлэх үүрэг хүлээгчдийг хувь хүнийх нь хувьд хүний эрхэд хандах мэдрэмж, дотоод эрхэм чанар, иргэд, сонгогчиддоо чин сэтгэлээсээ хандах хандлага, сэтгэлгээг өөрчлөхийг үүрэг болгодоггүй.

Хүний эрхэд суурилсан хандлага нь хүний эрхийг хэрэгжүүлэх үүрэг хүлээгч хувь хүний хандлагыг онцгойлон авч үздэг ба энэ нь үйл хөдлөл, ажил хэргийн явцад илэрч, үл мөр үлдээж, нийгэм хүмүүст хүрэх харилцааны явцад илэрч байдаг нарийн мэдрэмжид суурилдагаараа онцлог бөгөөд удирдлагын шинэ арга хэрэгсэл юм.

Төр гэдэг хийсвэр хэдий ч эрх барьж буй хүмүүс, шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагч албан хаагч хувь хүний эрхэд мэдрэмжтэй хандах хандлага, үүргээ ухамсарласан хүмүүсийн үйлдэл бүрийн үл мөрөөр үр дүн нь илэрдэг. Иргэд төрийн төлөөлөгчөө сонгохдоо хувь хүний нэрийн өмнөх дугаарыг дугуйлснаар нийгмийн гэрээ байгуулж, төрд өөрийгөө төлөөлөх хувь хүнийг сонгодог.

Төрийг төлөөлсөн хувь хүмүүсийн хүний эрхийн мэдлэг мэдрэмж, хүнлэг чанар, хүн болсон хүмүүжил, хандлагын нэгдэл нь төрийн зүгээс хүний эрх, эрх чөлөөг хангах үүргээ хэрхэн хэрэгжүүлэх нь шууд хамааралтай байдаг. Ийм учраас ерөнхий хийсвэр төр гэхээсээ илүүтэй төрийн албан хаагчид, шийдвэр гаргагчид, ажил олгогч эздийн хүний эрхэд суурилсан мэдрэмж, хандлагыг сайжруулах, төлөвшүүлэх шаардлага үүсч байна.





Хүснэгт: Хүний эрхэд суурилсан хандлага болон бусад хандлагын хоорондын гол ялгаа

БУСАД ХАНДЛАГА	ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА
Үйл ажиллагаа нь сайн дурын	Үйл ажиллагаа нь зайлшгүй шаардлагатай
Хүмүүст хангагдах ёстой хэрэгцээ байдаг	Хүмүүст хуулиар хамгаалагдсан нэхэмжлэх эрхтэй олгодог
Эрх мэдэл багатай хүмүүс халамжлуулагч объектийн хувьд тусламж хүртэнэ	Эрх мэдэл багатай хүмүүс эрхийн объектийн хувьд тусламж авах эрхтэй.
Зарим хүмүүсийг орхигдуулж болох юм	Бүх хүн өөрийн боломж чадавхаа хөгжүүлэх адил эрхтэй бөгөөд түүнийг илүү хөгжүүлэхэд дэмжлэг авч болно
Хөгжлийн хамрагдсан хүмүүс идэвхгүй үр дүн хүртэгчид юм; Хөтөлбөр, төслүүдийн үр дүнг сайжруулахын тулд тэднийг урьж оролцуулж болно	Хүмүүс эрхийн хувьд идэвхтэй хөгжлийн гол оролцогчид юм.
Зарим хэрэгцээ шаардлагыг зарим соёл хүлээн зөвшөөрдөггүй	Хүний эрх нь хил хязгааргүй, түгээмэл, салшгүй тул тэдгээрийг сулруулж, эсвэл салган авах эрх төрд байхгүй.
Хүчний бүтцийг өөрчлөх маш бэрхшээлтэй бөгөөд, тэдгээрийн дотор ажиллах прагматик арга замуудыг олох хэрэгтэй	Хүний эрхийг хэрэгжүүлэх үйл явцад саад болж буй хүчин зүйлсийг үр дүнтэйгээр ахиц гаргаж өөрчлөх ёстой
Хөгжил нь техник үйл явц бөгөөд хамгийн сайн мэдлэгтэй техникийн «мэргэжилтнүүд»-ээр л удирдуулах ёстой	Хөгжлийн үйл ажиллагаанд эрх агуулагчдыг гол оролцогчид гэж үзэн өөрсдийн эрхээ эдлэх болон олон нийтийн шийдвэр гаргахад оролцоход нь дэмжлэг үзүүлэх ёстой
“Хэрэгцээний шатлал” гэж байх ба зарим нь эрхийн хэрэгцээ нь үргэлж бусад эрхийн хэрэгцээнээс илүү чухал байдаг	Эрх нь ямар ч нөхцөл байдалд хуваагдашгүй, харилцан хамааралтай байдаг

Энэ харьцуулалтаас харахад улс орнуудын уламжлалт эрхэд хандах хандлага нь хүмүүсийг ялангуяа эрх мэдэл багатай бүлгийг илүү объект буюу хэрэгсэл гэж харж ирсэн бол ХЭСХ нь хүмүүсийг тэр дундаа эрх мэдэл багатай бүлгийг хөгжлийн гол оролцогч, шийдвэр гаргагч, эрх агуулагч гэж үзэн бодлого тодорхойлдоогоороо эрс ялгаатай удирдлагын шинэ арга хэрэгсэл болж байгаа юм.

Иймд төрийн болон төрийн бус эрхийг хэрэгжүүлэх үүрэг хүлээгчдийг эрхэд суурилсан хандлагад суралцаж хувь хүн өөрийн эрхийг харах өнцөг, удирдахуйн хандлагадаа эргэцүүлсэн дүгнэлт хийх, эрх мэдэл багатай бүлэг буюу эрх





агуулагчдыг үзэх үзэл, байр сууриа өөрчлөхийг хүсч байгаа юм. Ингээд ХЭСХ-ын үндсэн таван зарчмуудыг тайлбарлая.

Зарчим 1: Олон улсын хүний эрхийн стандартыг мөрдөн хэрэгжүүлэх



Хүний эрхэд суурилсан хандлага (ХЭСХ)-ыг нэвтрүүлэхийн өмнө төр түүний албан хаагчдад ХЭТТ болон түүний үндсэн хоёр пактаас гадна хүний эрхийн хууль ёсны үүрэг хариуцлагыг тодорхойлсон бусад эрх зүйн баримт бичгүүд түүний хэм хэмжээ, стандарт шаардлагуудын талаар мэдлэг олгох төдийгүй тэдгээрийг үндэсний хууль тогтоомжид

тусган, нийтэд тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх чадавх нөөцийг бий болгох ёстой. Тухайлбал, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудал улс хооронд хамтран ажиллах тухай, Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай, Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг, Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай¹⁶, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай конвенциуд тэдгээрийн нэмэлт протоколууд гэх мэт баримт бичгүүдийг багтаан ойлгоно.

ОУ-ын хэмжээний гэрээ, эрхзүйгээс гадна эрх мэдэл бүхий байгууллагуудын албан ёсны мэдэгдлүүд багтана. Тухайлбал, ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын конвенци түүний нэмэлт протокол, тухайлсан хэд хэдэн улс хоорондын Далайд гарцгүй улс орнуудын худалдааны зохицуулалт, эсвэл бүс нутгийн орнуудын хооронд хүлээх үүрэг, эсвэл хамтарсан тунхаглал мэдэгдлүүд мөн НҮБ-ын тусгай илтгэгчдийн үнэлгээний тайлан дүгнэлтүүд гэх мэт өргөн хүрээний баримт бичгүүдийг хамруулан авч үзнэ.

ХЭСХ нь хүний эрхийн суурь зарчмуудыг тодорхой тусгахыг шаарддаг ба хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, хүний эрхийн хэрэгжилт дэх үр нөлөөг үндэслэлтэйгээр хэмжих арга боловсруулах зарчмыг бий болгоно.

¹⁶ Төрийн мэдээлэл. 2004 он. Тусгай дугаар.



Зарчим 2: Эрх мэдэл олгох буюу эрх мэдэлжүүлэх

Хүмүүс эрхээ эдэлж чадахгүй байхын суурь үндэс бол эрх мэдэлгүй байх явдал бөгөөд энэ нь гол төлөв боловсрол муу эсвэл шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжгүй, мэдээлэл байхгүйгээс шалтгаалдаг. Энэ нь хүний эрхийн өөрчлөлтийг шаардах, хангах чадваргүй байхад хүргэдэг.

Эрх мэдэл олгох зарчим бол эрх агуулж буй болон үүрэг хүлээсэн этгээдийн аль алиных нь мэдээлэл солилцоо, шийдвэр гаргах үйл явцад оролцох, оролцуулах боломжийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхийг шаарддаг. Оролцооны эрхээ бүрэн дүүрэн эдэлж чаддаг болсон эрх агуулагч хувь хүмүүсийг нэгдэж эрхээ шаардах чадварт сургаж улмаар үүрэг хүлээгчдийг хариуцлагатай болгох замаар тэдгээрийн үүрэг хариуцлага хүлээх чадварыг нэмэгдүүлнэ гэж үздэг.

Оролцооны эрхийг үр дүнтэйгээр, тогтмол хангах нь эрх мэдэл олгох зарчмыг хэрэгжүүлэх зарчмын суурь болно. Өөрөөр хэлбэл, эрх мэдэл олгох, эрх мэдэлжүүлэх эрхээр дамжуулан үр дүнтэй, бодит оролцооны зарчим хангагдана.

Зарчим 3: Оролцоог хангах

Аливаа хүн өөрийнх нь амьдрал, эрх ашигт нөлөөлөх шийдвэр гаргахад оролцох эрх нь хүний эрхийг хангах талаар болон хүний эрхийн хувьд нэг алхам урагшилж буй явдал юм. ХЭСХ-ын бусад зарчмын адил оролцох эрх нь олон улсын хуулийн тодорхойлолтоор “идэвхтэй, чөлөөтэй, утга бүхий байх” цогц ойлголт бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, боловсрол эзэмших, мэдээлэл олж авах зэрэг олон эрхийг хангах явдлыг шаарддаг. Энэ нь үл ялгаварлах зарчимд тулгуурлах ба төрийн зүгээс хүний эрхийн гэрээгээр хүлээсэн үүргээ өргөн хүрээнд түгээж, ойлгуулах явдлыг багтаана.

Үр дүнтэй бодитой оролцох нь эрх мэдэл олгох болон эрх мэдэл олох аргын аль алинаас хамаарах бөгөөд “орон нутгийн хүмүүс өөрсдийн нутаг орны өмнө тулгарч буй бэрхшээл, тулгамдсан асуудлыг тодорхойлж, эдгээрийг шийдвэрлэх хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, улмаар гарч буй үр дүнд хяналт тавих чадвартай” байх асуудал бөгөөд энэ чадварыг төрийн зүгээс бий болгож өгөх үүрэгтэй бол эрх агуулагч өөрөө идэвхи санаачлагатай, бүтээлч байх нь мөн тэдний үүрэг болдог.



**4 Зарчим 4: Үл ялгаварлах ба эмзэг бүлэгт илүү анхаарал хандуулах**

Хүний эрхэд суурилсан хандлага (ХЭСХ) -ын бусад дөрвөн зарчимтай адил, энэ зарчим нь олон улсын эрх зүйн тогтолцооноос шууд урган гарах ба хүний эрхийг хамгаалах гол цөм нь юм. Хүний эрхийг хангахад ялгаварлан гадуурхах байдлыг хориглох, эмзэг бүлэгт илүү анхаарал хандуулах нь хүний эрхийн талаарх бүх гэрээнүүдэд тусгагдсан байдаг, хүний эрхийн түгээмэл нийтлэг асуудал юм.

ХЭСХ-ын энэхүү зарчим нь хөгжлийн үйл ажиллагаанд гол төлөв хэрэглэгддэг бөгөөд аливаа нэг цөөнх эсвэл эмэгтэйчүүд эсвэл хөдөөний хүмүүсийг илүү анхаарлын төвд тавих, эмзэг гэж авч үзэх тухай асуудал биш юм. Харин хөгжлийн аливаа бодлого нийгмийн эрх мэдэл багатай бүлгийн хүмүүсийг эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломжийг хангахад чиглэсэн байх, үүний тулд бодлого боловсруулахдаа тухайн бүлгийн иргэдийг оролцуулах, улмаар эрх мэдэлжүүлэх тухай ойлголт юм. Жишээ нь: МУ-ын Засгийн газар нь Ядуурлыг бууруулах урт болон дунд хугацааны бодлого гаргаж, түүнийгээ хэрэгжүүлэн багагүй хэмжээний төсөв зарцуулсан хэдий ч эмзэг байдалд байгаа иргэд тооны хувьд ч, амьдралын чанарын хувьд ч ахиц гараагүй байсаар байна. Үүнийг л ХЭСХ-аар харж бодлого боловсруулж хэрэгжүүлэхийг шаарддаг зарчим энэ юм. Гэхдээ хүний эрхийн эмзэг байх агуулга нь олон түвшинд, нарийн, мэдрэмжтэй, нийгмийн өөр өөр бүлгийг хамарсан, цаг хугацаа өнгөрөх явцад өөрчлөгдөж байдаг гэдгийг ч ойлгож хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

5 Зарчим 5: Хариуцлагын тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх

ХЭСХ-ын хариуцлагын тогтолцоо гэдэг нь эрхзүйн тогтолцоо бөгөөд эрх мэдэлжүүлэх, оролцоог хангах, эмзэг бүлэгт илүү анхаарах дээрх дөрвөн зарчим бүхэлдээ нэгэн зэрэг хүний эрхийн үүрэг хариуцлагыг хангах хариуцлагын тогтолцоо болдог. Энэ тогтолцоо нь эрх агуулагч болон үүрэг хүлээгч талуудын аль алинд гарч буй ахиц өөрчлөлтийг хэмжих, хүний эрхийн талаар гарч буй өөрчлөлтийн амжилтыг урамшуулах, алдааг залруулахад зориулагдсан.



“Төр ба бусад үүрэг бүхий этгээд хүний эрхийг хангахад мэдрэмжтэй байна. Энэ утгаараа, тэд хүний эрхийн асуудалд тусгагдсан эрхзүйн норм, стандартыг дагаж мөрдөх үүрэгтэй. Ингэж чадаагүй нөхцөлд, хуулийн дагуу тогтоосон дүрэм, зарчмын дагуу холбогдох шүүх, тохируулагч байгууллага арга хэмжээ авахаас өмнө эрх агуулагчид нь зохих арга хэмжээ авах эрхтэй байна.”¹⁷

¹⁷ Хөгжлийн хамтын ажиллагааны хүний эрхэд тулгуурласан арга – НҮБ-ын агентлагуудын хүрээнд нэгдсэн ойлголтод хүрэх нь, www.undp.org/governance/docshurist/030616CommonUnderstanding.doc



Хариуцлагын тогтолцоо нь бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх болон үр дүнг тооцох бүхий л үйл явцад хамарна. Иймээс, хариуцлагын тогтолцооны зарчим нь дараахь хоёр асуудлыг хамарсан байхыг шаарддаг. Үүнд:

- а) ХЭСХ-ын хариуцлагын зарчмыг хэрэгжүүлэх үр дүнтэй, системтэй төлөвлөлт, нөөц бий болгох
- б) Хуулийн, захиргааны, улс төрийн хүрээн дэх хариуцлагын төлөв байдлыг үнэлж шинжилсэн байх.

Үүнд эрх агуулагч хүмүүс болон үүрэг хүлээгч төрд аль алинд хариуцлагын тогтолцоог хангах, удирдах, үр дүнг үнэлэх асуудал багтана.

2.3. ХЭСХ-ыг хэрэгжүүлэхэд тулгарч болох бэрхшээлүүд

ХЭСХ - ыг хэрэглэх явцад бодлого, бүтэц тогтолцоог зарчмын хувьд хүний эрхэд суурилсан болгон өөрчлөх нь чухал хэдий ч түүнээс илүү зүйл хийх шаардлагатай болдог байна. Энэ нь удирдлагын аргачлал, практик арга зүй боловсруулахаас гадна ирээдүйд үүсэх, одоо тулгарах бэрхшээлийг урьдчилан харж сэргийлэх, бусад улс орнуудын сайн сургамжаас байнга суралцаж хэрэгжүүлэх шаардлага гардаг байна. ХЭСХ-ыг нэвтрүүлэх нь ч өөрөө хугацаа шаардсан процесс юм.

ХЭСХ-ыг хэрэгжүүлэхэд тодорхой сорилт, саад бэрхшээл гарч болно. Тухайлбал,

- Үүрэг хүлээгч төрийн албан хаагч хувь хүмүүсийн тогтсон хандлага өөрчлөгдөхгүй байх;
- Төрийн байгууллагын үйл ажиллагааны уламжлалт процесс шат дамжлагатай сөргөлдөх;
- ХЭСХ-ыг аль хэзээнээс бодлогод тусгаж хэрэгжүүлж байгаа мэт хандах. Тухайлбал, иргэдийн оролцоог хангасан, тодорхой эрх мэдэл олгосон, нийгмийн эрх мэдэл багатай бүлэгт чиглэсэн олон бодлого үйл ажиллагаа хэрэгжиж байгаа мэт үзэх хандлага бат бөх салахгүй байх;
- Эрх агуулагчдын оролцоог хүний эрхийн асуудал гэж үзэхгүй байх, ингэснээр үр дүнтэйгээр харж төлөвлөх, хэрэгжүүлэхэд саад гарах, зогсонги байдалтай болох;
- ХЭСХ-ын гол агуулга, ач холбогдлын талаар талууд, хамтрагчид тодорхой нэгдсэн мэдлэг мэдээлэлгүй, өөрчлөгдөх хүсэл эрмэлзэлгүй байх;
- Хүний эрхийн талаар олон нийтийн мэдлэг, мэдээлэл хомс байх, өөрчлөлтийн талаар бага хүлээлттэй байдгаас оролцоо муу, идэвхи санаачлагагүй байх;





- Хүний эрхийн хэрэгжилт нь өмчтэй байх эсвэл эдийн засгийн өсөлтөөс шалтгаална гэсэн үзэл ойлголт;
- ХЭСХ-ын хөтөлбөрийн чадавхи сул, гол анхаарах тусгай асуудлууд хомс байх;
- ИНБ-ын тархай бутархай, эсвэл цөөн байх, нэгдэж хамтарч ажиллах чадвар хомс байх гэх мэт олон шалтаг, шалтгаантай асуудлууд тулгарч болно.

Тухайлбал, Монгол улсын хувьд байгалийн баялгийг эрчимтэй ашиглаж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх нь ард түмний амжиргааг сайжруулах, шууд замаар хүний эрх, эрх чөлөөг хангахад бодит нөлөө үзүүлнэ гэж үздэг улс төрчид олон бий. Тэгвэл энэ хандлага нь байгалийн баялгаас эхтэй эдийн засгийн өсөлт нь хүний эрхэд суурилсан хандлагад ахиц гаргана гэж болох юм.

Гэвч эдийн засгийн өсөлт нь эсрэгээрээ өөр үр дүн үзүүлж болох юм. Олон орны эдийн засгийн өсөлт нь ядуурлын ялгааг улам нэмэгдүүлж, ДНБ-ний өсөлт нь дахин хуваарилах бодлоготой уялдаагүй байдаг. Авилга, ялгаварлан гадуурхах үзэл, эрх мэдэл олгохгүй байх нь бүгд нийгмийн дээд бүлэгт эдийн засгийн өсөлтийг илүү хүртэхэд хүргэдэг. Энэ жишээг нөөц баялаг ихтэй Науру улсын жишээнээс харж болохыг эдийн засагчид аль хэзээ манайд бичиж эхэллээ¹⁸.

Дэлхийн олон улс орнуудад дээрхи байж болох эсвэл гарч ирдэг бэрхшээл, сорилтуудыг даван туулах талаар тодорхой түршлага, сургамжуудыг хуримтлуулаад байна. Бид тэднээс суралцах бололцоотой бөгөөд энэ талаар судалж үзэх өргөн боломж нээлттэй байгаа юм.

ХЭСХ-ыг тууштай хэрэгжүүлэхэд, урт хугацааны өөрчлөлтийг бий болгоход тодорхой цаг хугацаа, нөөц шаардлагатай. ХЭСХ нь удирдлагын систем, ажилтнуудыг сургах, амжилт ба алдааг үнэлэх шалгуураа өөрчлөхөөс эхлээд байгууллагын соёлыг өөрчлөх хүртэл бүхий л үйл ажиллагааны хэсэгт өөрчлөлт хийх, бүрэн ойлгож мэдэхэд цаг хугацаа шаардлагатай. Гэсэн хэдий ч төр хүний эрхийг цаг ямагт ахиц гаргаж, бүрэн дүүрэн эдлүүлэх үүрэг хариуцлага хүлээсэн тул одооноос ХЭСХ-ыг эхлүүлэх нь зүйтэй юм.

¹⁸ <http://www.ikon.mn/n/b23>



2.4 ХЭСХ-ыг нэвтрүүлэхийн ач холбогдол, үр өгөөж

ХЭСХ нь хүн бүрт эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломжийг олгох зорилготой, суурь зарчмуудыг бодлого, үйл ажиллагаанд тогтмол хэрэглэх процесс гэж дээр тодорхойлсон. Тэгвэл хүн бүр эрхээ бүрэн дүүрэн эдлэх нь хүмүүс эрүүл, аюулгүй орчинд өөрийн ая тухаар ажиллаж амьдрах, чанартай эрдэм боловсрол эзэмшиж улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулж өөрийн потенциалыг бүрэн дүүрэн дайчлах, улмаар амьдралдаа хангалттай хэмжээний шударга хөдөлмөрийн хөлс бүхий орлоготой байж дутагдах гачигдахаас ангид байх нь хувь хүний хөгжил улмаар айл гэрийн амьдралын чанарын ахиц бөгөөд энэ нь ХӨГЖИЛ-ийн үндэс нь болдог.

Аливаа улс орны хөгжил нэг удаагийн арга хэмжээ, тодорхой цаг үеийн эдийн засгийн өсөлтийн үр дүнд бий болдоггүй. Ийм замаар бий болсон хөгжил нь түр зуурын, цөөн хүний элит бүлэгт ашигтай, нийт хүн амд үр нөлөөгүй, баян хоосны ялгааг бий болгосон, тансаг орд хаус, гудамж хотоор л хязгаарлагддаг.

ХЭСХ - д суурилсан бодлого, үйл ажиллагааны тасралтгүй үйл явц нь тогтвортой төдийгүй эрх агуулагчдын оролцоог хангах замаар тэдгээрийг эрх мэдэлжүүлж, улмаар тэдний эрх бүрэн биелэгдэх эерэг таатай боломжуудыг бий болгож, улам улам тэлсээр байх тасралтгүй ахиц дэвшил гаргадаг процесс юм.

ХЭСХ - д суурилсан хөгжлийн үр дүнд хүрээлэн буй орчин түүний экосистемд одоо болоод ирээдүйд сөрөг нөлөө гарах үл мөр үлдээгүй байх ёстой, эдийн засгийн салбаруудын төрөл аль болох цөөн биш, үндэсний ажиллах хүч нөөцөө бүрэн дайчилсан байх ёстой, мөн нийгмийн шударга ёс, ёс зүйд тулгуурласан хүмүүнлэг нийгмийг цогцлооход хүмүүс өөрсдөө бүтээлчээр оролцох чадвар боломжийг үүрэг хүлээгчид нь хариуцлагатайгаар хэрэгжүүлдэг байхыг шаарддаг. Энэхүү удирдлагын арга хэрэгсэл нь бүхий л түвшний үүрэг хүлээгчид, улс төрчдийн хувьд амлалтаа хэрэгжүүлэх, олон түмний итгэлийг авах, улс орны хөгжлийг үр дүнтэй урагшлуулах, ОУ - ын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн арга хэрэгсэл юм.

ХЭСХ - ыг нэвтрүүлэх нь нэн түрүүнд дараах ач холбогдлыг үзүүлнэ.

- ХЭСХ нь хүмүүст эрх мэдэл олгодог, оролцоотой зөв төлөвлөлт хийх, нөөцөө тооцохдоо боломжуудыг өргөжүүлдэг үйл явц, мөн иргэдэд эрх мэдэл олгох үйл явцыг аяндаа бүрдүүлж байдаг;





- Орон нутгийн хөгжлийн үйл явцад нутгийн иргэд, нутгийн хамт олон өөрсдөө илүү манлайлагч бүтээлч оролцоотой гол эзэн байх, хөгжлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэхэд үр нөлөөтэй, тогтвортой оролцох, илүү сайжруулах боломжтой болгодгоороо хөгжлийн бодлого зорилтууд үр дүнтэй хэрэгжихэд чухал нөлөө үзүүлнэ;
- ХЭСХ нь нутгийн иргэдэд тухайн орон нутгийнхаа ирээдүйн өмнө хүлээх үүрэг, өнөө үед амьдарч байгаагийн хувьд оноож авсан хариуцлага ухамсрыг төлөвшүүлнэ;
- Хөгжлийн зорилт, шалгуур үзүүлэлт, төлөвлөгөө нь олон улсын хүний эрхийн тогтолцооны түгээмэл стандартад үндэслэсэн тул ХЭСХ нь нийтлэг ойлголт, ил тод байдал, хариуцлагыг эрх агуулагч болон үүрэг хүлээгч аль аль талд адил хүлээлгэнэ. Ингэснээр харилцан ойлголцол, зөвшилцөл, үр дүнтэй түншлэлийг бий болгоно;
- ХЭСХ нь эдийн засаг, нийгмийн эрхийг эерэгээр хүлээн зөвшөөрөх талаарх улс орны сонголтыг онцлох олон улсын механизм (шүүх ба шүүхийн бус) зэрэг эрх агуулагчдын нэрийн өмнөөс иргэний нийгмийг хамгаалах үндэслэлийг бий болгоно;
- ХЭСХ нь олон нийт болон хувь хүмүүст эрхээ тодорхойлох, үүрэг хүлээгчдээс хариуцлагыг шаардах эрх мэдлийг олгоно;
- ХЭСХ нь улс орны бодлогын үйл явц, бодлого, стратеги төлөвлөгөө, санхүүгийн хуваарилалтаас эхлээд төрийн албан хаагчдын сургалт, үйл ажиллагааны үр дүнг үнэлэх хүртэл бүхий л асуудлын нийтлэг, уялдаа бүхий загварыг бий болгоно;
- ХЭСХ нь илүү үндэслэл бүхий дүн шинжилгээний тогтолцоог санал болгодог. Тухайлбал, шийдэх шаардлагатай эсвэл нэн тулгамдсан нийтийн эрх ашиг хөндөж буй асуудлын суурь шалтгааныг олж илрүүлэх түүнийг арилгахад чиглэсэн үйл ажиллагаа алхамуудыг шаарддаг. Ядуурлыг тооцдог уламжлалт арга нь орлого ба эдийн засгийн үзүүлэлтэд үндэслэдэг бол хүний эрхэд суурилсан ядуурлыг тооцох дүн шинжилгээ нь ядуурал бол материаллаг хэрэгцээ гэхээсээ эрх мэдлийн асуудал гэдгийг ойлгуулдаг;
- Эдийн засгийн өсөлт нь дангаараа ядуурлыг бууруулахад хангалтгүй, өсөлт нь тэгш бүс байдлыг багасгах арга хэмжээтэй хамт хийгдэх шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрүүлнэ.




- ХЭСХ нь хувь хүн бүрийн шийдвэр гаргахад оролцох, хэрхэн эрх мэдэлжих, хэрхэн үр дүнтэй хянах, эрхээ шаардах боломжуудыг зааж өгдөг бол, үүрэг хүлээгч төрийн байгууллагын албан хаагчийн юуг, яаж хийх замаар хүний эрхийг биелүүлэх, эрх чөлөөний боломжуудыг хангах замыг заадаг, асуудалд эрхэд суурилсан дүн шинжилгээ хийж сургадаг, суурь шалтгааныг арилгахад бодлого боловсруулах, суурь шалтгааныг эмчлэхэд төсвийг зарцуулах хэрэгсэл болдог ач холбогдолтой юм.

Өөрөөр хэлбэл, өнгөрсөн хугацаанд нийтийн эрх ашиг хөндөгдсөн, ялангуяа нийгмийн эрх мэдэл багатай хэсгийн өмнө тулгарч буй нийгэм, эдийн засаг, соёлын асуудлыг тэдний өмнөөс шийдэх оролдлогууд хийж маш их хэмжээний цаг хугацаа алдаж, асар их хөрөнгө зарцуулж ирсэн ч асуудлууд шийдэгдэхгүй хэвээр байсаар ирлээ. Энэ нь тухайн шийдвэрлэх асуудлынхаа суурь шалтгааныг “эмчлэхгүй”, тухайн бүлгийн оролцоогүйгээр шийдэх гэж оролдсоноос гадна асуудлаас гарсан үр дагавар болон асуудлыг дэмжиж, улам даамжруулж буй нөлөөлөх хүчин зүйлсийг л “эмчилж” ирсэн байна.

Энэ нь ганц манай улсын Засаг төрд тохиолдсон харамсалтай үзэгдэл биш бусад улс орны засгийн газрууд ч энэ алдааг олж харж залруулахыг хичээж байна. Улс орнуудын засгийн газрууд өөр өөрийн арга хэрэгсэл, арга замтай байгаа хэдий ч сүүлийн үед Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүй гэж энэ гарын авлагаар танилцуулж буй удирдамжийн ач холбогдолыг илүүд үзэж түлхүү хэрэглэж байна.

2.5. ХЭСХ-ыг хэрэглээ болгох нь

Хүний эрхэд суурилсан хандлагыг нэвтрүүлэхэд тодорхой хэмжээний бэлтгэл хийх хэрэгтэй байж болох юм. Гэхдээ Монгол улсын хувьд ардчиллын үнэт зүйл нь болох иргэдийн оролцоо, ил тод нээлттэй байдал, хариуцлага шаардаж нэхэх эрх ард түмний мэдэлд хуульчлагдсан явдал нь шууд хэрэгжүүлэх эрх зүйн боломж бүрдсэн гэж үзэж болно.



Харамсалтай нь улс төрчдөд, засаглалын тогтолцоонд өдөр тутмын соёл болж төлөвшөөгүй, нэр төдий оромдох





хэлбэртэй байгаа хэдий ч үүнийг бид шалтаг, шалтгаан болгох ёсгүй. Засгийн газар, төрийн албан хаагчдын хувьд иргэдийнхээ эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлж чадна гэсэн амлалт авсан үүрэг хүлээгчдийн хувьд хойшлуулах, цааргалах эрх байхгүй.

ХЭСХ-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхийн өмнө танай орон нутгийн хөгжилд саад болж байгаа асуудал тус бүрт эрхэд суурилсан хандлагаар дүн шинжилгээ хийх хэрэгтэй.

Энэ нь тухайн асуудал шийдэгдэхгүй, хөгжилд саад болоод байсаар байгаагийн суурь шалтгааныг олох, улмаар түүнийг арилгаж сааруулахад чиглэсэн бодлого боловсруулах, арга хэмжээ авах, зөвхөн суурь шалтгааныг арилгахад зориулсан төсөв гаргах нь асуудлыг шийдэхэд хамаагүй бага хугацаа шаардах бөгөөд илүү үр дүнтэй бодлого боловсруулж хэрэгжүүлэх, асуудлыг арилгах ач холбогдолтой юм.

Үүний тулд асуудлын суурь шалтгааныг олох, асуудалд эрхэд суурилсан хандлагаар дүн шинжилгээ хийх арга зүйд суралцах шаардлагатай юм. Иймд 2 аргачлалыг танилцуулъя.

НЭГ. “АСУУДЛЫН МОД” загвар


Асуудалд дүн шинжилгээ хийх олон төрлийн аргачлал байдгаас энд нийтлэг хэрэглэгддэг үндсэн хоёр аргуудыг орууллаа. Орон нутгийн эсвэл байгууллага, тухайлсан нэг асуудал, иргэдийн түвшинд тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийхэд тохиромжтой аргачлал нь “АСУУДЛЫН МОД” аргачлал юм.

Тухайн асуудлын агуулга, мөн чанар нь нийтийн эрх ашгийн төлөө, нийтийн сайн сайхны төлөө, аймаг, сумын нийт хүн амыг бүхэлд нь эсвэл томоохон төлөөллийн эрх ашгийг хөндсөн бол АСУУДАЛ байдаг. Түүнийг шийдэхийн тулд бодлого, хөтөлбөр, тогтолцооны түвшинд анхаарах хэрэгтэй болдог.

Харин хувь нэг хүн, нэгэн гэр бүлд хамааралтай бол тэр нь БЭРХШЭЭЛ байдаг. Түүнийг шийдэхийн тулд тодорхой чиглэсэн, нэг удаагийн арга хэмжээ хэрэгжүүлэх хэрэгтэй болдог. Энэ ялгаатай байдлыг санаж оролцогчдын дэвшүүлсэн тулгамдсан асуудал нь хэний хэдий хэмжээний хүмүүсийн эрх ашиг хөндөгдөж байна вэ? гэдгийг ялгаж тайлбарлан чиглүүлэх хэрэгтэй.



- ▶ Энэ загвараар тухайн асуудлыг үүсгэсэн суурь шалтгаан юу байна?, АСУУДАЛ нь өөрөө яг юу вэ? Тэрхүү асуудал даамжрахад мөн одоог болтол шийдэгдэхгүй, хүчрэгдэхгүй байсаар байхад нөлөөлж буй хүчин зүйл юу байна?, Энэ асуудлаас үүсч буй нийгэм, эдийн засаг, байгаль орчны үр дагавар нь юу байна вэ? гэдгийг гаргана.
- ▶ Хүмүүс эдгээрийг хооронд нь хольж, ялгаа заагийг харж чадахгүйгээс суурь шалтгаанд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулахаас илүү үр дагавартай ажиллаж их цаг, хөрөнгө, хүчээ үрдэг. Суурь шалтгаан буюу тогтолцооны гажуудлыг засахгүйгээр асуудлыг үр дүнтэй шийдэж чадахгүй юм.



Ингээд нийгэмд бодитой байгаа нэгэн асуудалд эрхэд суурилсан хандлага, арга зүйгээр хэрхэн дүн шинжилгээ хийх талаар тайлбарлая.

Монгол улсад 2000 оны эхнээс хувиараа ашигт малтмал олборлогч, бичил уурхайчин зэрэг нэр томьёо бүхий албан бус ажлын байр бий болж нийгэм янз





бүрээр хүлээж авч байна. Энэ нь цөөн хэдэн сонирхогч иргэдийн гэхээсээ илүү 200 мянган айл өрхийн 100,000 хүний өдөр тутмын хоногийн хэрэгцээг хангадаг гол орлогын эх үүсвэр, амжиргааны орлого болж тогтвортой ажлын байрны хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн байна. Эдгээр иргэдээс төр холбогдох хуулийн дагуу¹⁹ сар бүр 53,000 төгрөгийн орлогын албан татвар авч улсын төсвийн орлогод төвлөрүүлдэг.

Бичил уурхайчдыг Засгийн газраас хүчээр тараах, татан буулгах хэд хэдэн удаагийн арга хэмжээ явуулсан хэдий ч арилсангүй, харин ч ажиллах хүчин улам залуужиж, эмэгтэй эрэгтэй, дээд боловсролтой иргэд ч ажиллах боллоо. Засгийн газраас удаа дараа зохион байгуулалтад оруулах, тодорхой газрыг зөвшөөрлөөр олгож олборлолт эрхлүүлэх зэрэг арга хэмжээг хууль тогтоомжоор хүртэл хэрэгжүүлж ирсэн хэдий ч тийм ээлтэй, үр дүнтэй арга хэрэгсэл, зохистой аюулгүй ажлын байр болгож чадаагүй л байна. Өөрөөр хэлбэл, төрөөс эдгээр иргэдийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтийг ханган хэрэгжүүлэх үүргээ алхам алхмаар авч байгаа ч эрхийн зөрчил гарсаар байна.

Энэ юунд байна вэ? Уншигч та Хүний эрхэд суурилсан хандлагаар шинжилж үзнэ үү? Өөрөөр хэлбэл, дээр өгүүлсэн “хүний эрх, эрх чөлөө” томруулагч шил буюу линзийг зүүж дараах хэдэн асуултад хариулах оролдлого хийнэ үү.

1. Бичил уурхай эрхлэгч 60,000 орчим мянган хүний ажлын байрны асуудал шийдэгдэхгүй байгаагийн үндсэн буюу **суурь шалтгаан** нь юу вэ?
2. Бичил уурхай эрхлэгч 60,000 орчим мянган хүний ажлын байрны асуудал шийдэгдэхгүй байгаад **нөлөөлж байгаа гол хүчин зүйлсүүд** юу юу байж болох вэ?
3. Бичил уурхай эрхлэгч 60,000 орчим мянган хүний ажлын байрны асуудал шийдэгдэхгүй байснаар орон нутаг болоод үндэсний түвшинд үүсч буй **үр дагаврууд** юу юу байна вэ? Тэрхүү үр дагаврууд нь эерэг байна уу? сөрөг үр дагавар байна уу? Магадгүй өнөөдөр эерэг байгаа үр дагавар урт хугацааны дараа сөрөг үр дагавар болж өөрчлөгдөх үү? Өнөөдөр сөрөг байгаа үр дагавар урт хугацаанд сөрөг үр дагавар болох үү?

¹⁹ Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй иргэдийн хувь хүний орлогын албан татвар тогтоох тухай хууль.



4. Энэ асуудлыг шийдэхгүй, асуудал байсаар байгаад **хэний эрх ашиг хамгийн ихээр зөрчигдөж** байна вэ? Зөрчигдөж ирсэн бэ? Энэ асуудал олон хүнийг хамрах үү? Өөрөөр хэлбэл, нийтийн эрх ашигтай холбоотой асуудал мөн үү? Танай нутгийн нийт ажиллах хүчний, хөдөлмөрийн насны хэдэн хүн амыг хамрах, эмэгтэйчүүд, хүүхдүүд хэр байгаа вэ?
5. Эрх нь хамгийн ихээр зөрчигдөж байгаа бүлгийн ямар ямар эрхүүд зөрчигдөж буй, мөн хангагдахгүй байна вэ? **Аль эрх хэрэгжихгүй байгаа нь аль эрхийг зөрчихөд хүргэж байна вэ?** Тухайлбал амьд явах иргэний эрх, амьдралын чанараа дээшлүүлэх эдийн засгийн эрх, сурч боловсрох соёлын эрх
6. Асуудлыг шийдвэрлэхээр гаргасан хууль тогтоомж, Засгийн газрын бодлого, арга хэмжээ нь тэдгээр **иргэдийн эрх, эрх чөлөөг хэр дэмжсэн, эсвэл саад болсон**, тухайлбал ЗГ-ын 308-р журам боловсруулж гаргахдаа тэдгээр иргэдэд мэдээлсэн үү?
7. Тэрхүү бодлого, шийдвэрийг гаргах, арга хэмжээ авахад бичил уурхай эрхлэгчдийн **оролцоог хангасан үү?** Оролцоогоо бий болгох **чадавхийг төрөөс дэмжсэн үү?**
8. **ОУ-ын хүний эрхийн** биллүүдийн хэм хэмжээ, стандарт шаардлагын **хэрэгжилт** байна үү? ХЭТТ-ын 29 болон ЭЗНСЭТП, ИБУТЭТП-ын заалтуудтай жишиж үнэлнэ үү.
9. Бусад нийгмийн бүлгүүдтэй харьцуулахад хүний эрхээ эдлэх байдал, эрх чөлөөг харьцуулан үнэлэх. Ингэхдээ хамгийн багадаа **Үндсэн хуулийн 18 зүйл заалттай** тулган тунгааж үзнэ үү.
10. Энэхүү тулгамдсан асуудлыг шийдвэрлэх **хуулиар үүрэг хүлээгч талууд** хэн хэн бэ? Тэд хариуцлага хүлээсэн үү? Тэднээс **хариуцлага шаардсан үү?** Ямар хариу арга хэмжээ авсан бэ? гэсэн асуултуудад хариулах бөгөөд хамгийн гол нь хариулт нь өөрөө зөв шийдэл гаргахад туслах учраас хийсвэр, хуумгай хандаж болохгүй.

Эдгээр асуултуудад хариулах нь зөвхөн суурь шалтгааныг олох, асуудалд эрхэд суурилсан хандлага, арга зүйгээр дүн шинжилгээ хийх үйл явц юм.




**ХОЁР. “Асуудалд харьцуулсан цогц шинжилгээ хийх” загвар**

Энэ нь орон нутгийн болон байгууллагын түвшнээс арай өргөн, улсын хэмжээний, аймгийн түвшний тулгамдсан асуудал, Засгийн газрын урт хугацааны бодлого, томоохон төсөл хөтөлбөрт чанарын дүн шинжилгээ хийхэд тохиромжтой.

Энэхүү арга нь нийгэм, эдийн засгийн асуудлыг болоод бодлогын дүн шинжилгээ хийх чанарын аргачлал юм. НҮБ-ын Хөгжлийн сан, Байгаль орчин, цөлжилтийн бодлогын асуудлыг шинжлэхэд хэрэглэдэг өргөн хүрээтэй хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал юм.



Байгаль орчин + эдийн засаг + нийгмийн тулгамдсан асуудал болон бодлогын харилцан хамаарал түүнд харьцуулсан цогц шинжилгээ хийх үндсэн аргачлал болдог.





Энэхүү аргачлалаар тулгамдсан, шийдвэрлэх шаардлагатай АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ хийх, энэ асуудлыг зохицуулж буй одоогийн байгаа БОДЛОГОД ДҮН ШИНЖИЛГЭЭ хийхэд дээрх үндсэн таван бүтцээр дүн шинжилгээ хийнэ.

Энэхүү дүн шинжилгээний чанарын аргачлалаар хэрхэн дүн шинжилгээ хийх тухай Нийслэлийн агаар, хөрсний бохирдол, үндны усны аюулгүй байдал гэсэн тулгамдсан гурван асуудалд дүн шинжилгээ хийж үзье.



ЗӨВЛӨМЖ:

- Энэхүү аргачлалаар дүн шинжилгээ хийхдээ оролцооны аргаар хийнэ. Ялангуяа тухайн асуудал шийдэгдэхгүй байхад ямар бүлгийн эрх ашиг ихээр хөндөгдөж байгаа тэдгээрийн оролцоотой хийвэл илүү бодитой, үр дүнтэй дүн шинжилгээ болно;
- Хэрвээ үүрэг хүлээгч төрийн байгууллагын баг, ИТХ-ын төлөөлөгчид дангаар асуудалд дүн шинжилгээ хийх гэж байгаа бол хүмүүсээс, эрх агуулагчдаас мэдээлэл сайн авах хэрэгтэй. Цуглуулсан мэдээллээ дүн шинжилгээ хийх таван бүтцэд хариулт болгохдоо ашиглана. Харин цуглуулсан мэдээлэл судалгаа тань бодит үнэн байх ёстой. Хэдий чинээ бодитой мэдээлэл байна төдий чинээ энэ арга хэрэглэсний ач холбогдол гарна;
- Хэлбэрийн хувьд нээлттэй ярилцлага эсвэл тодорхой асуудлаар, тодорхой зорилтот бүлгийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг хийх хэлбэрийн алинаар ч явуулж болно;
- Мөн энхүү чанарын аргачлалыг байгууллагын стратеги, дээвэр холбоо эвсэл, сүлжээний тулгамдсан асуудал, бодлого хөтөлбөрт, бүр тухайлсан нэг төсөл дээр ч дүн шинжилгээ хийхэд ашиглаж болно. Мөн бизнесийн байгууллага эсвэл ижил зорилготой нэг бүлэгт чиглэсэн асуудлаар ажилладаг төр, ААН, төрийн бүс байгууллагууд стратеги гаргах, бусадтай хамтрах бодлого стратеги гаргахад ч энэхүү аргыг ашиглаж болно.





	Нийслэлийн агаарын бохирдол	Нийслэлийн хөрсний бохирдол	Нийслэлийнхний ундны усны аюулгүй байдал
Асуудал	Агаарын бохирдол хэт аюултай хэмжээнд хүрсэн	Хөрсний бохирдолт аюултай хэмжээнд байгаа	Усны нөөц болон чанар муудаж байгаа
Дарамт болон дадал: ил нөлөөлж буй хүчин зүйлс	- Түүхий нүүрс их шатаадаг - Хуучин машин ихтэй - Мэдлэг зан үйл хандлага - Ядуурал ихээс гэрийн галлагаа	180,000 ил задгай 00 асуудал хэвээр байгаа - Хог хаягдлыг ялгаж хаях, авч устгах тогтолцоо үр дүнгүй	- Усны замбараагүй хэрэглээ - Усны өртөг бага, шударга бус - Төрийн бодлого дутагдалтай
Далд буюу дам нөлөөлөх хүчин зүйлс	- Дэд бүтцийн шийдэл хот төлөвлөлтийн бодлого муу - Гэр хороололд чиглэсэн инженерийн шугам байхгүй - Хүн амын төвлөрөл өндөр - Машины зээлийн шаардлага сул, түүхий нүүрсийг халах технологийн шинэчлэл хийдэггүй - Мэдлэг зан үйл хандлагад нөлөөлөх ажил хийдэггүй	- Ил задгай 00-ыг багасгах төрийн бодлого гаргах, хэрэгжүүлэх төрийн хүсэл эрмэлзэл бага - Иргэдийн оролцоо, хандлага муу - Төв рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөн - Гэр хороололд чиглэсэн дэд бүтэц муу	- Хүн амын болон үйлдвэрлэлийн хэт төвлөрөлөөс үүдэн усны хэрэгцээ өсч байгаа - Бүх хэрэгцээг гүний усны эх үүсвэрээр хангадаг - Зөвшөөрөлтэй зөвшөөрөлгүй гүний худаг ихээр ашигладаг
Үр дагавар:	урт хугацааны эерэг Улс төрчдийн анхаарлын төвд тогтмол байдаг асуудал	- Дэд бүтэц замд хөрөнгө оруулж тэлж байгаа - Усны даац, нөөцөд таарсан хот төлөвлөлт эхэлж байна	- Дагуул хотууд байгуулагдана - Орон нутаг руу чиглэсэн суурьшил бий болно



Үр дагавар:	урт хугацааны сөрөг	- Хүний эрүүл мэндийг доройтуулж байна - Байгаль орчин хорт бодис нь Ургамал амьтан мутаци үүсгэх - Төсөл хөтөлбөрүүд нь эдийн засгийн хувьд ирээдүйд өр нэмэгдүүлэх	- Хүн амд урт хугацааны суурь өвчнүүдийн эх үүсвэр болох - Хөрсний бүтэц, чанарт сөргөөр өөрчлөлт орно - Хотын хөрсний даац дийлэхгүй болж байна	2020 онд 1,5 сая хүн амын усны нөөц хүрэлцэхгүй - Түүл голын усны түвшин багасна - Ундны усны аюулгүй баталгаат байдал алдагдана
	богино хугацааны эерэг	- Гэр хорооллыг орон сууцжуулах ажил эхэлж байна - Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд хөрөнгө босгох боломжтой	Орон сууцжуулах ажил эхэлж байна	ОУ-ын төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж, доноруудаас зээл тусламж авснаар зохих үр дүн гарна
	богино хугацааны сөрөг	- Үзэгдэх орчин муугаас осол аваар ихсэх - Төслийн мөнгийг завших, асуудлаар мөнгө угаах, хээл хахууль бий болгож байгаа	- Бодлого төсвийн үр ашиг, зориулалт муу - Хүн амын эрүүл мэндэд ялангуяа хүүхдийн эрүүл мэндэд сөргө нөлөө үзүүлж байна.	- Усны үнэ нэмэгдэж ард иргэд ачаа үүрнэ - Усны хэрэглээгээ багасгах шаардлага гарна
Хариу арга хэмжээ, шийдэл		- Олон нийтийн оролцох, хяналт тогтоох мэдлэгийг дээшлүүлэх, хандлага зан үйлийг өөрчлөх - Төрийн бодлого оновчтой болоход иргэд нөлөөлөх - Сайн санаачлага, технологи импортлогч, туршлагыг дэлгэрүүлэх, урамшуулал - Ногоон хөгжил, ногоон эдийн засаг, ногоон бизнесийг дэмжих - Төрийн бодлого суурь шалтгааныг арилгахад чиглэгддэггүй, зөвхөн үр дагаварт чиглэдэг	- Хот төлөвлөлтийн бодлогыг хөрсний даацад тохируулан төлөвлөх, дагуул хот байгуулах - Хотын дотор ялгамжтай бодлого явуулах СХД болон Гандангийн дэнжийн бодлого төлөвлөлт ялгамжтай байх гэх мэт - Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх - Хот хөдөөгийн ялгамжтай байдлыг арилгах - ОУ-ын туршлага судлах, стандартад нийцсэн хот төлөвлөлтийн бодлого хэрэгжүүлэх - Хогийн зохистой менежмент	- Гүний усны хэрэглээг багасгах - Саарал усыг хэрэглэх - УБ-д гадаргын болон хурын усыг ашигладаг болох - Усны хэрэглээгээр нь төлбөр тооцох, бохирдуулсан усны төлбөр нэмэгдүүлэх - Хүн амын төвлөрлийг сааруулах - Иргэдийн ухамсар хандлагыг өөрчлөх



Суурь шалтгааныг зөв олж тогтоож чадвал цаашид эрхэд суурилсан хандлага түүний зарчмуудад нийцүүлэн асуудлыг үүсгэсэн суурь шалтгааныг арилгах, нөлөөлж буй хүчин зүйлсийг сааруулах бодлого боловсруулж хэрэгжүүлснээр асуудлаас үүссэн үр дагаврууд аажимдаа багасна гэж үздэг. Асуудлыг үүсгэсэн суурь шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлсийг арилгахад чиглэсэн бодлого хөтөлбөрийг ОУ-ын хүний эрхийн биллүүдэд үндэслэн тогтвортой хөгжлийн үзэл санаанд нийцүүлэн, ногоон эдийн засгийн чиг баримжаатай шийдлүүдийг боловсруулахдаа хамгийн гол нь эрх ашиг нь хамгийн ихээр зөрчигдөж буй бүлгийн иргэдийн оролцоотой боловсруулах нь үр дүнтэй.

Энэ үйл явц нь тэдгээр иргэдийг эрх мэдэлжүүлэх бөгөөд хүний эрхийг баталгаажуулсан, зөрчигдөхөөс хамгаалсан, шийдвэрүүд гарч хэрэгжсэнээр талуудын оролцоо, хамтын хүчээр тогтвортой хөгжилд хүрэх чухал ач холбогдолтой юм.

Төрийн албан хаагчид, ажил олгогч эзэд хүний эрх, эрх чөлөө болон хүний эрхийн мэдлэг, мэдрэмж, хандлагаа төлөвшүүлэхэд хүний эрхийн өнцгөөс дүн шинжилгээ хийж, улмаар шийдвэр гаргаж, бодлого боловсруулахдаа байнга ашиглаж хэрэглээ болговол, ҮР ДҮНТЭЙ, ХҮНДЭЭ ХҮРСЭН, УДААН ХУГАЦААНД ҮРГЭЛЖИЛСЭН, ХАРИЛЦАН АШИГТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА болж чадна.



БҮЛЭГ

3

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БА ХҮНИЙ ЭРХ





3.1 Тогтвортой хөгжлийг эрхэд суурилсан хандлагаар хэрэгжүүлэх нь

Монголын ард түмэн олон зууны тэртээгээс байгалийн эрхшээлд амьдарч, өдөр тутам унаган байгальтайгаа харьцаж, байгаль орчноо унаган төрхөөр нь авч үлдсэн цөөхөн улс орны нэг билээ. Өөрөөр хэлбэл, монголчуудын хувьд экологийн боловсрол, ногоон эдийн засаг, тогтвортой хөгжил нь цоо шинэ зүйл биш юм.



Арван гуравдугаар зууны үед Эзэн богд Чингис хааны “Их Засаг” хуульд газар, ус, бэлчээрийг зохистой ашиглах, байгалийн хэв, онгон төрхийг хадгалах, ариун тунгалаг байлгах үзлийг төрийн бодлогын түвшинд гаргаж “Хэн ус руу шээвээс, өвс ургасан хойно газар нүхэлвээс, гал алдаж бэлчээр шатааваас цаазална” хэмээсэн нь байгаль хамгаалахад хичнээн их анхаарч хууль цааз зөрчигчдийг хатуугаар цээрлүүлэн шийтгэж байсныг гэрчилнэ.

Мөн арван долдугаар зууны “Монгол Ойрадын хууль”-д байгалийн баялагийг ашиглах, байгаль хамгаалах хэм хэмжээг тогтоож гал түймрийг унтраах, ус үерийн аюулаас хүний амь аварсан хүнийг шагнаж урамшуулах журмыг анх удаа хуульчилсан бол 1709 оны “Халх Журам” хуулиар суурин газрын ногоон бүсийг анх удаа тогтоож, ногоон бүсийн дотор мод огтлох, ан амьтан агнахыг хориглож, бүсийн харуул хамгаалалтын үүргийг тодорхойлж, усыг бохирдохоос хамгаалах, усыг зохистой зөв ашиглах, худаг гаргасан хүнийг шагнах эрхийг анх удаа хуульчлан баталж байжээ.



“Байгаль орчныг хамгаалах” гэдэг ухагдахуун нь монголчуудын хувьд, түүнийг гаднын ямар нэгэн хүч нөлөөнөөс халхалж хаацайлахын нэр бус, эвдрэл доройтолд орсных нь дараа нөхөн сэргээх арга замыг сүвэгчлэхийн ч нэр бус, харин тэрхүү болзошгүй доройтлоос урьдчилан сэргийлэх; байгалийн зүйд захирагдан, байгаль орчинтойгоо ухаалгаар зохицон амьдрах; газар дэлхийгээ ээжтэйгээ зүйрлэн, хүндэтгэн дээдлэх; түүнд хүмүүнлэг сэтгэлээр хандан, амьтан ургамлыг нь энэрэн хайрлах; экологийн өндөр ёс зүйтэй байж нөөц баялгийг нь ариглан гамнахын нэр байж иржээ²⁰.

²⁰ Байгаль орчныг хамгаалах Монголын өв уламжлал” нийтлэл. А.Өэлүн. ШУТИС, БИАС-н Архитектурын профессорын багийн ахлах багш, магистр.





Эдгээр хууль цаазын баримт бичгээс байгалийн нөөцийг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, байгаль орчинтой зүй бус харьцагчтай хариуцлага тооцох, мөн урамшуулах цогц харилцааг нарийн зохицуулж ирсэн эртний уламжлалт бодлоготой байсныг харж болно.

Хүн төрөлхтөний зэрлэг амьтнаас ялгагдах онцлог нь өөрийн амьдрах орчноо амар амгалан байлгаж, ирээдүйгээ ухамсартайгаар төлөвлөж, байгаа бүхнээ ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх гэсэн чин эрмэлзэл, хүсэл тэмүүлэл юм²¹. Иймээс өнөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг төлөвлөж зохион байгуулахдаа одоо үе болон хойч үед ээлтэй, аюулгүй байгаль орчин, хүний эрхэд ногоон үл мөр бүхий эдийн засаг, тэгш эрх, шударга ёс зүйтэй нийгмийн хөгжлийг тэнцвэртэй хангаж аль нэгийг хоёр гуравдугаарт тавилгүй, аль нэгийг нь илүү авч үзэлгүйгээр эдгээрийг тэгш хангаж чадсан хөгжил нь өөрөө тогтвортой хөгжил болох юм.



Монгол улс тогтвортой хөгжлийн талаар ...

Монгол улсын хувьд тогтвортой хөгжилд хүрэх, ногоон эдийн засагт шилжихийн тулд тодорхой зорилго, зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Ногоон хөгжлийн бодлогыг улс орны хөгжлийн тулгуур бодлогын нэг болгох”, ногоон хөгжлийн үндсийг бүрдүүлэн ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулж загваруудыг бий болгохоор заасан.

Монгол Улсын Их Хурлын 2014.06.13 өдрийн хуралдаанаар “Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр батлах тухай” тогтоолыг хэлэлцэн баталжээ. Ногоон хөгжлийн үзэл баримтлалд а) Уур амьсгалд зохицсон хөгжил, б) Ногоон эдийн засаг ба санхүүжилт, в) Ажил, орлоготой ард иргэд бүхий тэгш нийгэм, г) Соёл ба өв, д) Тогтвортой хөгжилд хүрэх засаглал гэсэн таван үндсэн чиглэлээр найман зорилго бүхий 39 зорилтыг тусгажээ. Ногоон хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрт 2020 он хүртэл түүнийг хэрэгжүүлэх бодлогын болон үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон байна. Үүнд:

- Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон нүүрстөрөгч багатай хөгжлийн эхлэлийг тавих;
- Эрчим хүчний хангамжид сэргээгдэх эх үүсвэрийн эзлэх хувийг нэмэгдүүлэх;
- Дотоодын түүхий эд, нөөцийг боловсруулах болон ашигт малтмалын бус эдийн засгийн салбарыг төрөлжүүлэн хөгжүүлэх;
- Усан хангамж, ариун цэврийн болон байгальд халгүй, нөөцийн үр ашигтай, эрчим хүч, зам тээвэр, барилга зэрэг дэд бүтцийн хангамжид оруулах ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Байгаль орчинд халтай бараа, үйлчилгээний үйлдвэрлэл, хэрэглээг бууруулах зорилт, үйл ажиллагаа, зах зээлийн зохицуулалтыг тусгасан байна.

²¹ Тогтвортой хөгжил, Г. Гансүх . 2014 он



Монгол улсын нийгэм, эдийн засгийн голлох салбар нь уламжлалт нүүдлийн мал аж ахуй, газар тариалан, онгон байгаль, нүүдлийн мал аж ахуй, нүүдэлчин угсаатны түүх соёлд түшиглэсэн аялал жуулчлал байсан бол 1990-ээд оны эхнээс уул уурхайн салбар хүчтэй нэмэгдэж орж ирсэн. Энэ нь Монгол улсын хувьд эдийн засгийн шинэ төрөл нэмэгдсэн сайн зүйл хэдий ч эдгээр нь бүгд газарт түшиглэсэн харилцан эрс тэс өөр өөр ашиг сонирхол, өөр өөр үр дагавар бүхий салбарууд юм.

Тухайлбал, мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал нь газрын унаган төрхийг өөрчилдөггүй, өнгөн хөрсний үржил шим, унаган төрхийн давуу байдлыг ашиглах замаар үйл ажиллагаа нь явагддаг, олон хүнийг ажлын байраар хангадаг, үр ашгийг олон хүн хүртдэг салбарууд. Харин уул уурхайн салбар нь эдийн засгийн уламжлалт салбаруудын үйл ажиллагаа явагдаж буй газар дээр давхцан ажиллахдаа газрын унаган байдлыг өөрчлөх замаар газрын хэвлий дэх баялагийг ил гаргаж ашиг олдог, ажиллах хүч шингээх боломж бага онцлог салбар юм.

Гэсэн хэдий ч Засгийн газрын 1993 оны «Алт» хөтөлбөрийг эхлүүлсэн уул уурхайн бодлого нь 1990-ээд оны шилжилтийн үеийн эдийн засгийн огцом уналтын үед улс орны эдийн засгийг хямралаас гарахад чухал нөлөө үзүүлсэн салбар. Гэхдээ засгийн газар гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах үүднээс татварын ээлтэй бодлого гаргаж үйл ажиллагаа явуулж байгаа эхний 5 жилд татвараас чөлөөлөх зохицуулалт хийхдээ хяналт, хариуцлагын тогтолцоог сүлрүүлснаас татварын орлогоо бүрэн авч чадаагүй сургамж бий. Тухайлбал, Бороо гоулд ХХК- эхний таван жилд нийт олборлолтынхоо 80 шахам хувийг олборлож татвараар дамжуулан авах ашгаа Монгол улс бүрэн хэмжээгээр авч чадаагүй гашуун сургамж манайд бий.

2014 оны 06 сарын 10 ны байдлаар улсын хэмжээнд ашигт малтмалын ашиглалтын 1335, хайгуулын 1492 нийт 2827 тусгай зөвшөөрөл 12 349,5 мянган га талбайд буюу нийт нутгийн 7,9% д олгогдсон бол газрын тос 21 талбайд, цөмийн энергийн 20 гаруй тусгай зөвшөөрөл тус тус үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр тусгай зөвшөөрлүүд нь нийт 22 аймгийн 227 сумын нутагт байрлаж байгаа бөгөөд эдгээрээс хамгийн олон лицензтэй 10 аймгаар Төв (373), Дорноговь (339), Өмнөговь (248), Улаанбаатар (183), Сэлэнгэ (183), Хэнтий (170), Дундговь (168), Баянхонгор (151), Дорнод (143), Говь-Алтай (134) тус тус эзэлж байна²².

²² http://www.mram.gov.mn/index.php?option=com_content&view=category&layout=blog&id=14&Itemid=34&lang=mn






Эндээс харахад олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаа засаг захиргааны анхан шатны нэгжийн нутаг дэвсгэрт сум сууринтай, нүүдлийн уламжлалт соёл, малчдын амжиргааны эх үүсвэр болсон малын бэлчээр, улсын тусгай хамгаалалттай газар нутаг зэрэг хүмүүсийн амжиргаа, өрхийн бизнес, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хөндөж тэдгээртэй зэрэгцэн явагддаг байна.

Монгол улсад тогтвортой хөгжлийг хангахад нэн түрүүнд эдийн засгийн гол салбаруудыг хэрхэн зэрэгцүүлж хөгжүүлэх, салбарууд харилцан нэг нь нөгөөгөө дэмжиж хөгжих, ингэхдээ хүмүүсийн эрх, эрх чөлөөг хөндөхгүй харин ч бүрэн хангаж хамгаалсан байх, түүнийг хэрэгжүүлэх үйл явц, үлдээх үл мөр нь одоо болоод ирээдүй үед халгүй байх төрийн зохистой бодлого, тогтолцоо шаардлагатай юм.

Тэгвэл, тогтвортой хөгжлийг төр дангаараа бий болгохгүй, харин төр тогтвортой хөгжлийг бий болгох шийдэл шийдвэр гаргахдаа хүний эрх, эрх чөлөөг бүрэн эдлэх боломжийг бүрдүүлэх төрийн үүргээ хэрэгжүүлэх, бодлого хөтөлбөрөө хүний эрхэд суурилсан хандлагын үндсэн зарчмуудыг баримтлан боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц бүртээ тэрхүү зарчмуудыг мөрдөж хэрэгжүүлэх шаардлагатай болж байгаа юм.



Уул уурхайн яам санаачлан “Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хууль”²³-ийн төсөл боловсруулж УИХ-д өргөн барьсан²⁴.

²³ Нөөц баялаг ихтэй улс орнуудад хэргэждэг олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага гэж байдаг бөгөөд тус санаачлага нь уул уурхайн компани засгийн газрын байгууллагуудад төлсөн төлбөр хураамжаа нээлттэй тайлагна, Засгийн газрын байгууллагууд нь хэдий хэмжээний орлого, төлбөр хүлээж авснаа нээлттэй тайлагнах, үүнд хөндлөнгийн аудитын компани тулгалт хийх энгийн зарчимтай санаачлага юм. Дэлгэрэнгүй мэдээллийг www.eitmongolia.mn www.pwyr.mn сайтуудаас үзнэ үү

²⁴ <http://www.parliament.mn/news/info/categories/210/pages/17059>



Тус хуулийн үзэл баримтлалд: ... Монгол Улсын нийгэм, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжилд эрдэс баялгийн салбарын зүгээс үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх нь зүйтэй.... эрдэс баялгийн салбар нь манай улсын эдийн засгийн хөгжлийн тулгуур салбар болох тул уг салбар дах шаардлагагүй зардлыг бууруулах, улмаар уг салбараас олж байгаа орлогыг оновчтой байдлаар зарцуулах, үүний тулд нийгэм, эдийн засгийн зохистой тогтолцоог бий болгоход энэхүү хуулийн хэрэгжилт чухал ач холбогдолтой. Тодруулбал, энэхүү хуулийн төслийг батлан хэрэгжүүлэх нь цаашид эдийн засгийг төрөлжүүлэх, баялагийн хараалаас зайлсхийх, авилга, үргүй зардлыг бууруулах зэрэг зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд чухал үр нөлөө үзүүлэх юм... гэжээ

Энд тодорхойлсныг хүний эрхэд сурилсан хандлага, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн дүн шинжилгээ хийж үзэхэд, эрдэс баялгийн салбарын тогтвортой хөгжилд үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэх гэж тодорхойлсон нь сайн хэдий ч цаашид зөвхөн уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн хөгжлийг дэмжих, үүний тулд нийгэм, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх бодлогуудыг хэрэгжүүлэх юм байна.

Эдийн засгийг төрөлжүүлэх гэсэн сайн хэллэг хэдий ч уул уурхайтай зэрэгцсэн эсвэл газар нь давхардан олгогдсон²⁵ ХАА-н салбарын хөгжлийг дэмжихээсээ илүү харин, эрдэс баялагийн салбарт боловсруулах, хайлуулах, нефтийн зэрэг хүнд үйлдвэрүүдийг бий болгох замаар эдийн засгийг төрөлжүүлэх бодлого байгааг харж болно. Мөн баялагийн олборлолт, борлуулалтаас орох мөнгөн хөрөнгийг ирээдүй үед болон хөгжилд зарцуулах бус өнөөдрийн үргүй зарцуулалтыг бууруулах, **оновчтой зарцуулах** гэж томъёолсон нь бүхэлдээ уул уурхайн салбарыг тэргүүлэх зэрэгт тавьж хөгжүүлэх, эдийн засгийн орлогын эх үүсвэр гэж үзэх, салбараас олсноо зарцуулах бодлого баримтлахаар тусгажээ.

Байгалийн баялаг бол бүх ард түмний эрх мэдэлд байгааг Үндсэн хуулиар баталгаажуулсан, энэ утгаар байгалийн баялаг нь нийтийн өмч, үе хоорондын баялаг. Тиймээс төр ард түмний эрх мэдлийн, нийтийн баялгийг ашиглаж эдийн засгийн эх үүсвэр үүсгэх гэж байгаа тул зайлшгүй олон нийтийн оролцоог хангах, улмаар тэдний зөвшөөрлөөр ашиглах учиртай.

²⁵ Иргэн бүрт Газрын тухай хуулийн 52-р зүйлд зааснаар малчин хүн 60 жилийн хугацаатай өвөлжөөний доорх газрыг эзэмших эрхээр авсан бол тэдгээртэй давхцуулан Ашигтмалтмалын тухай хуулиар уул уурхайн лиценз /30+30+30/ нийт 90 жилийн хугацаатай олгогдсон байдаг.





Байгалийн баялгийг ашиглах бол баялгийн эзний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хөндөхгүй байх, баялгийн эзний ая түхтай айх аюулгүй амьдрах, амьдралын чанарыг сайжруулсан тасралтгүй, тогтвортой хөгжлийг бий болгоход л нөөцийг зарцуулах бодлого зохицуулалт гаргах учиртай. Харин энэхүү хөгжлийг бий болгох эдийн засгийн эх үүсвэр нь байгальд “ногоон” зам мөртэй хөрөнгө байх ёстой. Эдгээр ХЭСХ-ын болон тогтвортой хөгжлийн зарчим, үзэл санааг тус хуулийн үзэл баримтлалд тусгаагүй байна гэж үзэхээр байна.

Яагаад?

тогтвортой

хөгжил

гэж

Байгалийн нөөцийг яах гэж олборлож ил гаргадаг вэ? Мэдээж хөгжил болгох, хөгжлийн санхүүгийн эх үүсвэр болгох гэж хэн ч хэлнэ. Тэгвэл хөгжил гэж юу вэ? Байгалийн нөөцөө ил гаргах гэж хөрөнгө оруулагчдыг татах замаар олсон бонд, зээл, урьдчилгаа төлбөр бүхий эдийн засаг уу? байгаль орчин, хүмүүсийн эрх, эрх чөлөөг эрсдэлд хүргэх үйл явц, арга замтай эдийн засаг уу? Өндөр байшин, гудамж талбай юу?

Тэгвэл хөгжил гэдгийг НҮБ-ын хөгжих эрхийн тунхаглал баримт бичигт ийнхүү тодорхойлжээ.



“Хөгжил гэдэг нь нийт иргэд, хувь хүмүүсийн идэвхитэй, чөлөөт оролцоонд үндэслэн нийгэмд бий болж буй үр ашгийг шударгаар хуваарилах, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм соёлын цогц үйл явц мөн”.

НҮБ-ын “Хөгжих эрхийн тухай тунхаглал

Харин ард түмэн, хүн бүр эрх, эрх чөлөөгөө бүрэн дүүрэн эдлэх хүмүүнлэг, шударга нийгэм бий болгохыг хүсч байгаа, хувь хүн бүр хөгжих эрхээ эдлэх боломж бүрдсэн ногоон эдийн засгийн эх үүсвэрт үндэслэсэн тогтвортой хөгжлийг хүсч байна. НҮБ-ын хөгжих эрхийн дээрх тодорхойлолт л ард түмний хүсч буй хөгжлийн зураг.



Байгалийн баялаг ялангуяа эрдэс баялгийн нөөц дуусдаг, шавхагддаг баялаг. Энэ утгаараа эрдэс баялгийг олборлож буй үйлдвэрлэл хэзээ нэгэн цагт дуусч хаагдахад аймаг, сум нь тогтвортойгоор хөгжиж чадсан байх ёстой юм. Өөрөөр хэлбэл, хүн мал амьдарч болох аюулгүй газар нутагтай, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчсөн, зөрчих үл мөр үлдээгүй байх, орон нутаг ногоон эдийн засагтай, бусад салбарыг зэрэгцүүлэн хөгжүүлж үлдсэн байх буюу орон нутаг эдийн засгийн бие даасан, тогтвортой орлогын чадавхтай болсон байх ойлголт юм. Энэ бол уул уурхай дагасан хөгжил юм.



2013 оны байдлаар уул уурхайн салбар улсын ДНБ-ний 18 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 59 хувь, экспортын орлогын 88 хувийг²⁶ тус тус бүрдүүлж байгаа бөгөөд 2004 онтой (ДНБ-ий 5 хувь байсан) харьцуулвал ДНБ-нд эзлэх хувь нь гурав дахин өссөн үзүүлэлт юм. Энэ нь гэнэтийн ашгийн татварыг авах болсон, мөн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлттэй холбоотойгоор компаний ашгийн татвар өссөнтэй холбоотой. Харамсалтай нь энэ үед Монгол улс нөөцийн сан хуримтлал үүсгэж чадаагүй. Засгийн газрын зардал огцом өссөн ба энэ нь урсгал зардал, нийгмийн халамжийн шилжүүлэг, мөн хөрөнгийн зардал нэмэгдсэн байдаг.

Мөн энэ хугацаанд уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр Өвөрхангай-545,8 га, Дундговь -433,3 га, Хэнтий-398,3 га гэх мэт нийт нутагт 17,343,6 га талбай нөхөн сэргээгдээгүй буюу нөхөн сэргээх тодорхой “эзэнгүй” үлдсэнийг БОНХЯ-ны 2011-2012 оны тайланд дурьджээ. Мөн энэхүү тайланд “...ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн усан сан бүхий газар 58,7 га бол энэ нь Говь-Алтай, Ховд, Хөвсгөл, Төв, Завхан аймагт илүүтэй байна” гэжээ.

Эндээс үзэхэд олборлох үйлдвэрлэлийн хариуцлагагүй үйл ажиллагаанаас болж байгаль орчин экосистемийн доройтол үүсэх, хүмүүсийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх ялангуяа ХАА-н салбарт ажиллагсад, ӨАА эрхлэгчдийн эдийн засаг, нийгэм, соёлын эрх зөрчигдөхөд шууд нөлөөлдөг төдийгүй удаан хугацаанд “хар мөр” болж үлдсэнээр орон нутгийн хөгжлийг тогтворгүйжүүлж тасалдуулахад хүргэдэг гашуун сургамжийн бодит жишээ энэ.

²⁶ мөн тайлан 23-р тал





Хөгжлийн гол үзүүлэлт ДНБ-д эзлэх хувь хэмжээ, уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй аймаг, суманд ямар байгаа вэ? Үндэсний хэмжээний үзүүлэлттэй адил өссөн үү? Магадгүй үндэсний том эрх ашгийн төлөө орон нутгийн тогтвортой хөгжил болон нутгийн иргэдийн эрх ашиг золиослогдож хохирч байхыг үгүйсгэхгүй. Нөөц баялаг ихтэй улс оронд хөгжил муу төдийгүй хөгжлийн явц хэт удаан, байгаль орчны нөхцөл доройтдог, авилга өндөр, хүмүүс ядуу, ажилгүйдэл өндөр байдгийг олон орны жишээгээр дурьдаж болно. Үүнийг “нөөц баялгийн гаслан буюу баялагийн хараал” гэж нэрлэх нь бий. Харин үүнтэй адил улс орны дотор нөөц баялаг ихтэй аймаг, сумдад энэ үзэгдэл байж болох юм.

Жишээ нь: хөдөөд нийслэлээс ядуурал өндөр, ажилгүйдэл их байгааг дараах мэдээлэл харуулж байна. Ядуурал нь орлогын хомсдол, материаллаг зүйлсээр хэмжигдэхээс гадна хүмүүс амьдралдаа сонголт хийх бололцоо, боломж, эрх чөлөөгөөр гачигдаж байгаагаар авч үздэг.

Ядуурал болон ажилгүйдэл хот, хөдөөгөөр- 2010-2012 оноор²⁷

	Ядуурлын түвшин -хувиар			Ажилгүйдлийн түвшин –хувиар		
	2010	2011	2012	2010	2011	2012
Үндэсний дүн	38,7	33,7	22,7	9,9	7,7	8,2
Баруун бүс	52,6	40,3	32,5	10,1	10,8	9,8
Хангайн бүс	52,0	49,1	38,6	11,9	8,3	8,3
Төвийн бүс	29,8	28,2	28,1	9,3	6,8	7,7
Зүүн бүс	42,4	40,1	33,3	10,5	11,1	10,8
Улаанбаатар	31,0	25,7	19,8	8,7	5,6	7,1

Уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа нэмэгдэхийн хэрээр байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл мөн нэмэгддэг. Монгол улсын хувьд орон нутагт хүмүүсийн амьдрах орчны чанар муудсан, өрхийн орлогын эх үүсвэр хомс болж хүмүүс нийслэл, төвийн бүсэд хэт олноор амьдрах болж байна. Нийслэл Улаанбаатар хот нийт газар нутгийн ердөө 0,3 хувийг эзэлдэг бөгөөд энд нийт хүн амын 70 шахам хувь оршин сууж нэг ам дөрвөлжин км газарт 247 хүн оногдож

²⁷ МХЗ-уудын үндэсний 5-р илтгэл 2013. 53-р тал



байгаа бол хөдөө орон нутагт дунджаар 1,7 хүн оногдож байгаа нь хөдөө орон нутаг жилээс жилд улам бүр эзэнгүйдэж байгааг нотлоно²⁸. Тэнд хүмүүс амьдрах ая тухтай орчин байхгүй, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар муу байна гэсэн үг. Үүнээс үүдэн хөдөөд хүн цөөрөх нь одоогийн мөрдөж буй Төсвийн тухай хуулиар бага төсөв оногдоход нөлөөлнө. Нийслэл хэт их төсөвтэй болох хэдий ч хүмүүст хүргэх төрийн үйлчилгээг тэгш шударга хүртээхэд бэрхшээл учирна. Харин хөдөөд ОНХС-аар дамжуулан орон нутагт өгч буй санхүүжилтийн үр дүн, нөлөө багасна. Хүнгүй газар бид бүтээн байгуулалт хийх хэрэгтэй юу, үгүй юу гэдэг сонголтын өмнө ирнэ.

Байгалийн баялагаа хөгжил болгож чадсан цөөхөн орны нэг болох Норвеги улсын Газрын тосны агентлаг 2012 онд гаргасан баримт бичигтээ “Норвегийн байгалийн баялгаас олсон орлого бол ард түмний өмчөөр баяжих гэсэн цөөн хүмүүсийнх биш, харин Норвегийн бүх ард түмний орлого мөн”²⁹ гэжээ. Үүнийг нь Норвегийн парламент хуульчлан баталгаажуулсан байна.

Тогтвортой хөгжил гэдэг нь зөвхөн эдийн засгийн өсөлт биш гэдгийг олон улс орон алдаанаасаа олж харсан бөгөөд “баялагийн гаслан, голланд өвчин” гэх гашуун сургамжид үндэслэн 1992 оны Рио-Де-Жанеро хотноо болсон НҮБ-ын гишүүн 180 гаруй орны төр засгийн тэргүүнүүдийн дээд хэмжээний чуулга уулзалтаас а) эдийн засгийн хөгжлийг байгалиас салангид авч үзэх нь дэлхий ертөнцийг цөлжих болон бусад тэнцвэрт байдлыг алдагдуулахад хүргэнэ. б) эдийн засгийг хөгжүүлэлгүйгээр дан ганц экологийг түших нь ядуурал, үе хоорондын шударга бус явдлыг нэмэгдүүлнэ. в) Харин энэ хоёр ойлголт байр суурийг цугт нь тэнцвэртэй авч явах, ингэхдээ нөөцийг хөгжил болгох хүний эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлж ая тухтай, сайн сайхан амьдрахад олборлосон нөөцийг зарцуулах нь ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ гэж үзэн дэлхий нийтээр даган мөрдөж байна.

Тогтвортой хөгжил гэдэг нь зөвхөн энэ үеийнхэн бүх нөөц боломжуудаа шавхаад, хойч үеийнхний сонголт хийх, хөгжлийн боломжуудыг хязгаарлахгүй байх, үе хоорондын хариуцлагад суурилсан зарчимтай бөгөөд Монгол улс тогтвортой хөгжлийн энэхүү үзэл баримтлалыг баримталж байгаа хэдий ч бодит байдал дээр

²⁸ “Хөдөөгийн зэргүйрэл ба хүн амын бодлого” илтгэл. Хил хязгааргүй алхам. Эмэгтэйчүүдийн нүдээр VIII чуулган 2014 он.

²⁹ “Монголоо ямар улс болгох, хэрхэн түүнд хүрэх вэ” 43-р тал. 2014 он. Сайнхүүгийн Ганбаатар





байгаль орчин, экосистемийг хамгаалах асуудал орхигдон зөвхөн эдийн засгаа хөгжүүлж байна.

ЯАГААД ? ногоон эдийн засагт тулгуурласан тогтвортой хөгжил гэж ?



Ногоон эдийн засгийг хэрэгжүүлэгч ямар ч төр засаг, байгууллага, хувь хүн одоогийн болон ирээдүйн үеийн ард түмний сайн сайхан аж байдалд анхаарах ёстой. **Ойрын зорилго** нь одоогийн болон ирээдүйн экологийн бүрэн бүтэн байдлыг хөндөлгүйгээр эдийн засгийн өнөөгийн хэрэгцээг хангах замаар эдийн засгийг экологийн хувьд илүү үр ашигтай болгох бол, **алсын зорилго** нь бүхий л үеүдэд хүмүүсийн хэрэгцээг хангаж, тогтвортой хөгжиж чадах тийм арга замаар хүрэх явдал юм.



Дэлхий дээр хэдийгээр олон улс орон оршин байж, өөр өөрийн хэл, хууль дүрмээр амьдарч, янз бүрийн төвшний хөгжилтэй байгаа ч бид нэг л дэлхий дээр амьдарч байгаа хүмүүс. Дэлхийн хүмүүс бид нэг дэлхий дээр амьдарч байгаа учраас эв санааны нэгдэлтэй байх төдийгүй харилцан хоорондоо, улс дотроо, үе хооронд хариуцлагатай, шударга, ёс зүйтэй байх ёстой. Байгалийн нөөц нь дэлхийн экологийн үйл явцаар, удаан хугацаанд бий болдог баялаг тул байгалийн бүх нөөцийг өнгөрсөн, одоо, ирээдүй нэг үеийн өмч бус харин бүхий л үеийнхний



өмч, нийтийн эрх мэдлийн нөөц гэж үзнэ. Хэрэв хэн нэг хүн эсвэл бүлэг хүмүүс эдгээр нийтийн мэдлийн, нийтийн нөөц баялагаас хууль бусаар, эсвэл экологид халтай байдлаар эсвэл хүмүүсийн эрх, эрх чөлөөнд арилшгүй ул мөр үлдээж, эсвэл нөөцийг мөнгөн болон мөнгөн бус хэлбэржсэн үед нь шударга бусаар хувиарласан, завшсан бол дэлхийн бүх хүмүүсийн хүний эрх, эрх чөлөөнд халдсан гэж үзэх үндэслэл болно.

Ингэхдээ харин тогтсон нэг хандлага, чиг баримжаа, зарчимтай байх үүднээс төрийн тэргүүнүүд тодорхой хугацаанд уулзалдаж хөгжлийн бодлого хөтөлбөрүүдийг боловсруулан, улс орон бүр даган мөрдөх амлалт үүргийг авч, хариуцлага хүлээдэг. Эдгээрээс нэн түрүүнд байгаль орчин, экологийн асуудлаар “тогтвортой хөгжил”, “ногоон эдийн засаг” бодлого хөтөлбөрүүдийг НҮБ-аас болон бүсийн улс орнууд хамтран хэлэлцэж гаргаж байна.

НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөрөөс “ногоон эдийн засаг”-ыг тодорхойлохдоо “Эдийн засаг болон нийгмийн сайн сайхан, ядуурлыг бууруулах гол хүчин зүйл бол эрүүл экосистем бөгөөд тэрхүү экосистем нь хүн төрөлхтний сайн сайхан, эдийн засгийн хөгжлийн үндэс суурь юм” гэжээ. Хүрээлэн буй орчны нэгээхэн хэсэгт хор хөнөөлтэй байна гэдэг нь байгаль орчны бусад юмс үзэгдэл, цаашлаад хүмүүст урьдчилж хэлэхийн аргагүй сөрөг үр дагавар үзүүлж болох юм. Байгалийн баялагийн ихэнх багассан болон шавхагдсан нөөц нь дахин сэргээгдэх боломжгүй болсон байдаг бол харин амьд организм нь сөнөж мөхөх хүртэл илүү их аюулд хүрдэгийг бид мэднэ.

1972 онд Хүн төрөлхтөний Хүрээлэн буй орчны Стокгольмын тунхаглалд “Аливаа хүн эрүүл саруул, өөрийн гэсэн байр суурь бүхий орчинд эрх чөлөөтэй, эрх тэгш амьдрах үндсэн эрхтэй” гэж хүний эрх, экологийн хоорондын салшгүй



1: Хүрээлэн буй орчинтой холбоотой ХЭ-ийн дагавар зохих гэрээ хэлэлцээрүүд

Дэлхийн улс орнууд гэлтгүй бүсүүдийн түвшинд хүний эрхийг хүрээлэн буй орчин хоорондын хамаарлыг холбогдох гэрээгээр зохицуулж баталгаажуулдаг. Жишээ нь, Африкийн Хүний Эрхийн Дүрэм, Европын хүний эрхийн Конвенц, Америкийн Хүний Эрхийн Конвенц, UNECE-н Мэдээлэл авах, Шийдвэр гаргалтанд оролцох, Хүрээлэн буй орчны асуудлуудын шүүхэд хандах Конвенц гэх мэт.

Олон орны хууль гаргагчид үндэсний түвшинд, эрүүл мэндийн орчин, эрүүл аюулгүй байдал, түүний хамгаалалт, экологийн эрх гэх мэт тодорхой хүрээлэн буй орчны асуудалд эрх үүсгэж Үндсэн хуульдаа оруулсан байдаг. 1970 оноос хойш зохиогдсон дэлхийн 130 гаруй Үндсэн хуульд, хүрээлэн буй орчныг хамгаалах эсвэл эрүүл, аюулгүй экологийн тэнцвэртэй нөхцөлд амьдрах эрхийг баталгаажуулсан байна.



холбоосыг тунхагласан байдаг. Олон улсын гэрээ хэлэлцээр, тогтоол тунхаглал зэрэг тодорхой хэд хэдэн бичиг баримт дээр хүний эрх болон хүрээлэн буй орчны харилцан хамаарлын талаарх ойлголтуудыг илүү тодорхой зааж өгсөн байдаг.

Одоо бий болсон хүн төрөлхтөний бүхий л эрхүүдийн зөрчлийн эх нь ихэвчлэн экологийн хямралаас үүдэлтэй тул түүнд анхаарлаа хандуулах шаардлагатай юм. Учир нь хүн төрөлхтөн амьдрах боломжтой гариг үгүй бол ирээдүйн хүн төрөлхтөний хөгжил үгүй болох билээ. Тиймээс, хүний эрхэд суурилсан эко хандлагыг нэвтрүүлэх явдал нь тогтвортой хөгжлийг дэмжих бөгөөд илүү сайн бодлого боловсруулах дүн шинжилгээний загвар арга хэрэгсэл болох юм. ХЭСХ нь нийгэм, эдийн засгийн болон экологийн шударга бус байдлын нийтлэг алдаануудад анхаарал хандуулж, түүнийг залруулахад чиглэл өгдөг.

Монгол улсын Үндсэн хууль 6.1: “Монгол улсад, газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, 16.2: “Монгол улсын иргэн нь эрүүл, аюулгүй орчинд амьдарч, орчны бохирдол болон экологийн тэнцвэр алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, 17-р зүйл: “Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн үүрэг мөн” гэж хуульчилан баталгаажуулсан нь хүний эрх, эрх чөлөөг хангах төрийн үүргээ хэрэгжүүлсэн гэж үзэх юм.

Түүнчлэн, Монголын Мянганы Хөгжлийн Зорилт (МХЗ) нь ядуурлыг бүүруулах, хүрээлэн буй орчны зөв зохистой байдлыг бий болгох, хүний эрхийг хамгаалах болон ардчилалыг хөгжүүлэх эрхзүйн боломжийг бүрдүүлсэн байна.

Хүний эрхийн баримт бичгүүд нь хоол хүнс, эрүүл мэнд, ая тухтай амьдрах орчин, ажлын нөхцөл гэх зэрэг хүний сайн сайхан амьдрах үндсэн элементүүдийн эрхүүдийг тодорхойлж өгдөг.

Хүний эрхийн тухай хууль нь байгаль орчныг хамгаалах талаар улс орнуудын хүлээх үүргийг заадаг.



2. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги-Мүүн 2012 оны 3-р сард: “НҮБ нь нийгмийн болон хүрээлэн буй орчны хамгаалалт, тэдгээрийн өсөлт хөгжилтэй холбоотой асуудлуудад анхаарч, зөв зохистой хүний хөгжлийн асуудлуудыг дэмжинэ” гэсэн ба энэхүү хуулийн үүрэг нь хамгаалалт болон боломж бололцооны тэгш байдлыг хангах зорилготой.



Эдгээр үүрэг нь:

- (а) Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээг дүгнэх, байгаль орчны мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох.
- (б) Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг хамгаалах замаар байгаль орчны талаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах.
- (в) Байгаль орчны хор хөнөөлтэй гэм хорыг арилгах, засах боломжоор хангах үүргүүдийг хүлээлгэдэг.

Улс орнуудын төр засаг нь мөн хүрээлэн буй орчны хор хөнөөлд өртөж болзошгүй бүлгүүдийн нөхцөл байдлыг тооцоолж үзэх ёстой бөгөөд хүрээлэн буй орчны хууль дүрэм журмыг хэрэгжүүлэхдээ бүлгүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах үйлдэл хийх ёсгүй. Харин тодорхой бүлгүүдийг хамгаалах нэмэлт алхамуудыг хийх ёстой.



3: Мэдээлэл авах

Мэдээлэл авах, оролцох эрх болон тэдгээрийн хүний эрх болон хүрээлэн буй орчны асуудлуудад хоёуланг нь хамаарах ойлголт юм.

Хүний эрхийн нэгдсэн тунхаглалын 19-р зүйлд: хүн бүр өөрийн хүсэл сонирхлоороо чөлөөтэй амьдрах эрхтэй;

Энэхүү эрхэнд бусдын оролцоогүйгээр өөрийн үзэл санаанд бат зогсох, мэдээлэл эрж хайж, олж авах, түүнийгээ хуваалцах, бодол санаагаа ямарваа нэгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй цацахад чөлөөтэй байна.

Мөн энэхүү эрхийг Олон улсын Иргэний болон Улс төрийн эрхийн конвенцэд тусгасан байдаг. 19(2)-р зүйлд: хүн бүр үг хэлэх эрх чөлөөтэй; Мэдээллийг эрж хайж, олж авах, түүнийгээ хуваалцах эрхтэй бөгөөд түүнийгээ хэвлэн нийтлэх, өөрийн хүссэн медиагаар цацах эрхтэй. 19(3)-р зүйлд тодорхой хэдэн хоригийг заасан байдаг бөгөөд тэдгээр нь хуулийн хүрээнд байдаг: (а) бусдын нэр хүнд болон эрхийг хүндэтгэнэ; (б) үндэсний аюулгүй байдал болон олон нийтийн хэв журмыг сахиж, олон нийтийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаална. 2011 онд Хүний эрхийн Хороо шинэ Ерөнхий Тайлбарыг гаргаж, тус хуулийн 19-р зүйлийг тодорхой нарийвчлан зааж өгсөн байдаг.

Хүний эрхийн хэрэгжилт нь хүрээлэн буй орчны хамгаалалтаас хамаарах бөгөөд хүрээлэн буй орчны хамгаалалт нь **мэдээлэл авах эрх, шийдвэр гаргахад нийтээр оролцох, шүүхэд хандах** зэрэг тодорхой эрхүүдийн хэрэгжилтээс хамаардаг³⁰. Түүнчлэн, орон нутгийн засаг захиргаа байгалийн нөөц баялагийг хариуцлагатай

³⁰ "Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах талаарх конвенц" 1998 он.



ашиглахад хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг. Хамгийн чухал нь олон нийт нутгийн хамт олон мэдээлэлтэй байх эрх нь ардчилсан үйл явц болон олон нийтийн амьдралд оролцох эрхийн чухал нөхцлийг бүрдүүлдэг. Хүрээлэн буй орчны мэдээлэлд хандах нь олон нийтийн шийдвэр гаргалтанд оролцох, төрийн болон хүвийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааг хариуцлагатай хянах нөхцлийг бий болгодог.

Олон нийтийн оролцоо нь шийдвэр гаргалтанд оролцох боломжийг олгож, улмаар экосистемд нөлөөлж буй бүхий л нөлөөллүүдийг илчлэхэд тусалдаг. ХЭСХ нь зөв зохистой хөгжлийг дэмжигч хэрэгсэл бөгөөд идэвхтэй, чөлөөт, ач холбогдол бүхий бодит оролцооны үйл ажиллагааг шаарддаг.

Хүмүүсийн иргэний болон улс төрийн эрхүүдийг бодитой эдлүүлэхэд нь экологийн мэдээлэлтэй, мэдлэгт суурилсан оролцох боломжийг бүрдүүлж, оролцооны ач холбогдлыг нэмэгдүүлж, урт хугацааны экологийн болон нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд тусалдаг.

Монгол улсын Үндсэн хуульд **иргэн бүрийн шийдвэр гаргах үйл явцад оролцох эрхийн** талаар “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” 16.9.Зүйл; “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.” 16.17. Зүйл гэж баталгаажуулсан байдаг.

Үүрэг хүлээгчдээс хариуцлага нэхэж, шаардах нь хүмүүс өөрийн эрхийг эдлэх боломж бололцоогоо ихэсгэхтүхай бөгөөд үүрэг хүлээгчдийн үүрэг хүлээх чадавхийг нэмэгдүүлэх онцгой ач холбогдолтой юм. Хүрээлэн буй орчны хамгаалалтад олон нийтийн гол гүйцэтгэх үүрэг нь шийдвэр гаргалтад оролцож, ялангуяа нөлөөлөх



4: Оролцоо болон Хариуцлага

Оролцоо болон хариуцлага тооцолт нь зөв зохистой хөгжлийн төлөө нийгмийн хөдөлгөөн, холбоодыг дайчлах ойлголт юм.

Эцсийн дүндээ, ХЭСХ-ын зорилго нь иргэдийг шийдвэр гаргахад оролцохыг уриалж хүмүүсийг “өөрийгөө дайчлах” замаар нөөц баялагийн удирдлагад оролцох эрх мэдлийг бэхжүүлдэг.

Олон нийтийн оролцоо нь хүний үндсэн эрхийн хэрэгжилтийг сайжруулах болон байгаль орчны асуудлаар шийдвэр гаргалтанд нөлөөлөх эрх мэдлийг хүчтэй болгодог. Оролцоо гэдэг нь хуулийг үр дүнтэй болгоход чухал үүрэгтэй зүйл юм.



болон бусад зөвшөөрөл олгох үйл явцад утга учиртай оролцох явдал юм. Улс орнууд нь эмэгтэйчүүд, нийгмийн эрх мэдэл багатай бүлгүүд хүрээлэн буй орчны шийдвэр гаргалтанд оролцох боломжийг тодорхойлох ёстой бөгөөд мөн хүрээлэн буй орчны хор хөнөөл нь тэдэнд хэрхэн нөлөөлж байгаад анхаарал хандуулах ёстой.

2007 оны 10 сарын 02-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар батлагдсан НҮБ-ын Уугуул Иргэдийн Эрхийн Түнхаглалын 10:18:19:27:28:29:32 дугаар зүйлүүдэд газар нутаг дээр нь явагдах хөгжлийн

төслүүд, газар, байгалийн баялагийг нь ашиглах аливаа төсөл хөтөлбөрүүдэд тухайн орон нутгийн уугуул иргэд оролцох эрхтэй бөгөөд эдгээр төсөл хөтөлбөрүүд батлагдахаас өмнө урьдчилан мэдээлэл авч, шийдвэр гаргах үйл явцад чөлөөтэй оролцох эрхийг баталгаажуулсан. Ийм төсөл, хөтөлбөрүүдэд уугуул иргэдийн зөвшөөрлийг заавал урьдчилан авч байх үүргийг төр, засагт хүлээлгэсэн. Төр засаг уугуул иргэдийн уламжлал, зан заншил, газар нутгаа эзэмших ашиглах, захиран зарцуулахтай холбоотой уламжлан тогтсон заншил, хандлагыг хүлээн зөвшөөрч, түүнийг хүндэтгэсэн шийдвэр гаргах хараат бус, шударга, ил тод нээлттэй тогтолцоог уугуул иргэдтэй хамтран бий болгож хэрэгжүүлэх үүрэгтэй гэдгийг онцлон тэмдэглэсэн байдаг.

Тэгвэл иргэний ардчилсан нийгэм гэдэг нэр томъёог хамгийн хялбараар тодорхойлвол аливаа иргэн тухайн нийгэмд нийтлэг эрх ашгийнхаа төлөө өөрийн санаачилгаар бодит үүрэг гүйцэтгэх боломж нь нээлттэй байдаг тэр нийгмийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, иргэн хүн, төрийн аппаратын шийдвэрийг зөвхөн гүйцэтгэгч объект бус, өөрөө шийдвэр гаргах, хянаж үнэлэхэд оролцогч, нөлөөлөгч субъект байна гэсэн үг. Энэ нь иргэдийн үр дүнтэй оролцоогоор илэрхийлэгдэнэ. Хүрээлэн буй орчны хор хөнөөлөөс хүний эрхийг хамгаалах төрийн үүрэг нь хүрээлэн буй орчныг бохирдуулж буй бүхий л үйл ажиллагааг зогсоохыг шаарддаг.



5: Шүүхэд хандах

Шүүхэд хандах эрхийг биелүүлэх нь хүний эрхийн зөрчлүүдийг бууруулах баталгаа болдог. Хүний эрхэд хүрээлэн буй орчны сөргөөр нөлөөлөх нөлөөллийг засах эрхийн 2 ойлголт байдаг. Энэ нь шүүхэд хандах нөгөөх нь эрхийг сэргээх ойлголт. Энэ нь бусад эрхүүдийн зөрчлийг бууруулж өгдөг. Шүүхэд хандах эрхийг баталгаажуулж өгснөөр, бусад бүх эрхүүд баталгааждаг. Энэ нь эргээд хүний эрх болон хүрээлэн буй орчны хамгаалалтыг чангатган, ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийг дэмжихэд туслах үйл ажиллагаа болдог.



Засгийн газрууд нь хүрээлэн буй орчны хамгаалалт болон эдийн засгийн хөгжил, бусад эрх зэрэг нийгмийн чухал асуудлуудын хоорондын тэнцвэрийг хангана. Хүрээлэн буй орчны стандартыг өөрийн хуулиндаа оруулсан бол тэрхүү стандартын дагуу хэрэгжүүлж, түүнд захирагдах ёстой.


ХЭСХ нь хүрээлэн буй орчны хамгаалалтын олон аргыг санал болгодог бөгөөд үүнд:



1. Нийгмийн болон хүрээлэн буй орчны уялдаа, хамаарлыг нэгтгэсэн бодлого хөтөлбөрийг бий болгох
2. Засгийн газрын болон хувийн хэвшлийн, хүний эрхийн байгууллагуудын хариуцлагатай байдал
3. Мөн илүү хүчирхэг салбар хоорондын холбоо, түншлэл хамтын ажиллагааг бий болгох арга замууд байж болно гэж үздэг.

3.2 Оролцогч талуудын хамтын ажиллагаа

Байгалийн нөөцийг хариуцлагатай ашиглах хамтын оролцооны механизм



Орон нутгийн олон талт зөвлөлийн (ОТЗ) ерөнхий зорилго нь орон нутгийн түвшний байгаль орчны хамгааллыг нэмэгдүүлэн, нөөцийн хариуцлагатай ашиглалтыг бий болгож, нутгийн иргэдийн идэвхитэй, бүтээлч оролцоог дэмжин улмаар орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах явдал юм.



Олон талт оролцогч талуудын хамтын ажиллагааны гэрээ (ОТХАГ)

Энэ нь уул уурхайн компани, орон нутгийн захиргаа мөн гол төлөв иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн орон нутгийн иргэдийн хооронд байгуулсан гурван талт хэлэлцээр юм. Энэхүү хэлэлцээрийн хамгийн чухал зорилго бол хүний эрхийг дээдлэх, уул уурхайгаас үүдсэн хүрээлэн буй орчинтой холбоотой зөрчил маргааныг саармагжуулах, сайн засаглалыг хөгжүүлэх, хувийн хэвшлийн хэвийн үйл ажиллагааг хангах, хуулийг хэрэгжүүлэх болон хяналт тавихад олон нийтийн оролцоог бий болгох болон төр, хувийн хэвшлийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд оршино.

Монгол улсын Ашигт Малтмалын тухай хуулийн 42 дүгээр зүйлд уул уурхайн лиценз эзэмшигч нь хүрээлэн буй орчныг хамгаалах, дэд бүтцийн хөгжил, ажлын байрны өсөлтийн асуудлуудаар орон нутгийн эрх баригчидтай хэрхэн хамтран ажиллах, харилцан зөвшилцөх талаар тайлбарласан байдаг.

Хүний эрх, Хүрээлэн буй орчин ба Ногоон эдийн засаг

НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөрөөс ногоон эдийн засгийг тодорхойлохдоо “Эдийн засаг болон нийгмийн сайн сайхан, ядуурлыг бууруулах гол хүчин зүйл бол эрүүл экосистем бөгөөд тэрхүү экосистем нь хүн төрөлхтний сайн сайхан, эдийн засгийн хөгжлийн үндэс суурь юм гэжээ.

Хүрээлэн буй орчныг хамгаалах болон эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа нь байгаль орчны тухай хуульд нийцсэн байх учиртай. Хүрээлэн буй орчин (агаар, ус, хөрс) болон бусад ургамал, амьтны төрөл зүйл нь харилцан хамааралтай байдаг.

Эдийн засгийн шинжлэх ухааныг нийгмийн болон эдийн засгийн даль жигүүрээс нь салгах аргагүй. Өнөөгийн эдийн засгийн загвар нь хүрээлэн буй орчин болоод хойч үеийн маань хэрэгцээнд бүрэн нийцэхгүй болсон тул дэлхий нийтээрээ “ногоон” эдийн засаг руу хамтдаа урагшлах хэрэгтэй болж байна.

Ногоон эдийн засгийг хэрэгжүүлэгч ямар ч байгууллага одоогийн болон ирээдүйн экологийн бүрэн бүтэн байдлыг хөндөлгүйгээр эдийн засгийн өнөөгийн хэрэгцээг хангах замаар эдийн засгийг илүү экологийн хувьд үр ашигтай болгох, бүх хүмүүсийн хэрэгцээг хангаж, тогтвортой байж чадах арга замаар үүнийг хийх явдал юм.





Тиймээс хүний эрх нь энэхүү нийтийн нөөц баялаг, бидний үндсэн хэрэгцээг хангахын тулд шударга хуваарилалтыг хангах өгөгдсөн стандарт, **зарчмуудыг** хамгаалахыг шаарддаг байна.



Сайн туршлага: Коста Рика улс хүний эрхээр дамжуулан хүрээлэн буй орчноо хамгаалах ажлыг бэхжүүлж байна. 1994 онд Коста Рика улс үндсэн хуулиндаа нэмэлт өөрчлөлт оруулан эрүүл, экологийн хувьд тэнцвэртэй хүрээлэн буй орчинд амьдрах эрхийг хуульчилжээ. Энэ хугацаанд хэд хэдэн үр дүн харагдсан байна. Ийнхүү энэхүү эрхийг улсынхаа хамгийн дээд түвшний хуулиндаа хуульчилснаар Коста Рика улс хүрээлэн буй орчноо хамгаалахад ихээхэн анхаарал хандуулаад зогсохгүй энэ асуудлаарх хууль эрх зүйн үндэс суурийг тавьж, Дээд шүүхийн Үндсэн хуулийн цэцээс энэ асуудлыг эрхлэхээр болжээ. Түүгээр зогсохгүй Үндсэн хуулийн цэцээс дурын хэн нэгэн хуульчгүйгээр энэ асуудлын хүрээнд ямар нэг төлбөргүйгээр, дурын хэлээрээ, хэзээ ч хамаагүй, бүр гар бичмэлээр хүртэл өргөдөл гаргаж болно хэмээн заажээ. Түүнчлэн, хүрээлэн буй орчны хамгааллын асуудлаар олон нийтийн өмнөөс өргөдөл гаргахыг зөвшөөрсөн байна. Ийнхүү үндсэн хууль, тухайлбал хүрээлэн буй орчны тухай заалтыг зөрчсөн тухай гомдол мэдүүлэхэд гардаг шат дамжлагыг багасгасан нь үнэхээр сайшаалтай бөгөөд бусад улсууд ч энэхүү сайн туршлагыг нэвтрүүлэх хэрэгтэй.

Зохистой ажил хөдөлмөр эрхлэх Хүний эрх

Ажил хөдөлмөр нь иргэдийн сайн сайхан аж байдлын гол цөм нь юм.

Зохистой ажлын ойлголт, үзэл баримтлалыг ОУХБ-ын бүрэлдэхүүн - засгийн газар, ажил олгогчид, ажилчид боловсруулсан байна. Ажил нь хувь хүний нэр төр, гэр бүлийн тогтвортой байдал, олон нийтийн амар амгалан, ардчилал, үр бүтээмжтэй ажлын байр, аж ахуйн нэгжийн хөгжих боломжийг нэмэгдүүлэх эдийн засгийн өсөлтийн эх үүсвэр болно гэсэн ойлголт дээр үндэслэсэн байдаг.

Зохистой ажил нь олон улсын системийн болон улс орны нийгэм, эдийн засаг, үлс төрийн хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийг тусгасан байна.

Бүтээлч хөдөлмөр эрхлэлт, зохистой ажил нь шударга даяаршилд хүрэх, ядуурлыг бууруулах, тэгш хүртээмжтэй, тогтвортой хөгжилд хүрэх түлхүүр юм.



Ажлын байр бий болгох: Хөрөнгө оруулалт хийх, бизнес эрхлэх, үр чадварыг хөгжүүлэх, тогтвортой амьжиргааны боломжуудыг бий болгох.

Ажлын байрны эрхийг баталгаажуулах: Ажилчдын эрхийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, ялангуяа эмзэг бүлгийн сонирхол, эрх ашгийг хамгаалах, хуулийн хэрэгжилтэд тэдний оролцоог төлөөлүүлэх шаардалагатай.



Зохистой ажлын **үндсэн зорилго** нь үндэсний болон орон нутгийн түвшинд **ард түмний амьдралд эерэг өөрчлөлт хийх** явдал юм.

Жендерийн эрх тэгш байдал



“Жендэр” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг ойлгоно.

Жендерийн эрх тэгш байдал гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлдэг³¹.



“Жендэрийн ялгаварлан гадуурхалт” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

“Жендэрт суурилсан хүчирхийлэл” гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчим, бодлого

Жендэрийн эрх тэгш байдал дараахь үндсэн зарчимд тулгуурлана. Үүнд:

- **Жендэрийн тэгш эрхийн зарчим:** эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялагаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөлийг хангах;
- **Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим:** эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх;

³¹ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиас





- **Төрийн хариуцлагын зарчим:** төр эрэгтэй, эмэгтэй хүний эрх тэгш байдлыг хангах талаар Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжоор ногдуулсан үүргээ биелүүлэх, түүний үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх;
- **Жендэрийн мэдрэмжтэй бодлогын зарчим:** хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөлд жендэрийн үзэл баримтлалыг тусгах замаар хөгжлийн бодлогыг жендэрийн агуулгатай болгох;
- **Жендэрийн мэдээлэл хүртээмжтэй байх зарчим:** хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангах.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого нь эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг хангах нөхцөлийг бүрдүүлэх, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, түүнийг арилгахад чиглэнэ.

Жендэрийн дүн шинжилгээ гэж бодлого, үйл ажиллагаа нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хэрэгцээнд суурилсан, тэдний оролцох, үр ашиг хүртэх тэгш боломжийг хангаж байгаа эсэхийг үнэлэн судалж, анхаарч тооцох үйл явц юм.

Жендэрийн мэдрэмж гэж эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг, хөгжилд оролцох, түүний үр шимээс хүртэхэд нь хязгаарлалт болж буй хүчин зүйлсийг анхаарч тооцох хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадвар юм.

Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах (Gender mainstreaming) гэдэг нь бүх хүрээ, бүх түвшний аливаа бодлого, үйл ажиллагааны, түүний дотор хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн эмэгтэй эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд ялгаатай нөлөөлөх байдлыг анхааран тооцох, тэдний хэрэгцээ болон мэдлэг түршлагыг эн тэнцүү үнэлж, анхаарах үйл явц, стратеги юм.

Жендэрийн үр нөлөөний үнэлгээ гэж бодлого, үйл ажиллагаа нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй эмэгтэй хүмүүст хэрхэн ялгаатай нөлөөлж байгааг судлан шинжилж, сөрөг нөлөөг арилгах арга замыг тодорхойлох арга юм. Жендэрийн дүн шинжилгээнээс ялгаатай нь бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны богино болон урт хугацаанд илрэх үр нөлөөг олон талын, түүний дотор уг нөлөөнд өртөж буй хүмүүсийн оролцоотой хийвэл үр дүнтэй.



БҮЛЭГ

4

УЛС ОРНУУДАД ХҮНИЙ ЭРХИЙН ХАРИУЦЛАГА
ХҮЛЭЭЛГЭХ МЕХАНИЗМУУД





4.1. Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)

НҮБ нь 1945 онд үндэс сууриа тавьсан анхны, дэлхий нийтийн, улс төрийн нэгдмэл байгууллага бөгөөд дүрмийнхээ 26 дугаар зүйлд хүн төрөлхтний үндсэн эрх, хувь хүний эрхэм чанар, хүн байхын үнэ цэнийг хөхиүлэн дэмжих явдал хэмээн зорилгоо тодорхойлсон юм. Улс орнууд өөрийн бүрэн эрхт байдал, улс орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх зарчимтай хэдий ч өөрийн орны иргэдтэй хүссэнээрээ харьцаж болно гэсэн ойлголт, үйлдэл хэрхэвч гаргахгүй гэдгийг улс орнууд хүлээн зөвшөөрсөн явдал юм.



НҮБ-ын дүрмийн эхлэл хэсэгт “арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэгээр үл ялган хүний эрх, хэн бүхний үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмжих, хөгжүүлэх” (1 дүгээр зүйл 2 дахь хэсэг) явдал хэмээн тодорхой заасан байдаг.

Энэхүү зорилгод чиглэсэн эхний алхам бол 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ) юм. Эрх чөлөө, тэгш байдлын сонгодог эрхүүд болон тэдгээрийг хэрэгжүүлэх баталгааг тусгасан (8,10, 11 дүгээр зүйл); нийгмийн хамгааллын эрх (22 дугаар зүйл); хөдөлмөрлөх эрх (23 дугаар зүйл) зэрэг олон тооны нийгмийн үндсэн эрхийг агуулдаг. Мөн 29 дүгээр зүйлд хүн бүрийн амьдран буй нийгмийнхээ өмнө хүлээх үүрэг хариуцлагыг тусгаж өгсөн байдаг.

4.2 Хүний эрхийн тухай олон улсын гэрээ

Хүний эрхийн тухай олон улсын гэрээ бол улс хооронд хийгддэг заавал дагаж биелүүлэх хуулийн дагуух гэрээ байдаг ба тэр нь улс орнуудад өөрсдийн хуульд захирагдах хувь хүмүүс (иргэд болон бусад)-ийн талаарх хоёр талын дагаж мөрдөх үүрэг хариуцлагыг оноодог. Гэрээг заримдаа “пакт” эсвэл “конвенц” гэж нэрлэх тохиолдол байдаг, гэвч нэрнээсээ үл хамааран тэдгээрийн хууль зүйн статус адил юм.

Зарим нэг тохиолдолд бүс нутаг, ОУ-ын хамтын хэлэлцээрээр тунхаглал, санамж бичиг зэрэг нөлөө бүхий боловч заавал биелүүлнэ гэж хуульчлаагүй баримт бичгүүд үйлдэгддэг. Энэ нь зарим тохиолдолд “зөөлөн хууль” гэгдэх нь бий. Гэвч олон улсын бусад гэрээнээс ялгаж ойлгохын тулд зарим тохиолдолд “зөөлөн” хуулийн стандартууд хуулиар заавал дагаж биелүүлэх ёстой “хатуу” хууль болон өөрчлөгдөж болно.





4.3 Хүний эрхийн хяналтын байгууллагууд

НҮБ-аас гаргасан гэрээ бүрийн заалтыг Засгийн газрууд хэрхэн хэрэгжүүлж буйг хянах “мэргэжилтнүүдийн хороо” байгуулагдсан байдаг ба мөн “тусгай илтгэгчид” томилогдсон байдаг. Хороо бүр өөрийн гэсэн дүрэм, процедуртай ба хамгийн гол нь тэд улс орнуудыг гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж буйг онцолсон тогтмол тайлан гаргаж өгөхийг шаарддаг. Эдгээрийг хороо хянаж үзээд тухайн улс гэрээг хэрэгжүүлэхдээ юуг сайжруулах талаар зөвлөмж өгдөг.

Энэхүү процедурын үеэр хороо ТББ-ууд гэх мэт сонирхогч талуудын санал бодол, дүгнэлтийг анхаарч үздэг ба энэ нь ихэнхдээ ТББ-уудын хувьд хөгжилд нөлөөлөх маш сайн арга зам болдог. Зарим хороод мөн хүний эрх зөрчигдсөн хэргүүд дээр газар дээр нь очиж тусгайлан шалгалт явуулах процедур ч байдаг.

Эдгээр хороод нь гэрээний заалтуудыг тайлбарлах, тодорхой болгох үүднээс ерөнхий тайлбарыг гаргадаг. Эдгээр тайлбар нь нэлээд нарийвчилсан шинжтэй байдаг ба заримдаа гэрээний нэг бүлэг дээр анхаарсан байх нь ч бий. Хэдийгээр тайлбар нь хуулиар заавал дагаж мөрдөх шинж чанаргүй ч тэдний нөлөө хүчтэй юм. Тиймээс тэдгээр нь үр дүнтэйгээр хянах болон зөвлөх хүрээ болдог, мөн стандарт зарчмуудын жишиг болдог.

Тухайлбал ЭЗНСЭТОУП-ын илтгэлийг улс бүр таван жил тутам илгээдэг бол ИБУТЭТОУП-ын тайлангаа зургаан жил тутамд нэг удаа илгээдэг. Тус илтгэл тайлантай зэрэгцээ буюу заримдаа сүүдэр илтгэл гэж нэрлэдэг ИНБ-ын хөндлөнгийн илтгэл тайлан хүргэх механизм байдаг.

4.4 Гарын үсэг, баталгаажуулалт ба нэмэлт тайлбар

Гэрээнд гарын үсэг зурна гэдэг нь түүний агуулгыг дагаж биелүүлнэ гэсэн анхны алхам юм. Хүний эрхийн конвенцийг зөвшөөрсний дараа тухайн Улс хариуцагч буюу “үүрэг хүлээгч” болж конвенциор заагдсан үүрэг хариуцлагыг хуулийн дагуу биелүүлэх үүрэг хүлээнэ.

Үүрэг хүлээгч Засгийн газрууд конвенцид заасан үүргээ биелүүлэхийн тулд төр юу хийх ёстой болон юу хийх ёсгүйг гэрээ, конвенцид заасан байдаг. Үүрэг хүлээгч Засгийн газрууд гэрээ, конвенци эсвэл протоколд заасан хүний эрхийн стандартыг биелүүлэхийн тулд өөрсдийн дотоодын хуулинд гэрээгээр хүлээсэн үүргийг багтаан хуульчлах, нийтэд таниулж сурталчлах, хэрэгжүүлэх, нөөц чадавхийг бий болгох үүрэгтэй болдог.



Засгийн газрууд гарын үсэг зурахдаа зарим тодорхой нэмэлт тайлбарыг оруулдаг. Тэр нь тухайн улс гэрээнд байхгүй тодорхой болзлыг тэмдэглэдэг ба энэ нь өөрийгөө хуулиар хариуцлага хүлээсэн гэж үздэггүй. Тайлбарыг зөвхөн гарын үсэг зурах үедээ оруулдаг ба түүнээс хойш оруулах боломжгүй байдаг.

4.5 НҮБ-ын хүний эрхийн хяналтын бүтэц болон хүний эрхийн зөвлөл

Хүний эрхийн зөвлөл нь Хүний эрхийн Комиссын оронд 2006 оны зургадугаар сард байгуулагдсан. Шинэ Хүний эрхийн зөвлөл нь бүс нутгуудад хуваарилсан 47 хүний суудалтай, шатласан байдлаар гурван жил тутамд сонгогддог.



Хүний эрхийн зөвлөлийн үйл ажиллагааны төв нь НҮБ-ын ээлжит төлөвлөгөөт хяналт юм. Энэхүү үйл явц нь НҮБ-ын гишүүн орнуудын хүний эрхийг биелүүлэх үүргийн хэрэгжилтийн төлөв байдлыг дөрвөн жил тутамд нэг удаа хянах механизм юм. Хүний эрхийн зөвлөлийн гишүүдийн боловсруулсан тайланд өгсөн зөвлөмжийн дагуу улс бүр хариу өгнө. ТББ-ууд, Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь энэхүү үйл явцын гол оролцогчид юм.

Хүний Эрхийн Зөвлөлийн өөр нэг тусгай журам нь Тусгай илтгэгчдийн хийх хяналт бөгөөд энэ нь тодорхой нэг сэдэв эсвэл улс орныг судлах, хүний эрхийн асуудлаар хэрэгжилтийг үзэж тайлагнах үүрэгтэй “ажлын бүлэг” юм. Эдгээрт эрүүдэн шүүх, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, аюултай уламжлалт зан заншил зэрэг орно. Тусгай илтгэгчид нь ерөнхийдөө өөрсдийн салбартаа манлайлагч мэргэжилтнүүд байх ба тэдний бие даасан байдлыг хангах зорилгоор тэдэнд цалин олгодоггүй. Монгол улсад 2005 оноос хойш НҮБ-ын гурван тусгай илтгэгч ирж ажилласан байна.



2004 онд Хоол хүнсээр хангагдах эрхийн асуудлаар НҮБ-ын тусгай илтгэгч Жан Зиглер ажиллаж тайланг гаргасан ба 11 зүйл зөвлөмж, 2005 онд Эрүүдэн шүүлтийн асуудлаар НҮБ-ын тусгай илтгэгч Манфред Новак ажиллаж 8 зүйл зөвлөмж өгсөн бол 2009 онд Сурч боловсрох эрхийн асуудлаар Вернор муноз Виллалбос ирж ажиллан Засгийн газарт гэлтггүй Монгол Улс дахь ОУ-ын байгууллагад хандаж 12 зүйл зөвлөмжийг гаргасан байдаг.³²

³² Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар Монгол улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос МУ-ын Засгийн газар өгсөн зөвлөмжийн эмхтгэл. 2-р боть. 489-546-р тал. 2012 он ХЭҮК



Мөн Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар (ХЭДКГ) гэж байдаг. Хүний эрхийн дээд комиссар нь улс төрийн байгууллага бөгөөд Хүний эрхийн зөвлөлөөс ялгаатай нь НҮБ-ын албан ёсны байгууллага бөгөөд НҮБ-ын нарийн бичгийн даргын нэг харьяа хэсэг юм. ХЭДКГ нь хүний эрхийг хамгаалах, дэмжих үүрэгтэй бөгөөд хамгийн чухал нь НҮБ-ын бүх байгууллагуудыг холбон хүний эрхийн чиглэлээр ажилладаг.

НҮБ-ын байгууллагууд нь бодлого, хөтөлбөртөө эрхэд суурилсан хандлага, арга зүйг илүү тууштай дэмжихэд гол үүрэг гүйцэтгэж үүнд гол анхаарлаа чиглүүлж байна.

4.6 Бүс нутгийн хүний эрхийн арга хэрэгсэлүүд

Хүний эрхийн байгууллагууд бүс нутагт хуваагддаг ба өөр өөрийн онцлогтой. Үүнд:

1. Европ дундын хүний эрхийн тогтолцоо
2. Америк дундын хүний эрхийн тогтолцоо
3. Африк дундын тогтолцооны талаар танилцуулъя.



Европын Зөвлөл (ЕЗ) эдгээрээс хамгийн эртнийх нь бөгөөд 1950 онд Хүний эрх, үндсэн эрх чөлөөний тухай Европын конвенци (ХЭҮЭЧ) баталж, НҮБ-ын үндсэн хоёр гэрээний суурь эхлэлийг тавьсан гэж үздэг. ЕЗ нь хүний эрхийн европын шүүх буюу хамгийн боловсронгуй шүүхийн системтэй ба хууль цаазын өргөн цар хүрээтэй байгууллага гэдгээрээ дэлхийн жишиг загвар болж байдаг юм. Европын шүүх, хүний эрхийн хувьслын онолын шинж чанартай зарчмыг бий болгоход гол үүрэг гүйцэтгэсэн бөгөөд ХЭҮЭЧ нь «амьд хэрэглүүр»-ийн хувьд нийгмийн хэм хэмжээ, чиг хандлагын загвар болж хөгжиж байна.

Америк дундын систем нь дэлхийн хоёрдугаар дайны хор үршгийн дараа 1948 онд Америкийн хүний эрхийн тунхаглалыг баталснаар эхэлсэн түүхтэй. Хүний эрхийн америкийн конвенцийг хэрэгжүүлэх шаардлагын үүднээс америк дундын хороо 1969 байгуулагдсан ба 1979 онд америк дундын шүүх байгуулагдсан байна. Энэхүү системийн хамгийн амжилттай хэрэгжүүлж буй үйлчилгээ нь хороо улс орнуудад айлчлан хүний эрхийн зөрчлийг шалгадаг үйл ажиллагаа юм. Хорооны 1979 онд гаргасан Аргентиний талаарх тайлан бол цэргийн дэглэмтэй улсуудын “алга болсон” хүмүүсийн талаарх системчилсэн бодлогыг дэлхий дахинд ил болгосон томоохон байр суурь бүхий тайлан болж чадсан амжилт юм.

Хүн төрөлхтөн болон хүний эрхийн төлөөх Африкийн хороо нь шүүхийн дүрэмд хүмүүсийн эрх болон хувь хүний эрхийг нарийн оруулсан. Энэхүү дүрэмд хүний



эрхийн хувирал өөрчлөлтийг зааж өгсөн. Хүний эрхийн гэрээнүүд салшгүй болон хувиршгүй чанартай үүсгэгдсэн, гэвч маш олон гэрээ нь тухайн хийгдсэн цаг үеийнхээ асуудлыг хамруулдаг гэдэг үтгаар байнга шинэчлэн сэргээж өргөжүүлж байх шаардлага үүсгэдэг. Жишээлбэл, Африкийн дүрмэнд анх удаа “хүрээлэн буй орчны эрх” болон “хөгжих эрх” гэдгийг тусгайлан оруулж өгсөн нь шинэ үзэл баримтлал, жишиг бүхий бодлого болсон.

Азид бүс нутгийн хүний эрхийн шүүх гэж байхгүй. Бүс нутгийн түвшинд хүний эрхийн асуудалд хандах хандлагын “Азийн үнэ цэнэ” нь өргөн хүрээний шүүх тогтолцоонд гарч буй дэвшлийг хойшлуулахад нөлөөлж буй том хүчин зүйл болж байна. Хэдий тийм ч зүүн өмнөд азийн холбоо АСЕАН³³-ы гишүүн арван орны удирдагч нар АСЕАН-ы хүний эрхийн байгууллагыг 2009 онд байгуулж, гарын үсэг зурсан зэрэг зарим нэг дэвшил гарч байна. 2010 оны 3 болон 4 сард Жакарта-д АСЕАН-ы Засгийн газар хоорондын хүний эрхийн хороо (АЗГХХЭХ)-ны анхны албан ёсны хурал зохион байгуулсан нь ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Энэ мэтчилэн хүний эрх түгээмэл төдийгүй аливаа нэг улсын хэрэг биш гэдгийг нотолж бүс нутгийн хэмжээг хамарсан хүний эрхийн өргөн суурьтай хамтын тогтолцоо бий болсоор байна.

Монгол улсад 2008 онд Зүүн өмнөд Азийн орнуудын Хүний эрхийг хамгаалагчдын бүсийн хурал амжилттай болж Нүхтийн тунхаглалыг гаргасан байдаг.

4.7 Хөгжлийн албан ёсны зээл тусламж (ХАЁТ)-ийн хүний эрх, эрх чөлөөг хангах олон улсын эв санааны зарчим

ОУ-ын түвшинд хөгжингүй орнууд нь хөгжиж буй болон буурай улс орнуудад хөгжлийн тусламж, зээл, техникийн туслалцаа үзүүлдэг. Харин ХАЁТ-ын үр өгөөжийг сайжруулах зорилготой Дэлхийн дээд хэмжээний чуулган 2003 оноос эхлэн гурван ч удаа болсон. 2005 оны хоёр дахь удаагийн чуулганаар 2010 он хүртэл зээл тусламжийн үр өгөөжийг сайжруулах тодорхой зорилтуудыг тавьсан Парисын тунхаглал гэдэг баримт бичгийг боловсруулан баталж түүний хэрэгжилтийг 3 удаа үнэлээд байна. Манай улсын Засгийн газар энэ үйл ажиллагаанд оролцож байгаа билээ.

³³ АСЕАН-ын зорилго: Бүс нутагт эдийн засаг, нийгэм, соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэх, нийгмийн дэвшил, эдийн засгийн түргэн өсөлт, аж үйлдвэр, тээвэр, худалдааны салбар дахь хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэх, бүсийн энх тайван аюулгүй байдлыг бэхжүүлэх, нийт орнуудын ашиг сонирхлын үүднээс хамтын ажиллагаа худалдааг хөгжүүлэх явдал юм.





2008 онд Гана улсын Аккра хотод болсон гурав дахь удаагийн дээд хэмжээний чуулганаар Парисын тунхаглалын хэрэгжилтийг хурдасгах, гүнзгийрүүлэх зорилгоор хөгжиж буй орнуудын Засгийн газрууд болон хандивлагч орнууд Аккрагийн Үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан.

2012 онд “Үр дүнтэй хөгжлийн хамтын ажиллагааны талаархи Пусаны түншлэлийн гэрээ” -нд засгийн газрууд бусад хөгжлийн оролцогчид гарын үсэг зурж хөгжлийн оролцогчдыг төр – хандивлагчид - ИНБ-аас гадна анх удаа хувийн хэвшлийн салбарыг хөгжлийн оролцогч гэж хүлээн зөвшөөрч тэдгээрийн тус бүрийн мөрдөх тодорхой үүрэг хариуцлагыг боловсруулсан.

Нийгмийн бүх тулгамдсан асуудлыг ХАЁТ-аар шийдэх боломжгүй боловч түүнийг хөгжлийн бодитой үр дүнд хүрэхэд түлхэц болох ёстой гэж үздэг. Тухайлбал, ядуурлыг бууруулах, жендерийн тэгш байдал, байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хангахад маш тодорхой, хэмжиж болохуйц ахиц гаргасан өөрчлөлтүүдийг хийхэд нөлөөлөх ёстой гэж хүлээж байна. Бүр тодруулбал, хүмүүсийн амжиргааг сайжруулах, ядуурлыг бууруулах, ялгаварлал тэгш бус байдлыг арилгах, ядуурлын суурь шалтгаан түүнийг ХЭСХ-аар буюу ардчилсан аргаар шийдвэрлэх, улмаар тогтвортой эерэг өөрчлөлтүүд гарсан байх ёстой гэж тодорхойлсон.

Монгол улсын Засгийн газар 1991 оноос хойш хандивлагч орон, олон улсын байгууллагуудаас 8 тэрбум гаруй төгрөгийн хөгжлийн албан ёсны тусламж авсан байна³⁴. Үүний 54 хувь нь зээл бөгөөд манай улсын нэг хүнд оногдох өрийн хэмжээ 2013 оны эцэст 5000 долларт хүрчээ. Засгийн газар эдгээр зээлийг төсвийн алдагдлыг нөхөх, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, дотоодод дамжуулан зээлдүүлэх, өр төлөх зорилгоор авч ашиглаж байна.

Энэхүү ХАЁТ нь ОУ-ын зарчмын дагуу хөгжлийг дэмжих нэг хэрэгсэл байх ёстой бөгөөд түүний үр нөлөөг нэмэгдүүлэхэд Төр төдийгүй хандивлагч хоёулаа гол үүрэгтэй харин ИНБ болон хувийн хэвшил хөгжлийн эн тэнцүү оролцогчид байх эрхтэй төдийгүй үүрэг хүлээсэн оролцогчид болдог.

³⁴ “Зээл тусламжийн үр нөлөөг нэмэгдүүлэх нь” судалгааны тайлан. 2011 он. Хөгжлийн ажиглагч форум.



4.7.1 Парисын тунхаглал түүний зарчмууд

Парисын Тунхаглал (2005) нь зээл тусламжийн чанар, түүний хөгжилд үзүүлэх үр нөлөөг сайжруулах, түүнд оролцогч талуудыг тодорхойлж тэдгээрийн гүйцэтгэх үйл ажиллагааны чиглүүлэгч баримт бичиг болсон юм. Энэ тунхаглалд хөгжилд оролцогч талууд нь: төр - хандивлагч - иргэний нийгмийн байгууллага гэж үзсэн байдаг ба тус тунхаглалыг хэрэгжүүлэх хэд хэдэн тодорхой арга хэмжээг зааж өгч, ахиц дэвшлийг үнэлэх хяналтын тогтолцоог бий болгох, хандивлагчид болон хүлээн авагчдын хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон юм.

Парисын тунхаглал нь ХАЁТ-ийг илүү үр дүнтэй болгох дараах таван үндсэн зарчмыг тодорхойлсон. Үүнд:

- ▶ **Зарчим 1.** Хөгжиж буй орнууд нь хөгжлийн бодлого стратегия тодорхойлон хэрэгжүүлэх буюу улс орнууд ядуурлыг бүүруулах, өөрсдийн институцийг сайжруулах, авлигыг таслан зогсоох өөрийн гэсэн стратегитай байх
- ▶ **Зарчим 2.** Хандивлагч улс орнууд эдгээр зорилтуудыг тухайн хүлээн авагч орны хөгжлийн бодлогуудтай уялдуулах, тэдний институцийн тогтолцоог ашиглах, ингэхдээ хөгжлийн оролцогч бүх талуудыг нээлттэй оролцох боломжийг хангах
- ▶ **Зарчим 3.** Хандивлагчид, доноруудын бодлого үйл ажиллагаа хоорондоо илүү уялдаа холбоотой, нээлттэй байх
- ▶ **Зарчим 4.** Хөгжиж буй орнууд, хандивлагч талууд бүгд хөгжлийн үр дүнд анхаарлаа төвлөрүүлж, үр дүнг хэмжиж болохуйц механизмтай байх
- ▶ **Зарчим 5.** Хандивлагчид болон түншүүд хөгжлийн үр дүнд харилцан хариуцлага хүлээх эдгээр зарчмууд эерхэн мөрдөгдөж байгаа эсэх, мөн тухайн жилд хийгдсэн хөгжлийн зээл тусламжийн үр дүнг хөгжлийн бүх талууд болох төр, хандивлагчид, иргэний нийгэм, хувийн хэвшлийн өргөн оролцоотой тогтмол хэлэлцдэг тогтолцоог бүрдүүлэх учиртай. Манай улсын хувьд тав дахь зарчмын дагуу Хөгжлийн ажиглагч³⁵ ИН-ийн форум олон талт хэлэлцүүлгийг 2011 болон 2012 онуудад зохион байгуулсан болно.

³⁵ Хүний эрх хөгжил төв ТББ болон Хүнс Эвсэл ТББ-дээр төвлөрсөн хэсэг ТББ-ууд 2010 онд “Зээл тусламжийн үр нөлөөг нэмэгдүүлэх нь” судалгаа хийж нөлөөллийн ажлын хүрээнд 2011 онд ЕТГ, ЗГХЭГ-ийн оролцоотой олон талт хэлэлцүүлгийг Засгийн газрын ордон дахь Иргэний танхимд, 2012 онд Сангийн яамтай хамтран Сангийн яаман дээр зохион байгуулж, үндэсний олон талт хэлэлцэх механизмыг тогтмолжуулах талаар талууд нэгдсэн саналд хүрсэн.





Зээл тусламж гэдэг бол хөгжлийн хамтын ажиллагаа юм. Энэхүү хамтын ажиллагаа нь талуудын болон донорууд, олон улсын сан, иргэний нийгмийн байгууллагууд болон хувийн хэвшлийнхэн зэрэг хөгжлийн оролцогчдын чадвар, чадавхийг бүрэн ашигласан тохиолдолд илүү үр дүнтэй болох юм. Өөрөөр хэлбэл, эдгээр бүх оролцогчдыг хамааруулна гэдэг нь угтаа хөгжиж буй орныг үр дүнтэй дэмжиж байна гэсэн үг.

Бидний үйл хэрэг ядуу буурай хүмүүсийн амьдралд гарч буй ахиц өөрчлөлт, үр нөлөөгөөр хэмжигдэнэ. Дотоод болон гадаад нөөцийг хэрхэн үр ашигтай ил тод ашиглаж байгаагаар хөгжлийн үйл явцын хурдацыг тодорхойлж болно³⁶.

4.8 Швейцарь улсын олон улсын хамтын ажиллагааны зарчим



Швейцарь улсын Үндсэн хуулийн 54 дүгээр зүйлд “Швейцарь улс дэлхийн ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулж, хүний эрх, ардчилсан ёс, хүн төрөлхтөний найрамдалт оршихуй, байгалийн нөөцийг хамгаалах үйлийг хүндлэн дээдлэнэ...” хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг. Швейцарь улс нийгэмд шударга ёсыг бүрдүүлэх, шүүхийн өмнө хүн бүр эрх тэгш байх зэрэг зарчмуудыг чанд мөрддөг.

Швейцарийн олон улсын хамтын ажиллагаа нь өөрийн шийдвэрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд тодорхой зарчмуудыг тогтоосон байна. Юуны өмнө ядуурал, дэлхийн эрсдлийг үр ашигтай, тогтвортой бууруулах үүднээс түншүүд, орон нутгийн байгууллагуудтай харилцан хүндэтгэлд суурилан хамтран ажиллана гэсэн үг юм. Эдгээр зарчмууд нь:

- Бүтцийн нөхцөл байдал, хөгжлийн таатай дэлхий нийтийн бодлогыг дэмжих: Швейцарь улс хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудад шударга, хууль эрх зүйн таатай нөхцөл байдал бий болгохын тулд хүчин зүтгэл гаргаж байна. Энэ нь ус, хүнсний аюулгүй байдал, үүр амьсгал, эрүүл мэнд, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тогтвортой, дэлхийн эв санааны менежментийн асуудлууд болон ногоон эдийн засгийн өсөлтийг дэмждэг;

³⁶ Аккрагийн үйл ажиллагааны хөтөлбөр 16 болон 22-р зүйл. “Зээл Тусламжийн Үр Ашиг” Гуравдугаар Дээд Хэмжээний Форум. Гана улс, Аккра хот 2008 он



- Хамгийн их үр ашгийг хангах: Төслийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт шалгалтын бүхий л үйл явц, үр дүнд голлон анхаарч, хүмүүсийн амьдралын нөхцөл байдал, олон улсын хамтын ажиллагаанд бодитой эерэг үр нөлөө үзүүлэхэд бодитойгоор анхаардаг;
- Үнэ цэнийг нэмэгдүүлэх, ноу-хауг хөгжүүлэх, туршлагаа хуваалцах: Швейцарь улс нь их хэмжээний “ноу-хау” эзэмшиж байгаа газруудад өөрийн тусламжийг үзүүлдэг. Швейцарь улс Швейцарийн хөгжлийн агентлаг болон SECO-ийн экспертүүдийг холбооны захиргааны бусад салбарт, хувийн хэвшил аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний хүрээлэн, иргэний нийгмийн салбарт тараан байршуулдаг. Швейцарь улс хөгжиж буй орнуудын ашиг тусын тулд өөрийн мэдлэг чадлаар цэнэглэн, тэдэнтэй өөрийн туршлагаасаа хуваалцахад хичээл зүтгэл гарган ажилладаг;
- Харилцан хүндэтгэн хамтран ажиллах: Өөрийн үйл ажиллагааны хүрээнд Швейцарийн олон улсын хамтын ажиллагаа нь дэлхийн өөр соёл, шашныг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн үздэг. Өөрийн түнш улс орнуудын иргэд, байгууллага, улс төрийн хүчнүүдтэй хамтран ажиллахдаа хууль, хүний эрхийг дээдлэн хүндэтгэхэд онцгой ач холбогдол өгдөг байна. Энэхүү түншлэл нь хамтын үнэт зүйлс, зорилго, харилцааны итгэлцэл, ил тод байдалд хүрэх тэмүүлэл дээр тулгуурладаг;
- Олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах: Түнш орнуудын иргэний нийгмийн байгууллагуудын хөгжлийн оролцогч хувь нэмэр оруулагч тал гэж үзэн тэдэнтэй хамтын ажиллагаатай байх нь чухал бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үздэг;
- Сайн засаглал: Швейцарь улс төрийн яриа хэлэлцээ болон хэрэгжүүлж буй өөрийн бүхий л төсөл, хөтөлбөрүүдээрээ хүний эрх, эрх чөлөө, сайн засаглалыг дэмжин, хүндэтгэлтэй хандана. Энэ нь хууль дээдлэх ёс, ардчилсан тогтолцоо, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж болон олон нийтийн аль алиных нь хувьд шударга зохицуулалтын хүрээнд байгааг харуулж байна. Ил тод байдал, авилгал, хээл хахуульд хүлээлгэх хариуцлага нэн чухал ач холбогдолтой юм;
- Эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдал: Швейцарь улс нь ядуурлыг бууруулахад хүйсийн эрх тэгш байдлыг хангахад хүчин чармайлт гарган





ажилладаг. Эмэгтэйчүүдийн ажил, боловсрол, тэдний бие махбодийн халдашгүй байдал, эрх чөлөөнд халдах, ялгаварлан гадуурхах явдлыг буруутгадаг. Швейцарийн олон улсын хамтын ажиллагаа нь хүйсийн тэгш байдлыг хангахдаа тухайн соёл, нөхцөл, онцлогт тохирсон чиг хандлагыг баримталдаг байна.

ШХА (Швейцарийн хөгжлийн агентлаг) нь Тогтвортой хөгжлийг дэмжих зорилт тавин ажилладаг

ШХА нь гурван харилцан хамааралтай салбарууд болох байгаль орчин, эдийн засаг, нийгмийн салбарын үүлзвар дээр үйл ажиллагаагаа явуулдаг. Байгууллагын хөгжил, технологи, мэргэжлийн түршлага нь ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийг тэргүүлэх гол зорилгоо болгодог.

- Швейцарийн хөгжлийн агентлаг нь байгалийн нөөцийг тогтвортой хянах, хөгжилд эрх тэгш байдлаар оролцох чадвартай хүмүүсийг эрхийн төлөө зогсохыг дэмжин, удирдах чадвартай орон нутгийн болон бүс нутгийн улс төрийн үйл явцыг дэмждэг;
- Усны нэгдсэн менежментийн хүрээнд Швейцарийн хөгжлийн агентлаг нь хоёр гол салбарт анхаарлаа хандуулдаг болно. Үүнд: ундны ус, эрүүл ахуй (ундны ус), хүнсний үйлдвэрлэлд зориулсан ус (хэрэглээний ус);
- Швейцарийн хөгжлийн агентлаг нь Олон улсын түвшинд, жилд дунджаар 170 төсөлд 90 сая швейцарь франкийн хөрөнгө оруулалт хийдэг.

4.9 Дотоодын хууль дахь хүний эрхийн хамгаалал

Хүний эрхийн олон улсын хамгаалалт чухал хэдий ч, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үндэсний хамгаалалт хамгийн чухал бөгөөд хүний эрх зөрчигдөхөд хамгийн хурдан үр дүнтэй залруулах боломж юм. Хүний эрхийг үндэсний үндсэн хууль болон бусад хуулиар хамгаалж болно.

Хүн бүр төрсөн цагаасаа эхлээд эрх чөлөөтэй, тэгш эрхтэй, мөн салгаж үл болох жам ёсны эрхтэй байх ёстой гэсэн үзэл санаа XVII, XVIII зуунд Америк европыг дамнасан хувьсгалын явцад батлагдаж, анхны үндсэн хуулиудын үндэс болсон түүхтэй. Үүнээс хойш бусад орнууд өөрийн улсаа ардчилсан улс гэж нотлохын тулд Үндсэн хуульдаа хүний эрх, эрх чөлөөг тодорхойлсоор иржээ.



Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ хэмээн заасан байдаг. Тэдгээрээс дурьдвал:

1. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй.
2. Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй.
3. Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй гэж заасан байдаг.

Үндсэн хуульд заасан хүний эрх нь бусад хуулиас дээгүүр тавигдах бөгөөд тодорхой процедурыг дагалгүй өөрчлөлт оруулах боломжгүй юм (зарим нэг онцгой тохиолдолд бүх нийтийн санал асуулга явуулж түүний дүнгээр өөрчлөлт оруулах боломжтой байдаг).

Үндсэн хуульд дурьдагдаж орсон хүний эрх байгаа эсэхээс үл хамааран ОУ-ын хүний эрхийн гэрээний үүрэг хүлээсэн улс орнууд нь тэдгээрийг нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх, хуулийн хүрээнд хэрэгжиж болохуйц болгох үүрэг хүлээдэг төдийгүй төрийн албан хаагчид, хувийн хэвшил, олон нийтэд ОУ-ын гэрээгээр хүлээсэн үүрэг түүний тайлан болон эдгээр гэрээ, тэдгээрийн агуулга болон гэрээний байгууллагын зөвлөмж зэргийг үхуулан таниулах, түгээн сурталчлах үүргийг хүлээдэг.

Жишээлбэл: Зарим нэг улсуудын хувьд олон улсын гэрээг баталгаажуулна гэдэг нь өөрийн үндэсний хууль руу нэгтгэх ба тэр нь шүүхийн өмнө яг л үндэсний хууль мэт хэрэглэгддэг бол зарим улсуудын хувьд олон улсын хуулийг дотооддоо хэрэглэхийн тулд өөр хууль тогтоомж болгон заавал шинэ хууль боловсруулан гаргах шаардлагатай гэж үздэг.

Улс орнууд өөрсдийн шүүх засаглалын зэрэгцээ ихэвчлэн хагас шүүхийн чанартай хүний эрхийн хяналт хийх болон хэрэгжүүлэх байгууллагууд болох хүний эрхийн хүрээлэн, хүний эрхийн хороо болон Хүний эрхийн комисс байгуулдаг. Эдгээр бүтэц, байгууллагууд аль нь байлаа ч хүний эрхийн мэдлэгийг түгээх, соён гэгээрүүлэх, үзлэг шалгалт хийх зэрэг олон үүрэг гүйцэтгэдэг. Тэд хуулийг хүний эрхтэй нийцэж буйг хянаж зөвлөх, зарим тохиолдолд шаардлага, мэдэгдэл гаргаж хүний эрхийг хамгаалсан зарга үүсгэн ажилладаг.





Энэ нь манай улсын хувьд Хүний эрхийн Үндэсний Комисс юм. ХЭҮК нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах үүрэгтэй ажилладаг байгууллага юм.

1991 оны Үндэсний хүний эрхийн хүрээлэнгийн анхны олон улсын семинар дээр Парисын зарчмыг тодорхойлсон ба НҮБ-ын үндэсний ассемблей дараа нь баталсан байдаг. Парисын зарчмын дагуу Хүний эрхийн үндэсний комисс нь дараах шаардлагуудыг хангана. Үүнд:

- а) Өөрийн оронд хүний эрх зөрчигдсөн бүхий л тохиолдолд хяналт тавих.
- б) Засгийн газар, парламент болон бусад эрх бүхий байгууллагуудад тухайлсан зөрчил болон хүний эрхийн тухай олон улсын гэрээний тухай хууль, биелэлтийн талаар зөвлөгөө өгөх чадвартай байх.
- в) Бүс нутгийн болон олон улсын байгууллагуудтай холбоо тогтоох.
- г) Хүний эрхийн чиглэлээр боловсрол эзэмшүүлэх эрхтэй байх.
- д) Магадгүй хагас шүүхийн шинж чанартай байх.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь 1991 оны Парисын зарчмын шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй. Мөн ХЭҮК нь улс орны эдийн засгийг хөгжүүлэхэд хүний эрхийн нэгдмэл байдалд ач холбогдол өгөх үүрэгтэй бөгөөд, мөн Засгийн газрын бүх хэлтэс, албадын үйл ажиллагаа хүний эрхэд суурилсан байх явдлыг хангаж ажилладаг.

Ашигласан материал, эх сурвалжийн жагсаалт

1. <http://asiafoundation.org>
2. <http://www.undp.org>
3. <http://www.legalinfo.mn>
4. <http://www.parliament.mn>
5. <http://www.mfa.gov.mn>
6. <http://mn-nhrc.gov.mn>
7. <http://www.upr-mongolia.mn>
8. <http://www.chrd.mongolnet.mn>
9. <http://www.eitimongolia.mn>
10. <http://www.pwyp.mn>
11. <http://www.ikon.mn>
12. Төрийн мэдээлэл. Тусгай дугаар. 2004
13. MNS ISO 26000:2012 стандарт
14. ХЭҮК. Хүний эрхийн товч тайлбар толь. 2012
15. ХЭҮК. Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар Монгол улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос МУ-ын Засгийн газар өгсөн зөвлөмжийн эмхтгэл. 2-р боть. 2012
16. МХЗ-уудын үндэсний 5-р илтгэл. 2013
17. Үндсэн хуулийн мэдлэг. Б.Чимид. 2008
18. Азийн сан. Тогтвортой хөгжлийн загвар. 2014
19. “Монголоо ямар улс болгох, хэрхэн түүнд хүрэх вэ” Сайнхүүгийн Ганбаатар. 2014
20. “Хил хязгааргүй алхам” ТББ. “Хөдөөгийн эзгүйрэл ба хүн амын бодлого” илтгэл. Эмэгтэйчүүдийн нүдээр VIII чуулган. 2014
21. Хөгжлийн ажиглагч форум. “Зээл тусламжийн үр нөлөөг нь” судалгааны тайлан. 2011

22. ШУТИС. “Байгаль орчныг хамгаалах Монголын өв уламжлал” нийтлэл А.Өэлүн.
23. Хүний эрхэд суурилсан хандлагыг хөтөлбөрийн удирдлагын үе шатанд ашиглах нь, IHRN
24. Хүний эрхэд суурилсан хандлагыг хөтөлбөрт ашиглах нь, UNFPA. 2010
25. Хүний эрхэд суурилсан хандлагыг хөгжлийн практикт ашиглах нь: хөтөлбөрийн гол асуултууд, Швейцарийн хөгжлийн агентлаг. 2007
26. Хүний эрхэд суурилсан хандлагыг хүрээлэн буй орчин ба уур амьсгалын өөрчлөлтийн асуудалд ашиглах нь. Гарын авлага, GI-ESCR. 2014
27. Хүний эрхийн тойм, IHRN. 2013
28. Африк дахь иргэдийн газрыг баталгаажуулах болон хүний эрхийн нөөцүүд: эрх зүйн шинэчлэл болон сайн туршлагууд гарын авлага. 2014
29. Хүний эрх эмхэтгэл, Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Швейцарийн хөгжлийн агентлаг. 2014
30. www.hrbportal.org
31. www.unep.org/environmentalgovernance/Events/HumanRightsandEnvironment

